

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛИЙН УРГАМЛЫН  
ТООЛЛОГО**



**ЗАХИАЛАГЧ: ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР  
ГҮЙЦЭТГЭГЧ: ЭКО-ҮЙЛЧИЛГЭЭ ТББ**

**Улаанбаатар хот  
2018**

## ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТООЛЛОГО СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**Захиалагч:** Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар

**Гүйцэтгэгч:** Эко-Үйлчилгээ ТББ

**Судалгааны багийн гишүүд :**

С. БАТДОРЖ. Эко-Үйлчилгээ ТББ-ын захирал, багийн  
ахлагч.....

Н. БАТТОГТОХ. Ерөнхий болон Сорилын Биологийн  
Хүрээлэнгийн, Ургамлын салбарын эрдэм шинжилгээний  
ажилтан

Д. АЛТАНГЭРЭЛ .....

Б. МӨНХЖАРГАЛ.....

**Танилцсан:** Дундговь аймгийн БОАЖ гарын дарга

Н. Гантулга.....

**Улаанбаатар хот**  
**2019**

## АГУУЛГА

Оршил

Судалгааны ажлын зорилго, зорилт  
 Судалгаа хийсэн газрын онцлог  
 Судалгааны аргазүй  
 Дундговь аймагт хийгдсэн ургамалжилтын судалгааны зарим дүнгээс  
 Дундговь аймгийн ургамлын зүйлийн бүрдэл  
 Дундговь аймгийн ашигт ургамлын судалгаа

### Нэн ховор ургамал

1. Шивлээхэй зээргэнэ - *Ephedra equisetina* Bunge.
2. Алтан бэрмэг - *Limonium aureum* (L.) Hill.
3. Сөөгөн шимэрс - *Hedysarum fruticosum* Pall.
4. Сибирь ерөндгөнө - *Cynanchum thesioides* (Freyn) K. Schum.
5. Толбот бэрмэг – *Arnebia guttata* Bge.
6. Монгол догар *Caryoteris mongolica* Bunge

### Ховор ургамал

1. Одий сараана - *Lilium pumilum* Delile.
2. Потаниний цахилдаг - *Iris potaninii* Maxim.
3. Баглагар сонгино - *Allium anisopodium* Ledeb.
4. Дэлхээ сонгино - *Allium ramosum* L.
5. Үлдэн могойн идээ - *Sedum aizoon* L.
6. Ацан ажигана - *Stellaria dichotoma* L.
7. Шар шарилж - *Artemisia xanthochloa* Krasch.
8. Урал чихэр өвс- *Glycyrrhiza uralensis* Fisch.
9. Нангид зээргэнэ - *Ephedra sinica* Stapf.
10. Шивүүрт цулхир- *Agriophyllum pungens* (Vahl.) Link. ex A. Dietr

### Эндемик ургамал

1. Гурвалсан боролз - *Hippolytia trifida* (Turcz.) Tzvel.
2. Бөнжгөр шарилж - *Artemisia globosa* Krasch.
3. Клеменцийн шарилж - *Artemisia klementzae* Krasch.

### Субэндемик ургамал

1. Бунгийн цахилдаг - *Iris bungei* Maxim.
2. Эдуардын сонгино - *Allium eduardii* Stearn.
3. Хөмөл - *Allium mongolicum* Rgl.
4. Таана - *Allium polyrhizum* Turcz. ex Regel.
5. Говийн ганга - *Thymus gobicus* Czern.
6. Төлөгчдүү боролз - *Ajania achilloides* (Turcz.) Poljakov ex Grubov
7. Дэмэглэй лавай - *Asterothamnus alyssoides* (Turcz.) Novopokr.
8. Гмелиний тайжийн жинс - *Echinops gmelini* Turcz.
9. Данхар хависгана - *Scorzonera capito* Maxim.
10. Дэрэвгэр хависгана - *Scorzonera divaricata* Turcz.
11. Иконниковын хависгана - *Scorzonera ikonnikovii* Lipsch. et Krasch.

12. Бүнгийн хавраг - *Ferula bungeana* Kitag.
13. Дагуур хүж өвс - *Haplophyllum dauricum* (L.) G. Don.

**Дундговь аймагт ургадаг ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал**

1. Долгиотсон гишүүнэ- *Rheum undulatum* L.
2. Намхан гишүүнэ - *Rheum nanum* Siewers.
3. Юлдэн тарваганшийр- *Thermopsis lanceolata* R.Br.
4. Говийн ганга- *Thymus gobicus* Tschern.
5. Үмхий буржгар- *Thalictrum foetidum* L.
6. Олслиг халгай- *Urtica cannabina* L.
7. Бүнгийн цахилдаг- *Iris bungei* Maxim.
8. Цагаалин цахилдаг- *Iris lactea* Pall.
9. Нарийннавчт цахилдаг- *Iris tenuifolia* Pall.
10. Алаг цэцэгт башир- *Dianthus versicolor* Fisch.
11. Зэл зангуу- *Tribulus terrestris* L.
12. Хөмөл, монгол сонгино - *Allium mongolicum* Rgl.
13. Таана, баглагар сонгино- *Allium polyrrhizum* Turcz. Ex Rgl.
14. Сибирь хармаг- *Nitraria sibirica* Pall.
15. Шинэсэрхүү бударгана- *Salsola laricifolia* Turcz. ex Litv.
16. Баруулт бүйлс- *Amygdalus pedunculata* (Pall.) Maxim.
17. Дагуур хүж өвс- *Haplophyllum dauricum* (L.) G.Don.
18. Агь шарилж- *Artemisia frigida* Willd.
19. Ээрэм шарилж, царван- *Artemisia macrocephala* Jacquem.
20. Үсхий нохойн хэл- *Panzeria lanata* (L.) Bge.
21. Төлөгчдүү боролз- *Ajania achilleoides* (Turcz.) Poljak.
22. Үмхий шимэлдэг- *Dracocephalum foetidum* Bunge.
23. Монгол чаргай- *Cotoneaster mongolicus* Pojark.
24. Козловын сүүт өвс- *Euphorbia kozlovii* Prokh.
25. Бүнгийн яргуй- *Pulsatilla bungeana* C.A.Mey.
26. Сөөгөн боролзгоно- *Dasiphora fruticosa* (L.) Rydb.
27. Хурц салбант хонинзажлуур- *Linaria acutiloba* Fiscz. ex Reichb

Дүгнэлт

Дундговь аймгийн хэмжээнд хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд өгөх зөвлөмж

Ашигласан бүтээл

## ОРШИЛ

Монгол орон цөл, хээр, ой, нуга намаг, өндөр уулын тундр гэх мэт олон янзын экосистемээс бүрдсэн өргөн уудам нутагтай. Сибирийн тайга, Төв Азийн хээр, цөл хэмээх дэлхийн ургамлын аймгийн хоёр томоохон дэд мужийн зааг дээр оршдог. Иймээс Монгол нутагт маш өвөрмөц бөгөөд баялаг ургамлын аймаг бүрэлджээ.

Монголын гуурст ургамлын аймаг 112 овгийн 683 төрлийн 3127 орчим зүйлээс бүрдэх бөгөөд түүний 150 гаруй нь унаган, 200 орчим нь завсрыйн унаган ургамал юм (Ургамал нар 2014).

Манай ургамлын аймаг дэлхийн дулаарал, жил дараалсан ган гачиг, цөлжилт, салхи шуургатай өдрийн тоо нэмэгдэх зэрэг байгалийн сөрөг хүчин зүйлс, бэлчээрийн талхлагдтал, малын тоо толгойн хэт өсөлт, уул уурхайн олборлолт, гал түймэр, ургамлын нөөцийг эм, хүнс, тэжээлийн зориулалтаар хэт ашиглах гэх мэт хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан олон асуудалтай тулгарч байна (Нямбаяр нар 2012).

Тиймээс байгалийн ургамлыг зөв зохистой хамгаалж, ашиглахад тухайн газар нутгийн онцлог, ургамлын нөмрөг, ургамлын бүтэц, бүрэлдэхүүн, ашигт ургамлын тархац, нөөцийг зөв тогтоох нь чухал юм. Эдгээрийг илрүүлж тогтоосноор тухайн газар нутгийн ургамлын бүрэлдэхүүн, ургамлын нөөцийг зөв зохистой ашиглаж, хамгаалах арга хэмжээг тодорхойлж, цаашдын менежмент төлөвлөгөөг боловсруулах боломжтой болно.

Ялангуяа нэн ховор, ховор болон ашиглалтад хэт өртөгдөж байгаа ургамлын тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, мониторинг судалгаа хийснээр тухайн зүйл ургамлуудын үржлийн биологи, ургах экологийн онцлог, тархцын хүрээ хэвийн болоод тэлж, хумигдаж байгаа зэрэг ареалын өнөөгийн байдал болон нөхөн сэргэх чадвар, нэгж талбайгаас авах ургацын хэмжээ зэргийг мэдэж болно. Ингэснээр тухайн зүйл ургамлыг тарималжуулах, байгальд нөхөн сэргээх боломж бүрдэнэ.

Бид захиалагч байгууллагын хүсэлтээр Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Гурвансайхан, Сайнцагаан, Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн сумдын нийт нутгаар хээрийн маршрут судалгааны ажлаар явж тухайн газар нутгийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн болон зарим ашигт ургамлын тархац, нөөцийн өнөөгийн төлөв байдлын тухай анхдагч мэдээлэл цуглувулаа.

## СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ


Дундговь аймгийн нийт нутгаар хээрийн маршрут судалгааны ажлаар явж тухайн газар нутгийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн болон зарим ашигт ургамлын тархац, нөөцийн өнөөгийн төлөв байдлын тухай анхдагч мэдээлэл цуглуулах

- Дундговь аймгийн бүх сумдын нутгаар маршрут судалгаа явуулж тухайн бүс нутгийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоох
- Тухайн бүс нутагт өмнө нь хийгдсэн судалгааны мэдээ материалтай харьцуулан нийт нутгийн хэмжээнд ургамлын зүйлийн бүрэлдэхүүний анхдагч мэдээ материал бүрдүүлж нэгтгэх
- Нэн ховор, ховор, зарим зүйл ашигт ургамлын тархац, нөөцийн өнөөгийн байдлыг тогтоох
- Нэн ховор, ховор, ашигт ургамлыг зөв зохистой ашиглах, хамгаалах арга зөвлөмж боловсруулах
- Судалгааны ажлын тайлан бичиж хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх.


## СУДАЛГАА ХИЙСЭН ГАЗРЫН ОНЦЛОГ

Монгол орон цөл, хээр, ой, нуга намаг, өндөр уулын тундр гэх мэт олон янзын экосистемээс бүрдсэн өргөн уудам нутагтай. Сибирийн тайга, Төв Азийн хээр, цөл хэмээх дэлхийн ургамлын аймгийн хоёр томоохон дэд мужийн заагт дээр оршдог. Иймээс Монгол нутагт маш өвөрмөц бөгөөд баялаг ургамлын аймаг бүрэлджээ.

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог болон Дундад Халхын хээрийн тойргийн заагт (Өлзийхутаг, 1985), ургамалжлын бүс, бүслүүрийн хувьд хуурай хээр ба цөлийн хээрийн шилжилтийн бүс болох цөлжүү хээрийн дэд бүсэд (Түвшинтогтох, 2014) оршино (Зураг 1, 2).



Зураг 1. Монгол орны ургамал газарзүйн тойрог



Зураг 2. Дундговь аймгийн нутаг дэвсгэр


Манай орны нутаг дэвсгэр байгалийн 6 бүс бүслүүрт хуваагдана (Зураг 3). Дундговь аймгийн хувьд нутаг дэвсгэр нь харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-хялганат жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг. Дараах хэв шинж бүхий бүлгэмдэлтэй бэлчээр зонхилен. Үүнд:

Уулархаг нутгаар уулын цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээр зарим хэсэгтээ бор хөрстэй уулын цөлөрхөг хээр зонхилен. Хялганы-жижиг үетэнт, жижиг үетэн-алаг өвс, хялганат, хялгана-хазаар өвс, хялгана-ерхөгт, үетэнт-агът, хялгана-хазаар өвс-агът хэвшлүүд голлоно. Крыловын хялгана, дэрвээн хазаар өвс, дааган сүүл, бэрш, гичгэнэ, үлд өвс, цагаан дэмэг, дагуур хүж өвс, нангид зээргэнэ, 2-3 зүйл шарилж зэрэг 15-18 зүйл ургамалтай. Ургамлын тусгаг бүрхэц нь 30-40 хувь хүрдэг.

Тэгшивтэр тал, хөндийн хүрэн хөрстэй хээр нийт нутгийн ихэнх хэсгийг эзлэнэ. Энд харгана-үетэнт, хялгана-хазаар өвс-агът, үетэн-агът, үетэн-таанат бүлгэмдлүүд 40 хувьд хүрнэ. 100 м<sup>2</sup> талбайд 12-16 зүйл ургамалтай. Үхэр харгана, коржинскийн харгана, алтан харгана, нарийн харгана, крыловын хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, имт гичгэнэ, цагаан дэмэг, агът,.govийн ганга, цахилдаг, ортууз, арзгар согсоот, таана, хөмөл, амманы сэдэргэнэ зэрэг ургамал голлон ургана.

Цөлөрхөг хээр нь тус аймгийн өмнөт хэсгийг эзэлж байна. Монгол өвс-хазаар өвс-таанат бүлгэмдэл гол төлөөлөгч болдог. Тусгаг бүрхэц нь 20 хувь, дээрсэн толботой, 100 м<sup>2</sup>-д монгол өвс, хазаар өвс, таана, хөмөл, арзгар согсоот, торгомсог хэрээн хошуу, агът зэрэг 8-9 зүйл ургамалтай.


Дээрс, дэрст-бударганат хотгор хөндийн нь Дундговь аймгийн нийт нутгаар алаг цоог тохиолдоно. Дээрс бүхий бударгана-таанат, дэрст, дэрс-хиагт, бэлчээрийн ургамлын тусгаг бүрхэц 10-15 хувь, 100 м<sup>2</sup> талбайд 10-17 зүйл ургамалтай.



Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүр

## СУДЛАГДСАН БАЙДАЛ


Монгол орны хэмжээнд 1:1,000,000 масштабаар харуулсан зургийг ашиглав. Энэхүү зураг нь Монгол-Оросын судлаачдын агаар сансрын зураг ашиглан хийсэн сэдэвчилсэн цуврал зургийн нэг бөгөөд Байгаль орчны мэдээллийн сангаас авсан болно. Монгол орны хэмжээнд нийт 182 төрлийн ургамалжилтыг харуулсан байна. Дундговь аймгийн хэмжээнд 46 ялгаатай хэв шинж илэрсэн байгаа нь доорх зургаас харагдаж байна.



Зураг 4. Дундговь аймгийн ургамалжилтын хэв шинж

№	Таних тэмдэг	24	Улаанбударгана, бударгана оролцсон нам ургасан заг
1	Алтан харгана оролцсон хазаар өвс-хялганат ба хялгана-хазаар өвс-шарилжит	25	Улаалж-хиаг-алаг өвстэй (20%) үетэн-алаг өвст бүлгэмдэл
2	Алтан харгана оролцсон чулуурхаг хялгана-таанын боролз-хялганат (20%) бүлгэмдэл	26	Хазаар өвс, хялгана, алтан харгана оролцсон хялгана-боролзот, хялгана-шарилжит
3	Алтан харгана, бударгана оролцсон чулуурхаг шарилж-хялганат, шарилж-таана-хялганат	27	Харгана оролцсон жижиг дэгнүүлт үетэн-хялгана-шарилжит
4	Багавтар үетэнтэй харганы сондуул	28	Харгана оролцсон хялгана-жижиг дэгнүүлт үетэн-хиагт
5	Баглуур, бор бударгана, таана, алтан харгана оролцсон шарилжит, шарилж-хялганат	29	Харгана, бүйлэс оролцсон чулуурхаг хялгана шарилж-гангтай бүлгэмдэл
6	Баглуур-хялганат, баглуур-хялгана-тааанат	30	Хиаг-бударганаат (30%) ба улаалж-нишингэт (20%) дэрстэй хиагын бүлгэмдэл

7	Бударгана-загт	31	Хиаг-улалжит (20%) ба дэрс-хиаг-бударгатай (10%) хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл
8	Бүйлэс, үхэр харгана (20%) оролцсон чулуурхаг хялгана-ботууль-алаг өвстэй хялгана-хазаар өвс-алаг өвст бүлгэмдэл	32	Хиаг-хялгана-шарилжит, хиаг-хазаар өвс-шарилжит
9	Гол өсв-улалжтай (10%) нишингийн шугуй	33	Хунгаралсан элс, хавцал, тойром, ганга, ганц нэг буттай сайр, мөнх цас, мөсөн гол, хад асга зэрэг бэлчээрт тохиромжгүй газрууд
10	Дэрс-хиагт (20%) ба нэг наст бударганат (10%) зурман сүүл-үетэнт бүлгэмдэл	34	Хялгана-бор бударганат
11	Дэрс-хиагт (20%) ба шарилж-таанатай бударгана-улаанбударганат	35	Хялгана-ерхөтг бархагана, шарилж оролцсон хялгана-хазаар өвст
12	Дэрс-хиагтай (20%), дэрс-хиагт ба бударгашарилжитай (10%) цахилдаг-үетэнт бүлгэмдэл	36	Хялгана-таанат, хялгана-таана-баглуурт
13	Дэрс-шарилжит (20%), чулуурхаг хялгана-баглуурт (20%) хялгана-хазаар өвс-баглуурт бүлгэмдэл	37	Хялгана-хазаар өвст ба хялгана-хазаар өвс-шарилжит (дундговь хэсгээр харгана элбэг)
14	Ерхөг-хялгана-алаг өвст ба шарилж, хунчир оролцсон ерхөг-хялгана-алаг өвст	38	Хялгана-хазаар өвст-70%, хиаг-улалжит-20%, зурман сүүл-улалжит-10% ба дэрс-хиагт-10% бүхий хялгана-хиаг-алаг өвст хээр
15	Заг-сөөгт (40%) элсэн манханы (хотир, монгол бүйлэс) чулуурхаг баглуур-шармодот бүлгэмдэл	39	Хялгана-харганат, харгана-хялганат
16	Зурман сүүл-хиагт-70%, дэрс-хиаг-улалжит-20%, нэг настай бударганат-10% бүхий хялгана-хазаар өвс-алаг өвст нуга	40	Цульхир, нэг наст бударгана, сухай, джузгун, хотир оролцсон сөөг-загт
17	Зурман сүүлт (30%) ба нэг наст бударганат (20%) хиаг-улалжтай дэрс	41	Шарбударганат (20%) ба улаанбударганатай (20%) лууль-баглуурт бүлгэмдэл
18	Сөөг (тавилгана, бүйлэс, чаргай) оролцсон чулуурхаг биелэг-шарилж-алаг өвст	42	Шарилж-хялгана-хазаар өвст, шарилж-монгол өвс-хазаар өвст
19	Таана оролцсон хялгана-улаанбударганат, улаанбударгана-хялганат, улаанбударгана-шарилжит	43	Эх чулуулаг ил гарсан үхэр харгана (дорнод хэсгээр), бүнгийн харгана (баруун хэсгээр) оролцсон хазаар өвст, хазаар өвс- шарилжит
20	Таана, бударгана, алтан харгана оролцсон чулуурхаг хялгана-баглуурт, баглуур-хялганат	44	Эх чулуулаг ил гарсан хазаар өвс-таана-хялганат, хазаар өвс-боролз-хялганат
21	Таана, шарилж, алтан харгана оролцсон чулуурхаг хялгана-боролзот, боролз-хялганат	45	Үхэр харгана (дорнод хэсгээр), бүнгийн харгана (баруун хэсгээр) оролцсон хазаар өвс-хялганат
22	Тэжээлийн ач холбогдолгүй сөөгэн ширэнгэ	46	Үхэр харгана оролцсон шарилж-биелэг-ботуулт
23	Тэсэг оролцсон хялгана-будаганат	24	Улаанбударгана, бударгана оролцсон нам ургасан заг



Зураг 5. Дундговь аймгийн хөрсний хэв шинж

## СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Хээрийн хайгуул судалгааг Дундговь аймгийн (Зураг 4) Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил (Загийн Ус БНГ), Өлзийт, Гурван сайхан (Их газрын чулуу БНГ), Мандалговь (Сайнцагаан), Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Эрдэнэцогт, Дэрэн сумдын нутгаар явж хийж гүйцэтгэв (Зураг 4).

Ургамал бүлгэмдэл тус бүрд  $5-10\text{ m}^2$  талбай сонгон 3-5 давталттайгаар бичиглэл хийв, Ургамалын хээрийн судалгааг гүйцэтгэхдээ геоботаникийн бичиглэлийг Друдегийн /1940/ аргаар үйлдэж, бүрхэц, арвиж дараах байдлаар илэрхийлэв. Үүнд:

- Soc-sociales – тухайн зүйлийн бодгалиудын бүрхэц 90%-аас илүү
- Cop<sub>3</sub> -(copiosae)-арвин – 90-70%
- Cop<sub>2</sub> -(copiosae)-олон – 70-50%
- Cop<sub>1</sub> -(copiosae)-нэлээд олон, цөөнгүй- 50-30 %
- Sp- (sparsae) цөөн, сийрэг – 30-10%
- Sol -(solitarae) ховор- 10%
- Un-(unicum) ганц, нэгхэн тохиолдоно.

Геоботаникийн бичиглэл хийх үед дараах зарчмыг баримтална. Үүнд:

-Бичиглэл хийсэн он, сар, өдөр, бичиглэлийн дугаар

-Ургамал газарзүйн тойрог (16 тойргоос судалгаа явуулсан тойргийн нэр) (Гробов, 1982)

-Бичиглэл хийсэн аймаг, сумын нэр (засаг захиргааны аль нэгжид хамаарах)

-Орон нутгийн байрлал (тухайн аймаг, сумын төвөөс аль зүгт хэдэн км-т орших, уул, ус зэрэг газар, нутгийн нэр)

-Газрын гадаргуугийн байрлал (уул толгодын орой, бэл, энгэр, хажуу, ар, налуу, хөндий, тал, хотгор г.м.)

-Ургамлын эвшлийг зонхилогч 2-4 ургамлаар (монгол өвс-харгана-элдэвөвст цөлөрхөг хээр /*Stipa gobica*, *S. glareosa*, *Anabasis brevifolia*, *Allium polyrrhizum*, *Asparagus gobicus*, *Artemisia sp.* *Caragana leucophloea*/гэх мэт) тэмдэглэнэ (Буян-Орших, 2005).

-Ургамалжлын өнгө, нийтлэг шинж, ярус

-Ургамалжлын тусгаг бүрхэц (хувиар)

-Хөрсний шинж чанар (өнгө, бүрдэл, ангилал)

-Бичиглэл хийсэн талбай (ам метрээр:  $50 \times 50\text{ m}^2$ ,  $100 \times 100\text{ m}^2$ ,  $250 \times 250\text{ m}^2$ , ....)

-Газарзүйн байрлал (д.т.д. метр, координатыг GPS-ээр тэмдэглэнэ)

-Бичиглэлийн талбай дахь ургамлын зүйлийн нэрсийн дарааллыг бичиж ард нь тэмдэглэгээ хийнэ. Үүнд:

амьдралын ямар хэлбэртэй ургамал (мод, ȿ - сөөг, - олон наст өвслөг ургамал, ☺ - нэг наст өвслөг ургамал, ☺ - хоёр наст өвслөг ургамал г.м.)

-ургалтын буюу хөгжлийн ямар үе шатанд явааг В.В.Алехины аргаар тусгай тэмдэглээгээр (~ - ургалтын үе, Ү - цухуйц, Λ - бундуужилт, Ⓛ - цэцэглэлтийн эх, О -

цэцэглэлт,  $\subset$  - цэцэглэлтийн төгсгөл,  $+$  - үрлэлтийн эх,  $\neq$  - үрлэлт,  $\#$  - үрлэлтийн төгсгөл,  $> <$  - үрээ гүвсний дараах вегетаци г.м.) буюу тоогоор (1-ургалтын эхэн үеийг, 2-бундуйлах үеийг, 3-цэцэглэх үеийг, 4-үр боловсрох үеийг, 5-ургалтын сүүл үеийг, 6-тайван үеийг) тус тус тэмдэглэнэ (Буян-Орших, 2005).

-ургамлын өндрийн хэмжээ (см-ээр) тус тус тэмдэглэнэ.

Жишээ нь: *Rosa acicularis*

  $\subset$  +, 60-70 см, сор1

*Agropyron cristatum*

+  $\neq$ , 40-45 см, sol гэх мэт.


### Ургамлын тархац, нөөцийн тогтоох

Аливаа ургамлын тархацын талбайг гаргахгүйгээр түүний нөөцийг тогтоох боломжгүй. Ургамлын тархац, нөөцийн судалгааг ихэвчлэн хайгуулын, хааяа хагас суурин аргаар явуулна. Ургамлын тархацын судалгааг хийхэд дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

1. Хээрийн хайгуул судалгаанд явж тэмдэглэл хөтлөх, геоботаникийн бичиглэл хийж, координатыг тогтоох
2. Ургамлын хатаадасын (гербариийн) санг шүүж тэмдэглэх
3. Бусад судаачдын хээрийн хайгуул судалгааны материал (хээрийн журнал, геоботаникийн бичиглэл) болон хэвлэл нийтлэгдсэн мэдээ, материалыг шүүж тархацын тэмдэглэл хөтлөх.
4. Судалгааны материалыг нэгтгэн боловсруулах.
5. Ашигт ургамлын тархац, нөөцийн зураглал үйлдэх зэрэг болно.

Ургамлын тархац, нөөцийн судалгаагаар явж тэмдэглэл хөтлөхдөө тухайн өдөр явсан маршрут, замд тохиолдох эвшил-хэвшил болон судалгаанд авсан ургамлын тохиолдоц (үүнийг судлаач машины спидометр болон GPS-ээр байнга тэмдэглэж явна), хүмүүстэй ярилцсан аман мэдээлэл, байгаль орчин цаг уурын онцгой, сонин содон үзэгдэл, экспедицийн бие бүрэлдэхүүний тухай, геоботаникийн бүрэн ба бүрэн бус бичиглэл зэргийг тэмдэглэнэ.

Ургамлын тархцын зураг хийхдээ ойролцоо улс, аймаг, сум, суурин буюу нэг бүлгэмдэлд ургаж буй хэд хэдэн зүйл ургамлыг тэмдэглэх цэгэн тэмдэглэгээг янз бүрийн ялгаатай дүрсээр эсвэл ижил дүрстэй боловч өнгөөр ялган тэмдэглэж нэг зурагт оруулж болно.



Зураг 5. Дундговь аймгийн ургамлын хээрийн судалгааны маршрутууд

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дундад Халхын хээрийн ургамалжлын үндсэн хэвшлийн нэг бол хялгана- харганат хэвшил юм. Хялгана- харганат хээр нь Дундад Халхын хээрийн тойротг өндөрлөг тэгш тал, дов толгод бүхий нутаг, толгодын энгэр, хажуу бэлээр өргөн тархдаг.

Дундговь аймаг нь д.т.д. 1250-1700 метрийн өндөрт өргөгдсөн хойт хэсгээр Монгол Дагуурын уулын ойт хээрийн хэв шинж бага зэрэг нөлөөлсөн хээрийн хэвшил, өмнөд хэсгээр цөлөрхөг хээрийн нөлөө орсон болон зүүн, зүүн урд хэсгээр бэсрэг уулс, ухаа гүвээ толгодын ландшафттай нийтдээ тал хөндий, хотос хонхордуу газар зонхилон оршино.

Ургамалжилтын хувьд ерөнхийдөө толгодын ар хажуу хэсгээр харгана-алаг өвс ургамлын бүлгэмдэлтэй, харин тал хөндийн хэсгээр маш сийрэг алаг өвст, хотос хонхроор дэрс-хиагт, дэрс-улаажит хээрийн ургамалжил зонхилж, ихэнх хэсэг нь ургамалжлын ангиллаар хээрийн бүсийн хээр, цөлөрхөг хээрийн төлөөлөгч оролцсон бөгөөд дараах ургамалжилтын бүлгэмдэлдээ тэмдэглэгдсэн.

Тус аймгийн газар нутаг нь дараах ургамал бүлгэмдэл ургана. Үүнд:

- Дундад Халхын хуурай хээрийн бүсийн элсэрхэг хүрэн хөрсөнд ургах Крыловын хялгана, дэрвээн хазаар өвс, ботууль-жижиг дэгнүүлт үетэн- харганат болон ботууль- хялганат хээр болно (Зураг 6).



Зураг 6. Хялгана - жижиг дэгнүүлт үетэн - харганат болон

Хазаар өвс - хялганат хээр

Энэ нь хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгийн хүрэн хөрсөнд ургах харгана (алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea*) бүхий жижиг дэгнүүлт үетэн- хялгана- таанат (зүүнгарын хазаар өвс - *Cleistogenes soongarica*, клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, хөмөл - *Allium mongolicum*) эвшил зонхилон ургана.

Дундад Халхын хээрт хамаарах зарим хэсэгт.govийн бэсрэг уул толгодын хоорондох элсэрхэг хүрэн болон хар хүрэн хөрстэй газар хазаар өвс- жижиг дэгнүүлт үетэн- агът болон хялгана- агът хээр бий. Үүнд: Монголын төв хэсгийн клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, өлчир шарилж - *Artemisia frigida*, дэгнүүлт шарилж - *A. caespitosa*, алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea* оролцсон, дэрвээн хазаар өвс - *Cleistogenes squarrosa* бүхий жинхэнэ хуурай хээр оршино (Зураг 7).



Зураг 7. Хялгана- агът хээр.

Мөн Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогийн тэгш өндөрлөг, бэсрэг уулсын хайргархаг, элсэрхэг бор хөрсөнд ургах баглуур- таана- хялганат (сайрын хялгана - *Stipa glareosa*,.govийн хялгана - *S. gobica*, таана - *Allium polorrhizum*, ахар навчит баглуур - *Anabasis brevifolia*) хээр өмнөт хэсэгт зонхилен (Зураг 8).



Зураг 8. Баглуур- таана- бударганат хээр

Тус нутгийн хойноос зүүн өмнөд хэсгийг дагаж хуурай хээрийн дэгнүүлт үетэнт, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-агт хээр тааралдаж байхад, нутгийн зүүн хойт хэсэгт сайр чулуурхаг хар хүрэн, хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс- хялганат хээр, өмнөд хэсгээр говийн бор хөрстэй хялгана-хазаар өвст, хялгана-таана-баглуурт цөлөрхөг хээр илэрдэг онцлогтой.

### **ДУНДГОВЬ АЙМГИЙН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ**

Монгол орны ургамал-газарзүйн Дундад Халх, Дорноговийн тойргуудын хээрийн бүсийн тодорхой газар нутгаар буюу Дундговь аймагт судалгаа явуулсан болон урьд жилүүдийн хийсэн судалгаа ургамлын цуглуулга, бичиглэлийг харьцуулан боловсруулж 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйл ургамал бүртгэв. Энэ нь ургамлын судалгааг ургамал ургалтын үеэс хожуу хийсэнтэй холбоотой байж болох юм. Эдгээр бүртгэсэн зүйл ургамлын дотор **нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, Эндемик 3 зүйл, Субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал байв.**

Дундговийн ургамлын аймагт Нангиад зээргэнэ - *Ephedra sinica* Stapf., алтан харгана - *Caragana leucophloea* Pojark., тарваган харгана - *Caragana pygmaea* (L.) DC., бариулт Бүйлэс - *Amygdalus pedunculata* Pall. зэрэг сөөг сөөгөнцөр; гялгар дэрс - *Achnatherum splendens* (Trin.) Nevski., говийн хялгана - *Stipa gobica* Roshev., дэрвээн хазаар өвс – *Cleistogenes squarrosa* (Trin.) Keng., саман ерхөг - *Agropyron cristatum* (L.) P.B., нангиад түнгэ - *Leymus chinensis* (Trin.) Tzvel., хөмөл - *Allium mongolicum* Regel., таана - *A. polyyrrizum* Turcz. ex Rgl., цагаалин цахилдаг - *Iris lactea* Pall., олслиг халгай - *Urtica cannabina* L., шоргор лууль - *Chenopodium aristatum* L., цагаан лууль - *Ch. album* L., толгодын бударгана - *Salsola collina* Pall., маралнавчт гичгэнэ – *Potentilla tanacetifolia* Willd. ex Schlecht., ацан ажигана - *Stellaria dichotoma* L., сиверсийн шарилж – *A. sieversiana* Willd., ишгэн шарилж - *Artemisia dracunculus* L., өлчир шарилж – *A. frigida* Willd. зэрэг олон наст өвс зонхилон ургана.

№	Овог	Зүйлийн нэр	Монгол нэр	Англи нэр	Амьдралын хэлбэр	Хэрэглээ, ач холбогдол	Ургах орчин	Тархсан тойрог
1	PTERIDACEAE E.D.M.Kirchin.	<i>Chelianthes argentea</i> (S. G. Gmel.) Kunze.	Мөнгөн ойм	Silver clockfern	Олон наст өвс	тодорхойгүй	оин бүслүүрийн уулын нүцгэн энгэр хажуу, хээрийн бус дэх чулуурхаг хажуу, хад, чулууны ан цавд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Говь-Алтай
2	EPHEDRACEAE Dumort	<i>Ephedra equisetina</i> Bunge.	Шивлэхэй зээргэнэ	Mongolian ephedra	Сөөгөнцөр, нэн ховор, Монгол орны улаан номонд (2013) орсон	эмийн ургамал	уул, толгодын хад, чулуурхаг хажуу, хадны ан цавд	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
3	EPHEDRACEAE Dumort	<i>Ephedra monosperma</i> C. A. Mey	Ганц үрт зээргэнэ	One-seed ephedra	сөөгөнцөр	эмийн ургамал	уулын чулуурхаг хажуу, эргийн хайрга, хад чулуу	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай
4	EPHEDRACEAE Dumort	<i>Ephedra sinica</i> Stapf.	Нангиад зээргэнэ	Chinese ephedra	сөөгөнцөр	эмийн ургамал	уул, толгодын хад, чулуут ташлан, хуурай сайрын хөвөө ба ёроол, хагас бэхжэсэн элс	Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
5	JUNCAGINACE AE Rich.	<i>Triglochin maritima</i> L.	Марцны шил өвс	Seaside arrowgrass	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	марз, хужирсаг намаг, нуур, гол, булгийн хужирлаг эрэг, хөвөө, нугад	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
6	JUNCAGINACE AE Rich.	<i>Triglochin palustris</i> L.	Намгийн шил өвс	Marsh arrowgrass	Олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	нуур, голын чийгтэй, нам гархаг хөвөө, марзлаг нуга, давстай нуурын хайргат хөвөө	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
7	LILIACEAE Juss.	<i>Lilium pumilum</i> Delile.	Одой сараана	Low lily	олон наст өвс, ховор	эмийн болон гоёл чимэглэлийн	уулын чулуурхаг хээр, нугын хээр, Нарсан ой, ойн зах,	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь

						ургамал	хуурай элс, хайрга харгия, хад чулуунд	
8	IRIDACEAE Juss.	<i>Iris bungei</i> <b>Maxim.</b>	Бунгийн цахилдаг	Largebract iris	олон наст өвс, субэндемик	тэжээлийн болон гоёл чимэглэлийн ургамал	элсэргэг, элс- хайргатай цөлийн хээр, толгодын үйрмэг-чулуурхаг хажуу, сайрын зах, ёроолд	Хангай, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алашаа говь
9	IRIDACEAE Juss.	<i>Iris potaninii</i> <b>Maxim.</b>	Потаниний цахилдаг	Potanin's iris	олон наст өвс, ховор, субэндемик	гоёл чимэглэлийн ургамал	хээрийн бутармаг чуулут, чулуурхаг хажуу, хад чулуунд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
10	IRIDACEAE Juss.	<i>Iris tenuifolia</i> <b>Pall.</b>	Нарийн цахилдаг	Slenderleaf iris	олон наст өвс	эмийн болон гоёл чимэглэлийн ургамал	элсэргэг, элс хайргатай цөлийн хээрт	Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
11	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium</i> <i>bidentatum</i> <b>Fisch. ex</b> <b>Prokh.</b>	Шүдлэг сонгино	Two-teeth onion	олон наст өвс	хүнсний болон тэжээлийн ургамал	хуурай хээр, уулын сайрга, чуулут хажуу, хад чулуу, голын хайрга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь
12	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium</i> <i>anisopodium</i> <b>Ledeb.</b>	Баглагар сонгино	Dwarf onion	олон наст өвс, ховор	эмийн, хүнсний болон тэжээлийн ургамал	уулын хээрийн чуулут, хадат ташлан, голын хайрга	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
13	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium</i> <i>eduardii</i> <b>Stearn.</b>	Эдуардын сонгино	Edward onion	олон наст өвс, субэндемик	хүнсний болон тэжээлийн ургамал	хад асга, чулуурхаг ба бутармаг чулуутай хуурай хажууд	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
14	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium</i> <i>leucocephalu</i> <b>m Turcz. ex</b> <b>Ledeb.</b>	Сарвуун сонгино	White onion	олон наст өвс	хүнсний болон тэжээлийн ургамал	элсэргэг хээр, уулын чулуурхаг хажууд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь

15	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium mongolicum</i> Rgl.	Хөмөл	Mongolian onion	олон наст өвс, субэндемик	хүнсний болон тэжээлийн ургамал	хайрга чулуут, элсэрхэг целийн хээр, уулын бэл, сайрга чулуут цөл, уул толгодын чулуурхаг, хадат ташлан, Заган ой	Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
16	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium polyrhizum</i> Turcz. ex Regel.	Таана	Alkali onion	олон наст өвс, субэндемик	хүнсний болон тэжээлийн ургамал	уул толгодын хормой, сайрчулуурхаг хажуу, хуурай марз, уулын дунд хэсэг хүртлэх хад, хайрга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь
17	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium ramosum</i> L.	Дэлхээ сонгино	Field onion	олон наст өвс, ховор	эмийн, хүнсний болон тэжээлийн ургамал	уулын ойт хээрийн чулуут толгод, уулын чулуурхаг хажуу, хуурай болон хужирлаг нуга, голын хайрга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
18	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium prostratum</i> Trev.	Дэлхээ сонгино	Prostrate onion	олон наст өвс	эмийн болон хүнсний, тэжээлийн ургамал	хээрийн сайрга, чулуурхаг хажуу, хайрга, марзлаг хээрийн нугад	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
19	AMARYLLIDA CEAE J.St.-Hil.	<i>Allium tenuissimum</i> L.	Турихан сонгино	Thinleaf onion	олон наст өвс	хүнсний болон тэжээлийн ургамал	уул толгодын сайрга, чулуут хажуу, хад чулуунд	Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
20	ASPARAGACE AE Juss.	<i>Asparagus dauricus</i> Fisch. Ex Link.	Дагуур хэрээн нүд	Dahurian asparagus	заримдаг сөөгөнцөр	эмийн болон тэжээлийн ургамал	элсэрхэг хээр, хуурай нугын ба хээржүү хажууд, Нарсан ойн зах, сөөгөн ширэнгэ	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь
21	ASPARAGACE AE Juss.	<i>Asparagus gobicus</i> Ivanova ex Grubov.	Говийн хэрээн нүд	Gobian asparagus	заримдаг сөөгөнцөр	эмийн болон тэжээлийн ургамал	элсэрхэг, шавранцар-элсэрхэг целийн хээр, цөлийн элсэрхэг-сайргат толгодын хажуу, асга	Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь

							болон сайрын хөвөө	
22	ASPARAGACEAE AE Juss.	<i>Polygonatum sibiricum</i> <i>Delarocche.</i>	Сибирь мухар цагаан	Siberian Solomon's seal	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	уулын энгэрийн чuluурхаг хажуу, хад чuluу, хээрийн сөөгөн ширэнгэ, элс, Нарсан ойд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь
23	JUNCACEAE Juss.	<i>Juncus bufonius</i> L.	Мэлхийн гол өвс	Toad rush	нэг наст өвс	тодорхойгүй	голын шаварлаг, элсэрхэг эрэг, хайрганд, намгархаг хужирлаг нуга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь- Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
24	CYPERACEAE Juss.	<i>Carex duriuscula</i> C.A.Mey.	Ширэг улалж	Needleleaf sedge	олон наст өвс	тэжээлийн ургамал	хээр, цэлийн хээр, нуга, гол горхины мараалаг эргээр, уулын чuluурхаг сайргат ташлан	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь- Алтай, Зүүнгарын говь, Алашаа говь
25	CYPERACEAE Juss.	<i>Carex korshinskyi</i> Kom.	Коржинский н улалж	Yellowpos ket sedge	олон наст өвс	тэжээлийн ургамал	Өндөр уулын бүслүүр хүргэлх хад асга, хээрийн сайрга, чuluут ташлан, манхан элс	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай
26	CYPERACEAE Juss.	<i>Carex stenophylloides</i> (V. Krecz.) T.V.Egorova	Утсан навчит улалж	Narrowleaf sedge	олон наст өвс	тэжээлийн ургамал	цэлийн хээр, уулын хээр, бэхжсэн элс, нам хотсын мараалаг нуга, суваг шуудууны зах, голын хөндий, голын сайр	Хангай, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
27	POACEAE Barnhart.	<i>Agropyron cristatum</i> (L.) Gaertner.	Саман ерхөг	Crested wheatgrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	хээр, уулын хээрийн хайрга, чuluут ташлан, цөлжүү хээр, хад	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь- Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
28	POACEAE Barnhart.	<i>Agropyron desertorum</i> (Fisch. ex)	Цэлийн хиаг	Desert wheatgrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	шаварлаг ба чuluурхаг хээрт	Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь

		<b>Link.) Schult.</b>						
29	POACEAE Barnhart.	<i>Agropyron fragile (Roth.) P.Candargy.</i>	Сибирь хиаг	Wheatgrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	элсэрхэг хээр, нимгэн ба бэхжэсэн элсэнд	Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Дорнод говь, Зүүнгарын говь
30	POACEAE Barnhart.	<i>Aristida adscensionis L.</i>	Гейманын бөөдий	Tree-awn	нэг наст өвс	тэжээлийн ургамал	уул, толгодын хуурай үйрмэг чулуурхаг ба элсэрхэг хажуу, хормой, элсэрхэг, хайргархаг цөл, тариалангийн талбайд	Хангай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь
31	POACEAE Barnhart.	<i>Beckmannia syzigachne (Steud.) Fern.</i>	Дорнодын топ өвс	Slough-grass	олон наст өвс	тэжээлийн ургамал	гол нуурын эрэг, чийглэг татмын ба намгархаг нуга, эргийн хайрга, булгийн чийглэг нуга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
32	POACEAE Barnhart.	<i>Chloris virgata Sw</i>	Саваан булган сүүл	Sweet-grass	нэг наст	тэжээлийн ургамал	сайргат бэл, говийн шал, элс-хайргат сайрын ёроол, эрэг, тариалангийн талбай	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь
33	POACEAE Barnhart.	<i>Cleistogenes songorica (Roshev.) Ohwi.</i>	Зүүнгарын хазаар өвс	Awnless cleistogene s	олон наст өвс	тэжээлийн ургамал	цөлийн хээр, уул толгодын хад чулуут хуурай ташлан, хормой, сайрын элс-хайргат ёроол	Монгол Дагуур, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
34	POACEAE Barnhart.	<i>Cleistogenes squarrosa (Trin.) Keng.</i>	Дэврээн хазаар өвс	Rough cleistogene s	олон наст өвс	тэжээлийн ургамал	сайрга, чулуут болон элсэрхэг хээр, толгодын хад, чулуут ташлан	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
35	POACEAE Barnhart.	<i>Leymus racemosus (Lam.) Tzvelev</i>	Цацааглагт цагаан суль	Mammoth wildrye	олон наст өвс	тэжээлийн ургамал	элс ба элсэрхэг хээр, цөлийн хээрт	Хангай, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
36	POACEAE Barnhart.	<i>Enneapogon desvauxii</i>	Умардын оготнын	Northern pappyusgra	нэг наст өвс	тэжээлийн ургамал	Сайрга чулуут, цөл болон цөлийн	Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод

		<b>P.Beauv.</b>	сүүл	ss			хээрийн уул толгодын ташлан, хуурай сайр, голын хайрга	Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
37	POACEAE Barnhart.	<i>Eragrostis minor</i> Host.	Бага хургалж	Small lovegrass	нэг наст өвс	тэжээлийн ургамал	элсэрхэг хээр, цөл, голын элс-хайргат эрэг, сайрын ёроол, зам, гуу жалга, тариалангийн талбайд	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
38	POACEAE Barnhart.	<i>Eragrostis pilosa</i> (L.)P.B.	Үслиг хургалж	Hairy lovegrass	нэг наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	уулын чулуурхаг, үйрмэг чулуут хажуу ба хормой, сайр ба ус урсдаг жалга, голын элсэрхэг хайргархаг эрэг, хааяа тариалангийн талбайд	Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Дорнод говь
39	POACEAE Barnhart.	<i>Koeleria macrantha</i> (Ledeb.) Schult.	Том цэцэгт дааган сүүл	Prairie junegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	өндөр уулын болон уулын хээр, сийрэг Шинэсэн ой, нуга, голын эргийн элс хайрга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
40	POACEAE Barnhart	<i>Leymus paboanus</i> (Claus.) Pilger.	Пабоаны цагаан суль	Pubescent wild rye	олон наст өвс	тэжээлийн ургамал	элсэрхэг хээр, эрэг орчмын мараалаг нуга, элс, хайрга, Дэрст цайдам, хээржүү ба нугажуу ташлан	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь
41	POACEAE Barnhart	<i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvelev.	Нангиад цагаан суль	Chinese wild rye	олон наст өвс	тэжээлийн ургамал	мараалаг газраар ба мараалаг нуга, гол нуурын мараатай элсэрхэг, хайргархаг эргээр	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь
42	POACEAE Barnhart	<i>Leymus secalinus</i> (Georgi.)	Хөх тариархуу цагаан суль	Wild rye	олон наст өвс	тэжээлийн ургамал	хужирт, мараат эргийн элс, нуга, дэрсэн дунд, гол	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон

		Tzvelev.					нуурын элсэрхэг хайргархаг эргээр, чулуурхаг хажуу, нуранга асганд	нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
43	POACEAE Barnhart	<i>Phragmites australis</i> (Cav.) Trin.ex Steud.	Эгэл нишингэ	Common reed	олон наст өвс	тэжээлийн ургамал	гол, нуурын эрэг, булгийн ойролцоо, элсэн манханы хөвөө, мараалаг элс, сондуул	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
44	POACEAE Barnhart	<i>Poa attenuata</i> Trin.	Сунагар биелгэ өвс	Delicate bluegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	уулын болон өндөр уулын хээр, чулуут, сайргат ташлан, хад асга, өндөр уулын бүслүүр хүртэлх ой ба голын нуга, голын хайрга	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь,
45	POACEAE Barnhart	<i>Puccinellia tenuiflora</i> (Griseb.) Scribner. et Merr.	Турьхан цэцэгт зурман сүүл	Alkaligrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	хужир мараатай нуга, элс ба хайрганд, эргийн хужир мараанд, булгийн дэргэд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
46	POACEAE Barnhart	<i>Setaria viridis</i> (L.) P.Beauv.	Ногоон хоног будаа	Green Bristle-grass	нэг наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	хайрга болон чулуурхаг хуурай хажуу, сайр, эргийн хайрга, тариалангийн талбай	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
47	POACEAE Barnhart	<i>Stipa splendens</i> (Trin.) Nevski.	Гялгар дэрс	Feather needlegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	мараалаг элс ба нуга, хужир марааны зах, сайр, булгийн эх, хөрсний ус ойр хөндий	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаа говь
48	POACEAE Barnhart	<i>Stipa breviflora</i> Griseb.	Ахар цэцэгт хялгана	Short-panicled needlegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	уулын хад чулуутай хажууд	Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь, Говь-Алтай

49	POACEAE Barnhart	<i>Stipa krylovii</i> <b>Roshev.</b>	Крыловын хялгана	Krylov needlegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	хуурай хээрийн бүсийн үндсэн ноёлогч, уулын хээрийн чулуурхаг ташлан, цөлжүү хээр	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь
50	POACEAE Barnhart	<i>Stipa glareosa</i> <b>(P.A. Smirn.) Tzvelev.</b>	Сайрын хялгана	Sand needlegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	элс ба сайргат цөлийн хээр, цөлжүү хээр, уул, толгодын хад чулуут хажуу, хормой, хайрга чулуутай тэгш тал, сайрын ёроол	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
51	POACEAE Barnhart	<i>Stipa gobica</i> <b>(Roshev.) D.F. Cui.</b>	Говийн хялгана (монгол өвс)	Gobi needlegrass	олон наст өвс	тэжээлийн ургамал	цөлийн хээрийн ноёлогч, цөлжүү хээр, уул толгодын сайрга, чулуут ташлан, хормой, хад, хайрга чулуут цөл, сайрын ёроол	Хангай, Монгол Дагуур, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
52	POACEAE Barnhart	<i>Tragus mongolorum</i> <b>Ohwi.</b>	Монгол ямаалз	Spike burgrass	нэг наст өвс	тэжээлийн ургамал	сайрга чулуурхаг хажуу, голын эрэг орчмын элс, хайрганд	Дорнод говь, Говь-Алтай
53	POACEAE Barnhart	<i>Tripogon chinensis</i> <b>(Franch.) Hack.</b>	Нангиад өлөн живэр	Chinese tripogon	олон наст өвс	тэжээлийн ургамал	уулын дунд бүслүүр хүртэл хайрга чулуутай хажуу ба хаданд	Хэнтий, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь
54	PAPAVERACE AE Juss.	<i>Hypescomum erectum</i> L.	Цэх галуун таваг	Erect hypescomum	хоёр наст өвс	эмийн, хүнсний ургамал	элсэргэх хээр тал, чулуурхаг ба үйрмэгт чулуут хээржүү хажуу, хад асган, голын элс, хайргат марзлаг эргээр	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорнод говь
55	PAPAVERACE AE Juss.	<i>Hypescomum lactiflorum</i> <b>Kar. et Kir. Pazij.</b>	Цагаалин галуун таваг	Horned hypescomum	хоёр наст өвс	тэжээлийн ургамал	сайрын ёроол, хайргат харгия, голын марзлаг нуга, цөлийн хээрийн	Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь,

							бүсэд уулын бэлээр	Алтайн өвөр говь, Алашаа говь
56	RANUNCULAC EAE Juss.	<i>Aquilegia viridiflora Pall.</i>	Ногоон удвал	Green columbine	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	уулын хад асганд, чулуурхаг хажууд	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай
56	RANUNCULAC EAE Juss.	<i>Halerpestes salsuginosa (Pall. ex Georgi) Greene.</i>	Марцны гэц	Halerpestes	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	чийглэг марзлаг, намгархаг нуга, нуур, гол, горхи, булгийн эрэг хөвөө	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
57	RANUNCULAC EAE Juss.	<i>Halerpestes sarmentosa (Adams.) Kom.</i>	Сахалт гэц	Halerpestes	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	намгархаг марзтай нуга, нуур, гол, горхи, булгийн хужиртай эрэг, чийглэг мараа, дэрсэн шугуйд	Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
58	RANUNCULAC EAE Juss.	<i>Thalictrum squarrosum Steph.ex willd.</i>	Дэрвээн буржгар	Meadowtu e	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	хээрийн бутармаг чuluут ба чулуурхаг хажуу, элсэрхэг хээр, хад асганд	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Говь-Алтай
59	GRASSULACE AE J.ST.-Hil.	<i>Orostachys fimbriata (Turcz.) A.Berger.</i>	Цацагт үлд өвс	Fringed orostachys	хоёр наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	уул, толгодын хээржүү чулуурхаг, сайргат хажуу, хад цохио, элсэрхэг хээр талд	Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
60	GRASSULACE AE J.ST.-Hil.	<i>Sedum aizoon L.</i>	Үлдэн могойн идээ	Aizoon stonecrop	олон наст өвс, ховор	эмийн болон тэжээлийн ургамал	ойт хээрийн бүслүүр болон цөлжүү хээр дэх уулын хад, чuluут хажуу, голын эргийн элс, хайрганд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Говь-Алтай, Зүүнгарын говь
61	TAMARICACE AE Link.	<i>Reaumuria soongarica (Pall.) Maxim.</i>	Улаан бударгана	Red reaumuria	заримдаг сөөгөнцөр	тэжээлийн ургамал	цөлийн хээрийн бүсэд тойрмын зах, марз, мараалаг хотос, хөндий, сайрга-элст, шаварлаг-сайргат цэл	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь

180	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Artemisia santolinifolia</i> Turcz.ex.Krasch.	Хар шарилж	Black wormwood	заримдаг сөөгөнцөр	тэжээлийн ургамал	өндөр уулын хээрийн бүслүүрт чулуут ташлан, асга, хавцлын ёроол, хад чулуу, татмын мараалаг нуга, хайрга, гол нуурын элсэрхэг хөвөө, сайрын ёроол	Хэнтий, Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
181	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Artemisia scoparia</i> Waldst.& Kitam.	Ямаан шарилж	Sagewort wormwood	хоёр наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	хээрийн сайргат ба чулуут ташлан, асга, уулын хормой, татмын мараалаг нуга, элс хайрга, сайргат ба элсэрхэг хээр, цөлийн хээр, цөл, Дэрст цайдам	Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь
182	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Artemisia xanthochloa</i> Krasch.	Шар шарилж	Wormwood	заримдаг сөөгөнцөр, Нэн ховор, Монгол улсын Улаан номонд (2013) орсон, субэндемик	элс тогтоогч	хээр ба цөл, Заган шугуй, элсэн довцог, элсэн манхан, заримдаа мараалаг элс, хайрга, татмын нуга, тойром, сийрэг сайрга-элсэрхэг ташлан, сайрын ёроол, хөвөө	Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
183	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Heteropappus altaicus</i>	Алтайн согсоот	Mongolian Altai aster	олон наст өвс	балт болон тэжээлийн	сайргат ба чулуут ташлан, хад, сайрын	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад

		(Willd.) Novopokr.				ургамал	хөвөө ба ёроол, сул бэхлэгдсэн элс, хайрга	Халх, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
184	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Aster hispidus</i> Thunb.	Арзгар согсоот	Aster	хоёр наст өвс	балт болон тэжээлийн ургамал	хээрийн сайргат ба чулуут ташлан, хад, голын хайрга, сул бэхлэгдсэн элс, элсэрхэг хээр, сайрын ёроол	Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь
185	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Astrothamnus alyssoides</i> (Turcz.) Novopokr.	Дэмэглэй лавай	Astrothamnus	заримдаг сөөгөнцөр	тэжээлийн ургамал	үйрмэг чулуутай ба чулуурхаг цөлөрхөг бэл, сайрын захаар	Дундад Халх, Дорнод говь
186	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Echinops gmelinii</i> Turcz.	Гмелиний тайжийн жинс	Gmelin globethistle	нэг наст өвс, субэндемик	эмийн болон тэжээлийн ургамал	элсэн товцог ба манхан элс, уулын элсэрхэг ташлан, сайрын элсэрхэг хөвөө, целийн хээр ба целийн бүсэд	Хангай, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
187	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Crepidiastrum akagii</i> (Kitag.) W.Zhang & N.Kilian.	Нарийн навчит юнги	Hawkweed	олон наст өвс	эмийн ургамал	хуурай хээр, сайрга чулуут ташлан, хад, эрэг орчмын хайрганд	Хэнтий, Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
188	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Crepidifolium tenuifolium</i> (Willd.) Sennikov.	Нарийн навчит банга	Crepidifolium	олон наст өвс	тэжээлийн ургамал	хуурай хээр, сайрга чулуут ташлан, хад, эрэг орчмын хайрганд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь
189	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Lactuca tatarica</i> (L.) C. A. Mey.	Татаар зираа	Mongolian jurinea	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	гол, нуур, булгийн хөвөөний мараалаг элс ба хайрга, Дэрст цайдам, марз, мараалаг элс, суваг	Хангай, Монгол-Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь

							шуудууны дагуу	
190	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Neopallasia pectinata</i> (Pall.) Poljakov.	Шүлхий шарилж	Combleaf wormwood	нэг наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	хээр, цэлийн хээр, заримдаг цөл, уулын хажуу, нуранга асга, хужир мараа, элс ба голын эрэг, хайрга, уул, толгодын үйрмэг чулуут хормой, сайрын ёроол адгаар	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь
191	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Saussurea amara</i> (L.) DC.	Гашуун банздоо	Meadow saw-wort	олон наст өвс	тэжээлийн ургамал	голын мараалаг элс-хайрга, эрэг орчмын мараалаг нуга, доройтсон газар	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Зүүнгарын говь
192	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Saussurea laciniata</i> Ledeb.	Имт банздоо	Saw-wort	олон наст өвс	тэжээлийн ургамал	гол нуурын мараалаг эрэг, хужир давстай элс, тойром, сайрын мараалаг ёроолд	Хангай, Монгол-Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
193	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Saussurea salsa</i> (Pall.ex Pall.) Spreng.	Марцны банздоо	Saline saw-wort	олон наст өвс	хортой ургамал	эрэг орчмын марз, мараалаг элс ба элс-хайргат харгия, булаг орчмын мараалаг намаг, мараалаг нугад	Хангай, Хянган, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Зүүнгарын говь, Алашаа говь
194	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Scorzonera capito</i> Maxim.	Данхар хависгана	Capitate vipergrass	олон наст өвс субэндемик	тэжээлийн ургамал	цэлийн хээр, цэлийн бүсэд уул толгодын хад, үйрмэг чулуутай ба чулуурхаг хажууд	Дундад Халх, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
195	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Scorzonera divaricata</i> Turcz.	Дэрэвгэр хависгана	Spreading vipergrass	олон наст өвс, субэндемик	тэжээлийн ургамал	цэлийн хээр, цэлийн бүсийн нимгэн элс, сайргат ба элсэрхэг цөл, уул толгодын сайргат ташлан, хормой, сайрын ёроолд	Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь

196	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Scorzonera ikonnikovii</i> Lipsch. et Krasch.	Иконниковы н хависгана	Vipergrass	олон наст өвс, субэндемик	тодорхойгүй	хуурай ба цэлийн хээрт уулын үйрмэг чулуутай ба чулуурхаг хажуу, хормой, хад, сайрын хаялгаар	Хангай, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
197	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Senecio dubitabilis</i> C.Jeffrey & Y.L.Chen.	Гацмал зохимон	Senecio	олон наст өвс	тодорхойгүй	эргийн хайрга ба сайрын ёроол, булаг, горхийн эргийн хужир мараа, хааяа суваг, харгианд	Хэнтий, Хангай, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
198	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Serratula centauroides</i> L.	Хонгорзулли г хонгорзалаа	Common plumeless saw-wort	олон наст өвс	эмийн, балт болон тэжээлийн ургамал	хээр, хээрийн ташлан, асга, сайрын элс-хайргат ёроол, нимгэн элс, элсэрхэг хээр	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол- Дагуур, Хянган, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь- Алтай
199	ASTERACEAE Bercht.& J.Presl.	<i>Taraxacum dissectum</i> (Ledeb.) Ledeb.	Цуулбар багваахай	Cutleaf dandelion	олон наст өвс	тэжээлийн ургамал	гол, горхины хөвөө орчмын мараалаг нуга, мараалаг хайрга, марзны зах	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол- Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Дорнод говь, Говь-Алтай
200		<i>Taraxacum leucanthum</i> (Ledeb.) Ledeb.	Цагаан цэцэгт багваахай	Taraxacum	олон наст өвс	эмийн ургамал	эрэг орчмын мараа, маралаг хээржүү хажуу	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол- Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь
201	APIACEAE Lindl.	<i>Bupleurum bicaule</i> Helm.	Хоёр ишт бэриш	Thorow wax	олон наст өвс	эмийн болон тэжээлийн ургамал	уулын сайргат, чулуут ташлан, нам уулс ба дов толгодын ташлан, чулуурхаг цэлийн хээр, тачир өвст хээрийн нуга, хаданд	Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол- Дагуур, Ховд, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь, Говь-Алтай
202	APIACEAE Lindl.	<i>Ferula bungeana</i>	Бүнгийн хавраг	Coarse giant fennel	олон наст өвс, субэндемик	эмийн болон тэжээлийн	элсэрхэг тал, нүүдэг ба тогтмол элс,	Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Дорнод говь,

		<b>Kitag.</b>				ургамал	сайрын элсэн ёроол, элсэрхэг ба хайргархаг цөлжүү бэл хормой, боржин чулуун толгой, байц хаданд	Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь
--	--	---------------	--	--	--	---------	---	---

	<b>Нэн ховор</b>
	<b>Ховор</b>
	<b>Элбэг</b>
	<b>Эндемик</b>
	<b>Субэндемик</b>

## ДҮНДГОВЬ АЙМГИЙН АШИГТ УРГАМЛЫН СУДАЛГАА

Тус аймгийн нутагт ургаж буй нэн ховор, ховор, ашигт ургамлын шинжлэх ухааны нэр, монгол, адилцаа, орос, англи нэршил, ургах орчин, тархцыг бичиж, ургамлын зургийг болон байршлын тойм зургийг тус тус оруулав. Мөн зарим ургамлын тархац, нөөц болон түүнийг ашиглах, хамгаалах талаар зүйл тус бүрийн ард товч зөвлөмжийг бичиж хавсаргасан болно.

### НЭН ХОВОР УРГАМАЛ

**АЛТАН БЭРМЭГ**, Бэрээмэг, шар цэцэг

Латин нэр: *Limonium aureum* (L.) Hill et Ktze.

Орос нэр: Кермек золотой

Англи нэр: Golden Sealavender

**Ангилалзүйн шинж:** Ихэвчлэн дэлхээ байрлалтай, салаалсан, 15-20 см өндөр иштэй олон наст өвслөг ургамал. Цэцэг 3-5-аар хамт байрлаж түрүүхэй үүсгэхтэйгээр нь улмаар нийлж салааны үзүүрт нягт толгой баг цэцэг болж тогтсон байдаг. Дэлбийн хэлтэс улбар шар(5-р зураг).

**Ургах орчин:** Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуут хажуу, бэл хормой, марзлаг цөл, голын эргийн хужир, марзтай хуурай элс, хайрга, тойрмын захаар ургана.



Алтан Бэрмэг



Алтан бэрмэгийн тархац

**Тархац:** Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь (дорнод), Алашаагийн говийн тойргуудад тархан ургана.

Хүснэгт 2. Алтан бэрмэгийн тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Дундговь, Өмнөговь аймгийн заагт төв замын дагуу.	Үетэн- элдэвавс-харганат хээр	Дорноговь	44° 40' 56.0" 105° 31' 17.5"

**Тархац, нөөц:** Алтан бэрмэг хэмээх ургамал нь тархцын хүрээндээ туйлын алаг цоог, тасархайтсан байдалтай ургах учир тооллогын материал бүрдээгүй.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Монгол анагаах ухаанд үндсийг биеийн тамир тэнхээ дорийтох, идээ ундаанд дургүй болох, навчийг хodoодны шархлаа, хodoод өвдөхөд, хodoодны шархлаанд хэрэглэнэ. Цэцэгт салааг умайнаас цус алдах, савны хүзүүний өмөн зэрэгт чанаж уулгана.

Энэ ургамал нь Байгалийн ургамлын тухай хуульд (1995) нэн ховор статустайгаар, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлд (2012) хэдийгээр популяцийн нягтшил бага боловч өргөн тархалттайг харгалзан анхааралд өртөхөөргүй гэсэн үнэлгээтэйгээр бүртгэсэн байна. Тархцын нутагтаа маш сийрэг боловч элбэг ургана.

## ТОЛБОТ БЭРЭЭМЭГ, Улаан үндэс, шар бэрээмэг, шар тэмэг, миндэн сэргүү

Латин нэр: *Arnebia guttata Bge.*

Орос нэр: Арнебия пятнистая

Англи нэр: Common Arnebia

**Ангилалзүйн шинж:** Ширүүн үсээр сийрэг хучигдсан сааралдуу ногоон, 20-30 см өндөр хоёр болон олон наст өвслөг ургамал. Будаглаг бүдэг улаан хальс бүхий голлосон үндэстэй, олон салаалсан цэх иштэй. Хоёр талдаа сийрэг ширүүн үслэг юлдэрхүү хавтгай, суумал цувраа навчтай. Хос билэгтэй олон цэцгүүд иш мөчрийн оройд цацаг баг цэцэг үүсгэнэ. Голчоороо 7 мм орчим дэлбээтэй, хүрэн бор толбо бүхий мухар таван дэлбэнтэй. Урт нь 12,5 мм урт, гонцгойвтор зууван дөрвөн жижиг хатуу жимстэй(7-р зураг).



Толбот бэрээмэг



Толбот бэрээмгийн тархац

**Ургах орчин:** Сайрын эрэг, сайрын элс, хайрган ёроол, үйрмэг чулуут болон чулуурхаг бэл хормой, нимгэн давхраат элс, элсэрхэг хөрсөнд ургана.

**Тархац:** Монгол Алтай (зуун өмнөд), Их нууруудын хотгор, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр.gov, Алашаа говийн тойрогт ургана.

*Хүснэгт 3. Толбот бэрээмэгийн (Улаан үндэс, шар бэрээмэг, шар тэмэг, миндэн сэруү)*  
*тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорнговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"

**Тархац, нөөц:** Нөөцийн судалгааны тоон материал хангалтгүй.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Бэрмэгийн үндсийг монгол, түвд эмнэлэгт цусан хавдар, улаанууд, хавдар, түлэгдэл, цусаар бөөлжих, хамраас цус гарах зэрэгт олгодог эмийн найрлагад оруулдаг байна.

Толбот бэрээмэг нь Байгалийн ургамлын тухай хуульд (1995) нэн ховор статустайгаар, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлд (2012) хэдийгээр мал болон хүний нөлөөгөөр тухайн зүйл ургамлын амьдрах орчин доройтох эрсдэлтэй боловч анхааралд өртөхөөргүй гэсэн зэрэглэлд багтаасан. Одоогоор дээд түвшний зэрэглэлээр үнэлэх хэмжээний аюул занал нүүрлээгүй. Популяцийн хэмжээ, цаашдын чиг хандлага, биологи, экологи, амьдрах орчны төлөв байдал, тархац нутгийн хэмжээ зэргийг судлах шаардлагатай.

**МОНГОЛ ДОГАР**, Ямаан эвэр, агаруу, сургир.

Латин нэр: *Caryopteris mongolica Bunge*


Орос нэр: Кариоптерис монгольский

Англи нэр: Mongolian Bluebeard

**Ангилалзүйн шинж:** Угаасаа эхлэн модожсон, нумарсан улаавтар саарал найлзууртай, 30-50 см өндөр, заримдаг сөөгөнцөр. Навчис эсрэг суусан, саарал ногоон өнгөтэй. Үзүүрийн эсвэл өврийн бамбай баг цэцэгтэй. Дэлбэ тод хөх өнгөтэй. Жимс тал бөмбөлөг хэлбэртэй, нүцгэн.



Монгол догар



Монгол догарын тархац

**Ургах орчин:** Хээр, цөлөрхөг хээр, цөлийн уул толгод, бэсрэг уулсын хярын чулуурхаг, үермэг чулуут хажуу, сайрын хөвөө, элсэн хайрган оёор, нимгэн давхраат элсэнд ургана.

**Тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол-Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говийн

#### Хүснэгт 4. Монгол догарын (Ямаан эвэр, агаруу, сургир) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уул, Булангийн давааны оройд.	Боролз – буйлс - алагөвст хээр.	Дорноговь	44° 11' 48.9" 104° 46' 16.7"
Хулд	Сумын төвөөс баруун урагш 12 км-т, Хулд уул.	Сөөг-үетэн-алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь	45° 11' 54.4" 105° 24' 58.5"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"
Өлзийт	Сумын төвөөс баруун урагш 70 орчим км-т.	Алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 33' 13.9" 105° 55' 17.9"
Адаацаг	Бага газрын чулуу	Бүйлээс- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)	46° 13' 00.6" 106° 03' 11.3"
Өлзийт	Өөш манханы элс, Хөтөл уулын баруун хажуу.	Харгана - бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Дэлгэрхангай уул орчмын үетэн-алагөвс-харганат (*Agropyron cristatum*, *Caryopteris mongolica*, *Artemisia frigida*, *Allium polyrrhizum*, *Caragana microphylla*, *Caragana pygmaea*) хээрт sol арвитай ургана.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Навч, цэцэгтэй газар дээрх хэсгээс бэлтгэсэн ханд, хандмал, чанамал нь төрсний дараах цус алдалтыг зогсоох, умай агшиж хэвийн байдалд орох явцыг түргэтгэх, шээлгэх, судсыг нарийсгах, умайн гөлгөр булчингийн чангарлыг нэмэгдүүлэх зэрэг үйлдэлтэй Монголын эрдэмтэд тогтоожээ.

Монгол дотор нь “Монголын улаан ном”-ын хоёр удаагийн хэвлэлд (1987, 1997) ховор статустайгаар, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлд (2012) мал бэлчээрлэлт болон уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр тархац нутгийн хэмжээ багасах хандлагатай байгааг харгалзан эмзэг зэрэглэлд багтаажээ.

Энэ ургамлыг тархац нутгийн хэмжээнд ашиглалт хэрэглээний түвшинг тогтоож тархац нөөцийн судалгаа явуулж, нөхөн сэргээх, тарималжуулах, нутагшуулах, шилжүүлэн үржүүлэх зэрэг ажлыг биотехнологийн аргаар гүйцэтгэх шаардлагатай юм.

#### СИБИРЬ ЕРӨНДГӨНӨ, Тэмээн хөх.

Латин нэр: *Vincetoxicum sibiricum (L.) Dence.*

Орос нэр: Ластовень сибирский

Англи нэр: Siberian Vincetoxicum

**Ангилалзүйн шинж:** Цэх энгийн юмуу сарвагар мөчиртэй, 15-20 см өндөр иштэй, олон наст өвслөг ургамал. Навч нь шовх оройтой, нарийн шугамархуу юмуу шугаман юлдэн. Цэцэг нь жижиг, ишний дээд хэсгийн навчны өвөрт богино цацаг хэлбэрийн баг цэцэг үүсгэдэг. Цэцгийн дэлбээ нь бүрцгэр шар.

**Ургах орчин:** Хээрийн үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, нураг, жижиг сайрын оёор, нимгэн давхраат элс, элсэрхэг хээрт ургана.



Сибирь ерөндөгнөө.



Сибирь ерөндөгнөийн тархац

**Тархалт:** Хангай(дорнод), Монгол Дагуур, Хянган, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Говь-Алтай, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Зүүн гарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойрогт тохиолдоно.

#### Хүснэгт 5. Сибирь ерөндөгнөийн (Тэмээн хөх) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Сайхан-Овоо сумаас аймгийн төв орох замд.	Хялгана-таана-харганат хээр	Дорнод Говь	44° 40' 31.5" 106° 59' 17.3"

**Тархац, нөөц:** Өргөн тархалттай боловч маш сийрэг, арвигүй ургадаг учир гарц нөөцийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Ардын эмнэлэгт боловсроогүй жимсийг элэгний болон цөс ялгаруулах замын эрхтнүүдийн өвчин, зүрх хийгээд хodoод, гэдэсний өвчин, цусан суулга болон улаанууд, уушгины хатгаа хүндрэх зэргийг эмчлэх эмийн найрлагад ордог байна.

Энэ ургамал нь Байгалийн ургамлын тухай хуулийн (1995) нэн ховор ургамлын жагсаалтанд орсон, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний

эмхэтгэлд (2012) өргөн тархацтай бөгөөд одоогоор энэ зүйл ургамал дээд аюул занал нүүрлээгүй тул Анхааралд өртхөөргүй гэсэн зэрэглэлд багтаав.

### ШИВЛЭЭХЭЙ ЗЭЭРГЭНЭ, Морин зээргэнэ, хар зээргэнэ.

Латин нэр: *Ephedra equisetina Bge.*

Орос нэр: Эфедра хвощевидная

Англи нэр: Mongolian Ephedra

**Ангилалзүйн шинж:** Өндөр нь 30-60 см, хоёр гэрт мөнх ногоон сөөг. Модлог иш бахим, эгц шулуун, хөхөвтөр юм уу саарал ногоон, хатуу. Эр боргоцой бараг бөөрөнхий, мөчрийн үе дээр хосоор юмуу ганцаар байрладаг, эм борогцой мөчрийн үе дээр эсрэг суусан, үр боловсрох үед шүүслэг, улаан жимсгэнэ мэт болно. Үр ихэвчлэн ганц.



Шивлээхэй зээргэнэ



Шивлээхэй зээргэнийн тархай

**Ургах орчин:** Уул толгодын хад чулуутай энгэр, сайр чулуутай ирмэг, эргээр ургана.

**Тархалт:** Хангай(өмнөт), Монгол Алтай(дорнод), Дундад Халх, Дорнод Монгол(Зүүн Нарт), Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаагийн говийн тойргуудад тархана.

#### Хүснэгт 6. Шивлээхэй зээргэнийн (Морин зээргэнэ, хар зээргэнэ) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Сумын төвөөс баруун урагш 12 км-, Хулд уул.	Сөөг-үетэн-алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	

**Тархай, нөөц:** Дундговь аймгийн Хулд сумын төвөөс баруун урагш 12 км-т долгодын дунд sol арвтай ургана. Энд нийт 100 орчим га талбайд 2.4 кг/га ургацтай, 30 кг бэлтгэлийн нөөцтэй болохыг тогтооолоо.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Зээргэнээр хийсэн эм нь захын судсыг нарийсгаж цусны даралтыг өндөрсгөн, уушигны мөгөөрсөн гуурс болон бусад эрхтний гөлгөр булчинг сулруулж цусан дахь чихрийн хэмжээг ихэсгэнэ. Эфедрин нь төв мэдрэлийн тогтолцоог тордож амьсгалын төвийн сэрэх чадамжийг нэмэгдүүлдэг.

Шивлээхэй зээргэнэ нь Байгалийн ургамлын тухай хуулийн (1995) нэн ховор ургамлын жагсаалтанд орсон, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл (2012), Монголын Улаан Номны 2 удаагийн хэвлэлд (1987, 1997) нэн ховор статустайгаар бүртгэгдсэн бөгөөд Монгол орны.gov цөлийн бүсэд бэсрэг уулсын хад чулуутай энгэр, сайр чулуутай ирмэг, эргээр маш сийрэг ургах ба мөн энэ ургамал цөлөрхөг хээр, цөлийн бүсийн дээрх орчинзүйн нөхцөлд ургамалжлын бүлгэмдэлд оролцдог тул түүж бэлтгэх зөвшөөрөл олгохгүй байх нь зүйтэй.

## ХОВОР УРГАМАЛ

### УРАЛ ЧИХЭРӨВС, Чихэрөвс

Латин нэр: *Glycyrrhiza uralensis Fisch.*

Орос нэр: Солодка уралская

Англи нэр: Ural Licorice

**Ангилалзүйн шинж:** Өндөр нь 40-100 см, буурцагтан-Leguminosae Juss.-ын олон наст өвслөг ургамал. Үндэс, үндэслэг иш хүчирхэг хөгжсөн. Иш шулуун, салаалалттүй, навчны адил ширүүн, аргар гадаргуутай. Навч сондгой өдлөг, 4-6 хос, гонзгойвтор-өндгөрхүү шовх илтэстэй. Баг цэцэг цайвар нил өнгөтэй, богино өтгөн цацаг хэлбэртэй. Буурцаг том, гонзгойвтор, хавчиг, тахиралдсан, долгиолог, гадна талдаа шүүсэвчлэг, ноолуурхаг, ихэвчлэн өргөслөг. Үр бөөр лугаа хэлбэртэй(15-р зураг).

**Ургах орчин:** Хээр тал, чийглэг марцилаг нуга, марц хужиртай элс, элсэрхэг хээр, сондог, хээрийн гол горхины хөндийд ургана.



Урал чихэр-өвс



Урал чихэр өвсний тархай

**Тархалт:** Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорнговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Алашаа говийн тойрогт, засаг захиргааны хуваариар Монгол орны бүх аймагт тархан ургах бөгөөд гарц-нөөцийн хувьд янз бүр байна. Баянхонгорт манай орны чихэр өвсний түүхий эдийн 80% орчим нь ургах бол зарим аймагт тархцын цэг тэмдэглэгдэх төдий ургана.

*Xүснэгт 7. Урал чихэр өвсийн тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Баянжаргалан	Сумын төвөөс урагш 52 км-т, Өмнөговийн Манлай сум явах замд.	Үетэн- шарилж-алагөвст цөлөрхөг хээр.	Дорнговь (жинхэнэ)	

**Тархац, нөөц:** Энэ нутагт гарц-нөөцийн нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Эм, хүнс болон тэжээлийн өндөр ач холбогдолтой ургамал юм. Тухайлбал: үндсийг нь хими, хүнс, өнгөт металлургийн, хөдөө аж ахуйн, барилгын, тамхины үйлдвэр г.м. олон салбарт ашигладаг бөгөөд зөвхөн аж үйлдвэрт гэхэд 20 гаруй салбарын түүхий эд болдог.

Чихэрөвсөөр бэлтгэсэн эм (chanamal, идээшмэл, өтгөн, шингэн болон хуурай ханд, үрэл г.м.)-ийг уушигны хатгаа, цагаан мөгөөрсөн хоолойн өрөвсөл, ханиад, ханиалга зэргийг анагаахад хэрэглэнэ. Энэ ургамлыг читамон, чигатусин зэрэг эмийн найрлагад оруулах ба чихэрөвсний ханд, үрлэн эм, элексир, сироп зэрэг эм бэлдмэл хийж цэр ховхлох зорилгоор өргөн хэрэглэж байна.

Үндэс, үндэслэг ишийг хавар 4-5-р сар, намар 9-10-р сард бэлтгэнэ. Бэлтгэхдээ үндэс, үндэслэг ишийг ухаж аваад ишийг хярган хаяж, шавар шороог арилган сүүдэр газар хатаана. Урал чихэрөвсийн нөөц харьцангуй ихээр багасаж байгааг анхаарч дараах арга хэмжээ авах нь зүйтэй.

Чихэр өвсний тархац, нөөц, нөхөн сэргээх онцлогийг одоогийн нөхцөлд нарийвчлан тогтоох.

-Байгалийн нөхцөлд нь хамгаалах эвшил, бүлгэмдэл болон цэвэр шигэнгийг тогтоож зохих хууль, тогтоомжийн дагуу улс, аймаг, сум, багийн хэмжээнд шатлан хамгаалах.

-Нөхөн сэргээх, үр болон үндэслэг иш, суулгацаар үржүүлэн ургуулах, судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын шууд удирдлагаар орон нутагт нь эл чиглэлийн ажил үүрэг бүхий хамтын нөхөрлөл, хоршооны хэлбэрээр гүйцэтгэх шаардлагатай.

Урал чихэрөвс- *Glycyrrhiza uralensis Fisch.* сүүлийн жилүүдэд гарц-нөөцийн хувьд харьцангуй тогтвортой байгаа нь Монгол улсын засгийн газрын тогтоолоор (2004) ховор

ургамлын жагсаалтанд оруулж гадаадад их хэмжээгээр гаргахыг зогсоосонтой холбоотой болов уу.

### АЦАН АЖИГАНА, Түмэн занилаа, сороол

Латин нэр: *Stellaria dichotoma L.*

Орос нэр: Зведчатка вильчатая

Англи нэр: Dichtomous Starword

**Ангилалзүйн шинж:** Үндэс нь 5-15 мм голчтой, 20 см урт олон наст өвслөг ургамал. Булчирхайт өтгөн богино үсэрхэг, сууриасаа эхлэн ацлаж салаалсан, 30 см хүртэл өндөр, бөмбөлөг хэлбэрийн бут үүсгэдэг, олон салаа иштэй. Навчис өндгөрхүү буюу гонзгойвтор өндгөрхүү, юлдэрхүү юмуу шугаман юлдэрхүү, ишний доод хэсгийнх өргөн, дээд хэсгийнх нарийн олон навчистай. Навчны үзүүр шовгор, суурь зүрхэрхүү. Бага зэрэг цуурсан цагаан дэлбээ бүхий цэцгүүд иш найлзуурын үзүүр ба навчны өвөрт байлада, нарийн сарьслаг эмжээртэй, шовх юлдэн илтэстэй. Цоморлигт жимс 2-5 үртэй, бараг бөмбөлөгөн хонхорцог.



Ацан ажигана.



Ацан ажиганын тархай

**Ургах орчин:** Хээрийн чулуурхаг хуурай хажуу, нураг хад чулуу, заримдаа хайрга элсэнд ургана.

**Тархалт:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган?, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорноговь, Говь-Алтайн тойротг ургадаг.

Хүснэгт 8. Ацан ажиганын (Түмэн занилаа, сороол) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Адаацааг	Бага газрын чулуу, Баянбулагийн амралтын зүүн талд.	Үетэн- алагөвст эвшил	Дундад Халх	46° 12' 56.0" 106° 01' 10.9"
Адаацааг	Бага газрын чулуу	Бүйлээс- алагөвст хээр	Дундад Халх	46° 11' 53.1" 106° 01' 08.9"
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян	Шарилж-үетэнт,	Дорнод говь.	46° 33' 38.2"

	уул.	алаг өвс-үетэн-шарилжит эвшилд.		107° 50' 13.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс-алаагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ. Ерлөг уул. Хархадны тохой	Монгол өвс-алаагөвст хээр.	Дорнод говь	45° 52' 08.6" 107° 12' 18.2"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"

**Тархац, нөөц:** Энэ ургамлын бүрхэц маш сийрэг, тархцын хүрээндээ түйлийн алаг цоог, тасархайтсан тархалттай учир тооллогын материал бүрдээгүй.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Үндэс нь *Coli communis*-ын өсөлтийг нэлээд зогсоох үйлдэлтэй ба хоруу чанар багатай. Уушгины өрөвсөл, сүрьеэ, хүүхдийн хөхүүлдэг ханиад анагаадаг олон эм танд зонхилогч болгон оруулдаг. Бэлдмэл ба нийлбэр үйлчлэгч бодисын ханд нь цэрийг шингэрүүлэн ховхлох үйлдэлтэй. Ардын болон шинжлэх ухааны эмнэлэгт эм тангийн зориулалтаар бэлтгэж популяцийн тоо толгой ховордож байгааг харгалзан Засгийн Газрын тогтоолоор ховор ургамлын жагсаалтанд оруулсан.

Уг ургамлын ургаж байгаа бүс нутагт тарималжуулах, нөхөн сэргээх, туршилт судалгаа явуулах шаардлагатай болно.

### НАНГИАД ЗЭЭРГЭНЭ, Ямаан зээргэнэ

Латин нэр: *Ephedra sinica Stapf.*

Орос нэр: Эфедра китайская

Англи нэр: Chinese Ephedra

**Ангилалзүйн шинж:** Тахиралдаж мушгирсан үзүүр бүхий ногоон мөчиртэй, 10-20 см өндөр иштэй жижиг сөөг. Жимс махлаг улаан, дундаа 2 үртэй, үрлэгч түрүү хоёр цэцэгтэй(19-р зураг).

**Ургах орчин:** Тэгшивтэр толгодын дунд үетэн-алаагөвст хээр ургана.



Нангиад зээргэнэ.



Нангиад зээргэнийн тархац

**Тархалт:** Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойротг сүүлийн жилүүдэд Зүүнгарын говийн хойт зах, Алтайн өвөр говийн зарим хэсэгт ургадаг болохыг тогтоосон. Хөвсгөл, Архангай аймгаас бусад бүх аймагт тархан ургана.

*Хүснэгт 9. Нангиад зээргэнийн (Ямаан зээргэнэ) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Дэлгэрцогт	Сумын төвөөс зүүн хойш, Шалын тойром. Суурингийн туршилтын талбай орчим	Хялгана- алагөвст хээр.	Дундад Халх (зүүн)	46° 17' 15.9" 106° 30' 40.7"
Дэлгэрцогт	Гишгүүрийн Суурингаас урагш 30 км-т аймгийн төв явах замд.	Хялгана- алагөвст хээр.	Дундад Халх (зүүн)	45° 55' 53.5" 106° 20' 32.7"
Дэлгэрцогт	Дэлгэрцогтоос Улаанбаатар явах төв замын дэргэд.	Хялгана- таанат хээр.	Дундад Халх	46° 53' 19.2" 106° 37' 36.7"

**Тархац, нөөц:** Нангиад зээргэнэ нь Дундговь аймгийн Дэлгэрцогт, Дэрэн сумдаар алаг цоог ургадаг, тооллогын материал бүрдээгүй.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Нангиад Зээргэнэ нь эмчилгээ үйлчилгээний хувьд бусад зээргэнэтэй ялангуяа шивлээхэй зээргэнэтэй ижил үйчилгээтэй юм.

Хавар (3-4-р сард) зээргэний ногоон мөчрийг зориулалтын хайчаар (цэцэрлэгийн), хадуураар хадаж авна. Ингэхдээ зээргэнэт талбайн гурваны нэгийг хөндөлгүй үлдээх бөгөөд мөн нэг бутны ногоон мөчрийн гуравны нэгийг хөндөлгүй үлдээх шаардлагатай. Ингэх нь энэ төрлийн ургамлын нөхөн сэргэлтэнд чухал нөлөө үзүүлнэ. Энэ ургамал өөрийн төрлийн бусад зүйл болон бусад ашигт ургамлаас харьцангуй арвин нөөцтэй боловч Дундговь аймагт бэлтгэлийн нөөц байхгүй юм.

Энэ зууны эхээр энэ ургамлын ногоон мөчрөөс “Эфедрин” гарган авах үйлдвэр байгуулахаар их хэмжээгээр бэлтгэснээс манай орны байгалийн ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлж, тэнцвэрт алдагдах болсноос Засгийн газрын тогтоолоор (2004) ховор ургамлын жагсаалтад оруулсан. Гэвч энэ ургамлын зөвхөн газар дээрх хэсгийн ногоон мөчрийг ашигладаг, тарималжуулах ирээдүйтэй, анхан шатны боловсруулалт хийж гадаадад худалдаалж валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ач холбогдолтой зэргийг харгалzan тус аймгийн пүүс компани, аж ахуйн нэгж тарьж ашиглах боломжтой болно.

**ШИВҮҮРТ ЦУЛХИР,** Цульхир, хатгуурт цульхир, шивүүрт цулхир, дэрвээн цульхир, элсний цульхир, сульхар, сульхир.

Латин нэр: *Agriophyllum pungens* (Vahl.) Link. ex A. Dietr

Орос нэр: Кумарчик колючий

Англи нэр: Tgorny Agriophyllum, Squarrose Agriophyllum

**Ангилалзүйн шинж:** Ёзоороосоо оройдоо хүртэл салаалсан найлзуур нь 30-40 (80) см өндөр нэг наст өвслөг ургамал. Навч 5-7 судалтай, үзүүртээ өргөстэй, юлд юмуу шугаман юлд хэлбэртэй, цайвар ногоон өнгөтэй. Навчны суганд байрласан цэцгүүд нь өргөслөг, зангуу хэлбэртэй. Үр жимс оройдоо хоёр салаа өргөслөг сэргтэнтэй, захаараа дэвүүр мэт хайртай, цайвар хүрэн, хүрэн. 5, 6-р сард соёолж, 6-7-р сард цэцэглэн, 8 сард үр боловсроно.



Элсний цулхир.



Элсний цулхирийн тархай

**Ургах орчин:** Элсэн дов толгод, манхан, тал, сайрын ёроолын элс, хуурай элсэн хаялгаар ургана.

**Тархалт:** Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Говь-Алтай, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Зүүн гарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойротг тохиолдоно.

*Хүснэгт 10. Элсний цулхирын (Цульхир, хатгуурт цульхир, шивуурт цульхир, дэрвээн цульхир, элсний цульхир, сульхар, сульхир) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өлзийт	Сумын төвөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана –харганат хээр.	Дорнод говь	44° 59' 22.5" 106° 23' 32.4"

**Тархай, нөөц:** Дундговь аймгийн Өлзийт сумын Тахилга уулын зүүн урл хэсгийн элсний зарим хэсэгт sol арвитай ургана.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Цулихирын бүрэн боловсорч гүйцсэн үед /8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр/ шигүү урт шүдтэй сэрээ, савраар доороос нь өлгөн түүж цайруулна.

Цулихирын үрийг хоол хүнсэнд хэрэглэхдээ дахин сайн хуурч болгоод ууранд хийж нүдэж нунтаглах буюу тээрэмд хийж гурил болтол тээрэмдэж цайнд үйх юмуу, сүү,

цөцгийй, шар тос, элсэн чихрээр амтлан арвайн гурил мэт зуурч хүнсэнд хэрэглэхээс гадна элдэв төрлийн гурилан боов, талханд хольц болгон хэрэглэнэ. Мөн хуурсан цулихирыг шар ба цагаан будааны оронд махтай хоолонд хачир болгон хэрэглэнэ. Ардын эмнэлэгт амьсгалын зам, элэг цөсний өвчин анагаахад хэрэглэж байжээ.

Сүүлийн жилүүдэд хувь хүмүүс энэ ургамлын үрийг их хэмжээгээр бэлтгэн хэрэглэж байгаагаас бүс нутгийн ургамалжилт, ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлж эхлэсэн тул Засгийн газрын тогтоолоор (2004) ховор ургамлын жагсаалтанд оруулсан байна.

### АШИГЛАЛТАНД ӨРТӨМТГИЙ АШИГТ УРГАМАЛ

#### ДОЛГИОТСОН ГИШҮҮНЭ, Гишүүнэ, айргана, цоор, цооргоно, жумз

Латин нэр: *Rheum undatum L.*

Орос нэр: Ревень волнистый


Англи нэр: Walyleaved Rhubarb, Bucharian Rhubarb

**Ангилалзүйн шинж:** Олон наст 1.6 м хүртэл өндөр иштэй ургамал. Хүрэн хайрст бүдүүн бахим үндэстэй. Захаараа үргэлж зүрхэрхүү суурьтай цөөн тооны том далвагар навчтай. Улбар ногоондуу, заримдаа шаргал цэцэг бүхий залаа баг цэцэг үүсгэнэ(23-р зураг).

**Ургах орчин:** Хээрийн бүс, уулын ойн ба ойт хээрийн бүслүүрт уулын хажуу, чулуу, хадтай энгэр, хормой, бэл, эрэг, мөргүү, тарваганы дош, айлын бууц, гуу жалга, эргийн хайрганд мөн түүнчлэн голын эргийн шугуй, сөөг, эрэг орчмын чийгтэй нугад хүртэл ургана. Заримдаа дэд тагийн бүслүүрт ургана. Дээрх ургах орчинд алаг цоог буюу уулын хээрийн үетэн-элдэвөвст эвшилд тохиолдоно.



Долгиотсон гишүүн



Долгиотсон гишүүнийн тархай

**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорноговь, Говь-Алтайн тойргуудад буюу Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгийн нутгуудад тохиолдоно.

*Хүснэгт 11. Долгиотсон гишүүнийн (Гишүүнэ, айргана, цоор, цооргоно, жумз) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс-алагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу	Бүйлээс- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)	46° 13' 00.6" 106° 03' 11.3"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн зарим сумдын нутагт туйлын алаг цааг, sol арвитай ургана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Гишүүний үндсийг бага тунгаар хэрэглэхэд суулга тогтоох ба дунд тун нь цөс ялгаруулж, их тун нь туулгах үйлдэлтэй. Үндэсний бэлдмэл нь Bact. proteus vulgaris, Bact. subtilis, Bact. friedlandri зэрэг нянгийн өсөлтийг саатуулах үйлдэлтэй нь тогтоогдсон.

Одоогийн байдлаар эмийн зориулалтаар бус навчны бариулаар чанамал хийх зорилгоор түгээмэл ашиглаж байна. Газрын дээд хэсгийг ашигладаг болохоор нөөцдөд төдийлөн нөлөө багатай. Үрээр хялбархан тарималжих боломжтой учраас плантаци байгуулан технологи боловсруулж сайн чанарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх ашиглах бололцоотой.

### НАМХАН ГИШҮҮНЭ, бажууна

Латин нэр: *Rheum nanum Sievers.*

Орос нэр: Ревень низкий

Англи нэр: Low Rhubarb

**Ангилалзүйн шинж:** Иш нь 10-20 см өндөр олон наст өвслөг ургамал. Навч 5-15 см өргөн дугараг, ногоон хүрэн өнгөтэй, дээд талдаа бэрсүүтэй, 2-3-аараа газраар дэлгэж ургасан байдаг. Навчны гадарга гурван судалтай. 5-р сард ургаж эхлэх ба 9-р сарын сүүл хүртэл вегетаци үргэлжилнэ.



Намхан Гишүүнэ



Намхан Гишүүний тархац

**Ургах орчин:** Цөл, заримдаг цөлд тархсан ургамал бөгөөд уулын хормойн хайрга чулуутай хажуу, хад, асгарга хайргатай бэл, сайд дагаж тохиолдоно. Цөл, цөлийн хээрийн баглуур, бударганат эшилд тохиолдоно.

**Тархалт:** Монгол Алтай, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өөр говь, Алашаа говийн тойрот тархан ургана.

#### Хүснэгт 12. Намхан гишүүнийн (бажсууна) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Хармаг- бударганат элсэрг хотгор.	Дорнод говь	44° 56' 14.2" 107° 44' 57.7"
Өлзийт	Ухаа худагийн говийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгойгоос баруун урагш 12 км-т. Өөш манхан явах замд	Баглуурт цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 50' 25.0" 107° 31' 52.3"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"
Өлзийт	Сумын төвөөс баруун урагш 65 км-т.	Алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 33' 20.1" 105° 54' 01.6"
Баянжаргалан	Сумын төвөөс урагш 52 км-т, Өмнөговийн Манлай сум явах замд.	Үетэн- шарилж- алагөвст цөлөрхөг хээр.	Дорноговь (жинхэнэ)	45° 28' 06.8" 107° 33' 05.1"

**Тархац, нөөц:** Тархцынхаа хүрээн маш сийрэг ургах тул гарц-нөөцийн материал бүрдээгүй болно.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Үндэслэг ишийг намар ухаж аваад нунтаглаж тостой холих юмуу чанаж хүнсэнд хэрэглэнэ. Цардуул ихтэй учраас гурилархаг хүнс болох тул төрөл бүрийн боов зэргийн хийнэ. Зун ургадаг, жил бүр ногоордоггүй. Ганд онц тэсвэртэй ургамал тул зарим найлзуур гантай хуурай зунаар барахгүй бороотой чийглэг

зун ч ургалгүй тайван байдалд орж чадна. Намар үр бүрэн боловсorsны дараа үндэслэг ишийг ухаж авч хүнсэнд хэрэглэх шаардлагатай.

### ЮЛДЭН ТАРВАГАНШИЙР.

Дагуур тарваган шийр, тарваган шийр  
Латин нэр: *Thermopsis lanceolata R.Br.=Th. dahurica Czebr.*

Орос нэр: Термопсис ланцетовидный, Термопсис даурский

Англи нэр: Lanceolata Thermopsis, Dahurian Thermopsis

**Ангилалзүйн шинж:** Шар өнгийн цэцэгтэй, гурамсан навч бүхий 15-35(40) см өндөр ургадаг олон наст өвслөг ургамал(27-р зураг).

**Ургах орчин:** Ойт хээр, хээрийн чулуурхаг, хайргархаг хажуу, нуур, гол, булгийн эрэг, хээрийн хужирлаг нуга, уулын хээрийн хотос дагуу болон суурин газрын ойролцоо ургана.

Юлдэн Тарваган шийр ленийн ботууль, биелэг, нангид хиаг, байгалийн хялгана, крыловын хялгана түүнчлэн агь, ширэг улалж зонхилсон эвшлүүдэд голчлон ургах бөгөөд дэрвээн хазаар, даагансүүл, саман ерхөг, сибирь зөрөвс, харгана зонхилсон эвшлүүдэд тохиолдоно.

**Тархалт:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монголын тойрог, Архангай, Дорноговь, Дорнод, Баянхонгор, Булган, Өмнөговь, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгуудын нутагт ургана.


Судалгаагаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Чойрын Богд уул, Бухын хоолой орох замд, Их хэт сумын Бүсийн чулуу, Дэлгэрэх сумын төвийн тус тус тархан ургана

*Хүснэгт 13. Юлдэн тарваганийрийн (Дагуур тарваган шийр, тарваган шийр) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Хулд уулын баруун хоолой.	Монгол өвс- дэрс оролцсон харганат хээр.	Дорнод говь	45° 10' 37.8" 105° 16' 22.0"



Юлдэн тарваган шийр



Юлдэн тарваган шийрийн тархац

**Тархац, нөөц:** Судалгааны явцад Дундговь аймгийн Хулд сумын Хулд уулын баруун хоолойд *sol* аривтай ургана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Ханиад, амьсгалын замын болон уушигний өвчинд хэрэглэнэ. Тарваган шийрийн эмээр бэлтгэсэн өвсийг уушигны хатгалгаа, мөгөөрсөн гуурсан ба цагаан хоолойн үрэвсэл, ханиалга, томуу ханиад зэрэг өвчний үед цэр ховхлох зорилгоор хэрэглэнэ.

Энэ ургамлын газрын дээрх хэсгээр бэлтгэсэн түүхий эдээр эмийн үйлдвэрүүд “Чигатусин”, “Читамон” зэрэг эм үйлдвэрлэдэг.

Зун намар газар дээрхи хэсгийг авч цэвэрлээд хатааж хэрэглэнэ. Уг ургамлыг цэцэглэлт дуусах үед нь газрын дээрх хэсгийг хадах юмуу хутга хайчаар хяргаж авна. Бэлтгэхдээ ишний угыг 3-5 см өндөр үлдээх хэрэгтэй энэ нь нөхөн сэргээлтэнд сайнаар нөлөөлдөг. Газрын дээд хэсгийг хайчлан аваад наранд буюу хатаагч шүүгээнд 40-45°C хэмд хатаана. Буурцгийг бүрэн боловсорсон үед түүгээд наранд тавьж, үрийг ялгаж авна. Дээжийг даавуу, цаасан уут болон таар уутанд 2 жил хадгална.

## ГОВИЙН ГАНГА

Латин нэр: *Thymus gobicus Tschern.*

Орос нэр: Тимьян гобийский, Чабрец гобийский


Англи нэр: Gobian Thyme

**Ангилалзүйн шинж:** Иш үл мэдэгдэм дөрвөн талтай, 2-5 см өндөр, ёзоороороо салаалсан, газраар ширэлдэн ургадаг заримдаг сөөгөнцөр. Баг цэцэг хөхөвтөр-ягаан юмуу ягаан өнгөтэй, анхилуун үнэртэй(30-р зураг).

**Ургах орчин:** Ойт хээр, хээрийн бүсэд бол уулын чулуурхаг хайргат хажуу, нураг, байц; говийн бүсэд бол цөлийн хээр, эргийн хайрга, элсэнд ихэвчлэн ургана. Дээрх орчин нөхцөлд үетэн-элдэв өвст уулын хээрт зонхилогч болон дэд зонхилогчийн үүрэгтэй ургадаг.



Говийн ганга



Говийн гангын тархац

**Тархалт:** Хөвсгөл (өмнөд), Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай (Тайширын уул, Хасагт Хайрхан), Дундад Халх, Дорнод Монгол (Шилийн Богд уул), Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтайн тойрогт Архангай, Баянхонгор, Булган, Дорнговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгуудын нутагт ургана.

#### Хүснэгт 14. Говийн гангын тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана-монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"
Адаацаг	Сумын төвөөс баруун урагш.	Монголөвс-хялгана- харганат хээр	Дундад Халх	46° 17' 05.1" 105° 27' 11.6"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Рашаант багын нутгаар, Адаацаг сумын Их Адаацаг уул, Бага газрын чулуунд болон түүний орчим толгодоор sol арвтай ургана.

**Ашиглах байдал:** Газрын дээд хэсгийг нь ханиад хүрэх, толгой өвдөх, хоолны шингэц муудах, устай зүйлээр удаан гүйлгэх, цусны даралт ихсэх зэрэгт хэрэглэнэ. Өт хорхой, шавьж, нохой бөөс зэргийг устгахад хэрэглэнэ. Мөн хандалж үс уртуулах зорилгоор хэрэглэдэг.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Цэцэг дэлгэрсэн (6,7-р сард) үед өвс буюу газрын дээд хэсгийг хайчилж аваад хатаж өгөршсөн, гэмтэж муудсан, хатаж шарласан зэрэг элдэв хольцоос цэвэрлэж хатаагаад хэрчиж хэрэглэнэ.

#### ҮМХИЙ БУРЖГАР, Өмхий буржгар, буржгар, огор, цөс өвс

Латин нэр: *Thalictrum foetidum L.*


Орос нэр: Василистник вонючий

Англи нэр: Meadowtrue, Glandularhairg Meadowrue

**Ангилалзүйн шинж:** Үндэслэг иштэй, үмхий үнэртэй булчирхайгаар бүрхэгдсэн олон наст өвслөг ургамал. Иш 15-30 см өндөр. Навч жижиг, шүдлэг захтай, дугариг өндөг, гурвалсан болон дөрвөлсөн өдлөг хэлбэртэй. Дагавар навч болон навчинцаргүй. Навчны илтэс гурав буюу дөрвөнтөө өдлөг. Сийрэг залаа баг цэцэгтэй. Дохиур олон. Жимс суумал, өндөгөрхүү ба зууван хэлбэртэй).



Үмхий буржгар



Үмхий буржгарын тархац

**Ургах орчин:** Байц цохио, хайргат юмуу чулуурхаг хээржүү хажуу, сийрэг хуурай шинэсэн ой, түүний чөлөөнд ургана.

**Тархац-байришил:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дорнод Монгол, Дундад Халх, Их Нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Монгол Алтай, Дорноговь, Говь-Алтайн тойрогт ургана. **Орон нутаг дахь тархац-байришил:** (33-р зураг, 15-р хүснэгт).

*Хүснэгт 15. Үмхий Буржгарын (Өмхий буржгар, буржгар, огор, цөс өвс) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ. Ерлөг уул. Хархадны тохой	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 52' 08.6" 107° 12' 18.2"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Гариц-нөөц:** Адаацаг сумын Адаацаг ууланд уулсаар 10 га талбайд 150 кг биологийн нөөцтэй, 15 кг бэлтгэлийн нөөцтэй гэсэн урьдчилсан дүн гарлаа.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Газрын дээд хэсэг, үндсийг нь яр шарх эмчлэхэд мөн халуун намдаах, халдварт өвчин, суулгах өвчнийг анагаахад хэрэглэдэг.

Цэцэглэлтийн үед нь өвсийг /газар дээрх хэсгийг/ бэлтгэж муудсан хэсэг, элдэв хольцоос цэвэрлэн сүүдэрт хатааж хэрэглэнэ.

## ОЛСЛИГ ХАЛГАЙ, Халгай, үхэр халгай, халаахай, халхай

Латин нэр: *Urtica cannabina L.*

Орос нэр: Крапива коноплевая

Англи нэр: Hempleaf Nettle, Kentucky Hemp.


**Ангилалзүйн шинж:** Эгц шулуун, 50-120 см өндөр иштэй, олон наст өвслөг ургамал. Сарвуулаг цуулбар, 3-5 өдлөг хэрчлээст, шүдлэг салбан бүхий 12 см урт навчтай. Эр цэцэг нь ишний дунд хэсгийн навчны өвөрт майрлаж байхад эм цэцэг нь ишний дээд хэсгийн навчны өвөрт байрлана(34-р зураг).

**Ургах орчин:** Голын эрэг, сөөгөн ширэнгэт шугуйн зах хөвөө, хад асга, үхэр чулууны ёроол, шинэсэн ой, ам хөндийн эхэнд ургадаг. Малын хашаа, айлын бууц, хогийн газраар ч тохиолдоно.

**Тархалт:** Хангай, Монгол Дагуур, Хэнтий, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Говь-Алтай, Зүүнгарын говийн тойргуудад тархан ургана.



Олслиг халгай



Олслиг халгайн тархац

Хүснэгт 16. Олслиг халгайн (Халгай, үхэр халгай, халаахай, халхай) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян уул.	Шарилж-үтэктэнт, алаг өвс-үтээн-шарилжит эвшилд.	Дорнод говь.	46° 33' 38.2" 107° 50' 13.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ. Ерлөг уул. Хархадны тохой	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 52' 08.6" 107° 12' 18.2"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялганы- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялганы- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Тархац, нөөц:** Энэ ургамал нь хүмүүсэг (хог-хөл газрын) ургамал тул тархац байршлын хувьд сум суурин, малын хашаа, айлын бууц, хогийн газраар элбэг тохиолдог учраас гарц нөөцийн судалгаа хийгээгүй.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Ишний хальсны ширхэгээр нэхмэл эдлэл хийх (утас ээрч, нэхмэл бөс даавуу) ба иш, навч нь арьс эдээлгийн түүхий эд болно.

Монголчууд Халгайг залуу байхад нь (сөөм хиртэй) түүн авч чийг бам хөдлөхөд тамир тэнхээ оруулах зорилгоор буцалгаж юмуу битүү (бууз, хуушуур г.м.) хоолонд хольж хэрэглэгдэг бөгөөд хоол амт оруулах, ногоотой шөл бэлтгэхэд навчийг хэрэглэдэг. Хавар эрт нялх Халгайг хярган авч угааж цэвэрлээд хатаах юмуу нойтноор бууз, баш, хуушуур зэрэг хоолонд хэрэглэнэ.

## БҮНГИЙН ЦАХИЛДАГ

Латин нэр: *Iris bungei* Maxim.

Орос нэр: Ирис (касатик) Бунге

Англи нэр: Largebract Iris


**Ангилалзүйн шинж:** Навчис шугаман, нарийхан, 2-4 мм өргөн, нягт дэгнүүтлүүсгэдэг, 20-30 өндөр, олон наст өвслөг ургамал. Цэцэглэгч иш олон бөгөөд тус бүртээ 1-3 цэцгтэй(34-р зураг).

**Ургах орчин:** Элсэрхүү, элс-хайрган цөлийн хээр, толгодын бутармаг-чулуурхаг хажуу, сайрын зах, ёроолд ургана.

**Тархалт:** Дундад Халх, Олон нуурын хөндий, Лонрод говь, Говь-Алтайн тойрогт тохиолдоно.



Бүнгийн цахилдаг.



Бүнгийн цахилдгийн тархай

Хүснэгт 17. Бүнгийн цахилдагийн (Хосхайрст цахилдаг, сахилдаг)  
тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – харганат хээр.	Дундад Халх	45° 59' 48.1" 107° 35' 19.2"
Баянжаргалан	Хавирга уулын урд толгодын дунд.	Таанат хээр.	Дундад Халх	45° 47' 17.3" 107° 44' 22.9"
Баянжаргалан	Баянжаргалан сумаас Өндөршил явах замд, толгодын дунд.	Хялгана-харгана- таанат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"

Өлзийт	Сумын төвөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана – харганат хээр.	Дорнод говь	44° 59' 22.5" 106° 23' 32.4"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уулын зүүн хажуу.	Дэрс – харганат сайр.	Дорнод говь	45° 12' 19.4" 104° 56' 54.2"
Адаацаг	Бага газрын чулуу. Улиас бүхий хийдийн турьтай ам	Улиас- бүйлэст хадан ам.	Дундад Халх	46° 13' 00.6" 106° 03' 11.3"
Дэрэн	Дэрэнгээс баруун тийш 3 км-т Дэлгэрцогт явах замд.	Хайлаас- дэрстэй ам.	Дундад Халх	46° 10' 47.9" 106° 41' 30.1"

**Тархац, нөөц:** Гарц нөөцийн материал бүрдээгүй.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Монгол уламжлалт анагаах ухаанд үндэс, үндэслэг ишийг хodoодонд халуун, хүйтэн хямрах өвчин анагаах, бэртэж хугарсан шархны гэм эмчлэх зэрэгт тус тус хэрэглэнэ.

### ЦАГААЛИН ЦАХИЛДАГ, Хосхайрст цахилдаг, сахилдаг

Латин нэр: *Iris lactea Pall..*

Орос нэр: Ирис (касатик) молочно-белый, пикулька


Англи нэр: Whiteflower Iris

**Ангилалзүйн шинж:** Өтгөн саглагар олон үндэс бүхий, баихим үндэслэг иштэй, том дэгнүүл үүсгэн ургадаг 30-40 см өндөр ургамал. Ишний уг орчмоос бөөндүү гарсан шугаман буюу сэлмэн хэлбэрийн ногоон навчистай, тэр нь цэцэглэх ишнээс өндөр байдаг. Том сайхан цайвар, цайвар хөх буюу хөх хөвхөр нил цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний хоолой нь дэлбэнгээсээ олон дахин богино.

**Ургах орчин:** Нуур, гол булгийн марцлаг эрэг, хайрга, марцлаг нугад ургах бөгөөд Цахилдагт нуга, гол горхийн шанд, булаг, давстай нуурын ойролцоо хуурай амны давстай ёроолооп ул хөрсний ус ойртой нам дор газраар татмын төв ба гульдралын хэсэг дэнжийн хормой, ёроол дагаж марцлаг дэрстэй хотгордуу газраар томхон талбай эзлэн ургадаг.



Цагаалин цахилдаг



Цагаалин цахилдгийн тархац

**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх (баруун хэсэг), Дорнод Монгол (Халх гол), Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий (Богд сум), Дорноговь, Говь-Алтай, Алашааны говийн тойргуудад ургана.

*Хүснэгт 18. Цагаалин цахилдагийн (Хосхайрст цахилдаг, сахилдаг)  
тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – харганат хээр.	Дундад Халх	45° 52' 26.3" 107° 41' 08.0"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ. Ерлөг уул. Хархадны тохой	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 52' 08.6" 107° 12' 18.2"
Хулд	Хулд уулын урд хэсэг, энгэр.	Монгол өвс- харгана- алагөвст хээр.	Дорнод говь	45° 13' 28.8" 105° 34' 09.3"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уул. Давааны оройд.	Боролз – бүйлс - алагөвст хээр.	Дорнод говь	45° 11' 48.9" 104° 46' 16.7"
Дэлгэрхангай	Сумын төвөөс Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 23' 32.5" 104° 24' 22.0"
Сайхан-Овоо	Дэлгэрхангайгаас Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- таана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 25' 07.6" 104° 03' 25.6"
Дэрэн	Дэрэнгээс баруун тийш 3 км-т Дэлгэрцогт явах замд.	Хайлаас- дэрстэй ам.	Дундад Халх	46° 10' 47.9" 106° 41' 30.1"

**Тархац, нөөц:** Гарц нөөцийн материал бүрдээгүй.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Энэхүү цахилдгийн үндэс, үндэслэг иш, үр цэцгийг монгол уламжлалт эмнэлэгт хodoод гэдэсний өвчин, элэгний өвчин анагаах, суулга тогтоох, хорт хавдар эмчлэх зэрэгт тус тус хэрэглэнэ. Үрээр сайн үрждэг, чимэглэлийн ач холбогдолтой ургамал. Үрээр тарьсны хойтон жил цухуйж хоёрдох жилээс цэцэглэнэ.

### НАРИЙН НАВЧИТ ЦАХИЛДАГ, Цулбуур өвс, тахь өвс, оонын сахал

Латин нэр: *Iris tenuifolia Pall.*

Орос нэр: Ирис тонколистный

Англи нэр: Slenderleaf Iris


**Ангилалзүйн шинж:** Нягт дэгнүүл бүхий 5-10 см өндөр ургадаг олон наст өвслөг ургамал. Ишний угийн навчис үетнийх шиг шугаман утсархуу маш урт нарийн, дагуудаа хийлаасан, тахиралдсан, 40 см хүртэл урт, 1-1.5 мм өргөн, ширүүн, саарал ногоон, салмарч задарсан хүрэн өнгийн үлдмэл угларгатай. Цайвар-хөх юмуу нил цэцгүүд дэгнүүлээсээ дөнгөж цухуйж хосоор байрлана. Хонхорцог нь 2.5-4 см урт, зууван, богино шонтонтой. Үр далавчгүй (38-р зураг).

**Ургах орчин:** Нарийннавчит Цахилдаг-*Iris tenuifolia Pall.* Монгол орны хуурай хээрийн урьд зах, цөлөрхөг хээр буюу заримдаг цөлийн бүсийн элсэрхэг болон хайргархаг-элсэрхэг хөрсөнд ургана. Өндөршилийн хувьд энэ жилийн судалгаагаар д.т.д. 1000-1400 метрийн өндөрт ургаж байна. Цаг-уурын хувьд жилд дунджаар 100-300 мм хур

тундасны унадаг, 7-р сард  $+15^{\circ}\text{C}$ -ээс их темпаратуртай, 1-р сард  $-20^{\circ}\text{C}$ -ээс дээш темпаратуртай хэсэгт ургадаг, элссэг-хуурайсаг ургамал болно.



Нарийн навчим цахилдаг



Нарийн навчим цахилдаг

**Тархалт:** Монгол Алтай(Хасагт Хайрхан, дорнод хэсэг)-н уулын хээрийн; Дундад Халхын ба Дорнод Монголын хээрийн; Их нууруудын хотгор(Боригдэлийн элс, Хүнгүй гол)-ын, Олон нуурын хөндийн болон Дорноговийн цөлөрхөг хээрийн; Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн, Зүүнгарын говь-(хойт хэсэг)-ийн цөлийн тойргуудад буюу Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Увс аймгуудын зарим сумдын нутагт тархан ургана.

*Хүснэгт 19. Нарийн навчим цахилдгийн (Цулбуур өвс, тахь өвс, оонын сахал) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Эрдэнэдалай	Сумын төвөөс урагш 30 км-т Улаанбаатараас Даланзадгад орох төв замд, багийн төвийн хойно (Эрдэнэдалайгаас Мандал-Овоо орох зам ).	Харгана- таана- монгол өвст цөлөрхөг хээр.	ДундадХалх (жинхэнэ)	$45^{\circ} 46' 12.0''$ $104^{\circ} 46' 06.0''$
Өндөршил.	Сумын төвийн урд, ШТС-ын дэргэд, Өнчин цагаан нуурын хойт хөндий.	Үетэн- шарилж- алагөвст хээр	Донод Говь (дорнод)	$45^{\circ} 13' 41.2''$ $108^{\circ} 17' 04.0''$
Өндөршил.	Сумын төвөөс баруун тийш 37 км-т, Тоодогийн говь.	Үетэн- алагөвст хээр	Дорноговь (жинхэнэ)	$45^{\circ} 05' 038''$ $107^{\circ} 54' 587''$

**Тархац, нөөц:** Тархалтын нутагтаа маш сийрэг, sol аривтай ургаж байна.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Уламжлалт эмнэлэгт үндсийг яс, үе, бөөрний халуун өвчин, элдэв бэртэнг, хорхойн өвчнийг туулгах, шарх анагаах, бөөр давсагны өвчнийг анагаахад хэрэглэдэг ба савны хавдарт тустай. Гэдэсний цагаан хорхой, түлэнхийг анагаана. Монгол эрдэмтэд “Моносфарм” ХХК-тай хамтран энэ ургамлын

үндэснээс полифенолын нэгдэл бүхий бөөрнийг хамгаалах үйлдэлтэй Нефромон(MNS 5099:2001) хэмээх шингэн эм үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

### АЛАГЦЭЦГТ БАШИР, Алаг башир

Латин нэр: *Dianthus versicolor Fisch.*

Орос нэр: Гвоздика разноцветная

Англи нэр: Colour-changing Pink, Versicolor Pin

**Ангилалзүйн шинж:** Дэлбийн хэлтэс улаан ягаан, дэлбэн нь 10-12 мм урт, үзүүрээдээ шүдэрхэг, сууриадаа үсэрхэг; цоморлиг 15 мм урт; цэцэглэх ишний үзүүрт ганц цэцэгтэй(40-р зураг).



Алагцэцэгт башир



Алагцэцэгт баширын тархац

**Ургах орчин:** Хайргат ба чулуурхаг хуурай хажуу, хээржүү нуга, тэгш талд ургана.

**Тархалт:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Монгол Алтай, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтайн тойрогт ургана.

*Хүснэгт 20. Алагцэцэг баширын (Алаг башир) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 12' 01.6" 106° 02' 03.5"

**Тархац, нөөц:** Алагцэцэгт башир нь Дундговь аймгийн Адаацаг сумын Их Адаацаг, Бага газрын чулуунд үетэн-алагөвс-бүйлсэт эвшилд sol арвигтай ургана.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Алаг цэцэгт Бashiрын газрын дээрх хэсгийн идээшмэл ханд нь цусны даралт бууруулах, цусны ханыг тэлүүлэх, шээлгэх үйлдэлтэйн дээр төв мэдрэлийн тогтолцоог хориглох үйлдэлтэй, мөн умайн агшилтыг дунд зэрэг идэвхжүүлдгийг судалгаагаар тогтоосон.

Энэхүү ургамлыг нутгийн ард иргэд үйлдвэрлэлийн бус гэр булийн хэрэгцээнд бага хэмжээгээр хэрэглэдэг.

**ЗЭЛ ЗАНГУУ,** Нохой зангуу, хэвтээ зангуу, наанги зангуу, хээрийн зангуу, зэрлэг зангуу, ямаан зангуу.

Латин нэр: *Tribulus terrestris L.*

Орос нэр: Якорцы стелюющиеся

Англи нэр: Puncturevine Caltrap


**Ангилал зүйн шинж:** Мөчирлөн салаалсан 50 см хүртэл урт дэлхээ иштэй, тавчилсан шаравтар цэцэг нь нэжгээдээр байрласан, олон наст өвслөг ургамал. Навчис 6-8 хос өдлөг, дээд тал нүцгэн, доод тал нь ишний адил урт үсэрхэг. Үр жимс нь бөөрөнхий, хуурай нэг үрт 5 хэсэг болон салдаг. Хэсэг тус бүрт хурц хатгууртай.

**Ургах орчин:** Цөл, цөлөрхөг хээр, хээрт талхлагдсан бэлчээр, суурин газар, зам дагуу, худаг орчим, мөн сайд элстэй ёроолоор ургана.

**Тархалт:** Хангай (өмнөд), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь, Зүүнгарын говийн тойрот ургана.



Зэлэн Зангуу



Зэлэн зангуугийн тархац

*Хүснэгт 21. Зэлэн зангуугийн (Нохой зангуу, хэвтээ зангуу, наанги зангуу, хээрийн зангуу, зэрлэг зангуу, ямаан зангуу) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өндөршил	Өөш манхан орох замд. Өөш манханы амралтаас хойш.	Үетэн- алаговст цөлөрхөг хээр.	Дорноговь (жинхэнэ)	44° 49' 35.8" 107° 29' 21.9"

**Тархац, нөөц:** Энэ ургамал тархацынхаа хүрээнд маш сийрэг ургадаг. Бидний судалгаагаар Өөш манханд суль бүхий элсэнд sol аривтай ургана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Монгол эрдэмтдийн бүтээсэн склерон хэмээх эмийн найрлагад жимстэй ногоо нь ордог, мөн эквиман гэдэг эмийн найрлагад ногоо нь ордог. Өнгөрсөн зуны сүүлээр уламжлалт анагаах ухааны хүрээлэн бэлтгэж дээрх эмийг хийдэг байсан.


### ХӨМӨЛ, Монгол сонгино

Латин нэр: *Allium mongolicum Rgl.*

Орос нэр: Лук монгольский

Англи нэр: Mongolian Onion

**Ангилалзүйн шинж:** 10-20 см өндөр бөөрөнхий гөлгөр иштэй. Хөрсөнд хөндлөн байрласан үндэслэг иштэй, нарийн булцуунуудтай, багатар дэгнүүл үүсгэдэг. Дэгнүүлийн уг салмарч нарийн ширхэгүүд болдог шаравтар өнгийн бүрхүүлээр битүү хучигдсан байдаг. Навч нь үндэснийхээ орчмоос багцлан гарсан бортгон хэлбэрийн, шүүсээр дүүргэгдсэн цайвар хөх, хөх ногоон өнгө, өвөрмөц өнгөртэй. Шүхэр нь олон цэцэгтэй,



сийрэг цэцэг нь том, улбар ягаан өнгөтэй байна(44-р зураг).

Хөмөл

Монгол сонгино (хөмөлийн) тархац

**Ургах орчин:** Говийн уул толгодын бэл, хормой, тал хөндий, дэрс, товцог, бут бударганын зайд чөлөөгөөр ургана. Хөмөл нь заримдаг цөл, цөлийн ургамалжилтад зонхилогч болон дэд зонхилогчоор ургана.

**Тархалт:** Хангай, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн цаад говь, Алашаа говийн тойротг ургана.

Хүснэгт 22. Хөмөлийн (Монгол сонгино) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Говь-Угтаал	Сумын төвөөс зүүн урагш 20 орчим км-т.	Хялгана – харганат хээр.	Дундад Халх	45° 59' 48.1" 107° 35' 19.2"

Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – хазаар өвс-харганат хээр.	Дундад Халх	45° 52' 26.3" 107° 41' 08.0"
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Монгол өвс-таана-бударганат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Хармаг-бударганат элсэрэг хотгор.	Дорнод говь	44° 56' 14.2" 107° 44' 57.7"
Өлзийт	Өөш манхан, Хөтөл уулын баруун хажуу.	Харгана- бударгана-таанат элсэрэг хажуу.	Дорнод говь	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Өлзийт	Сумын төвөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана –харганат хээр.	Дорнод говь	44° 59' 22.5" 106° 23' 32.4"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уулын зүүн хажуу.	Дэрс – харганат сайд.	Дорнод говь	45° 12' 19.4" 104° 56' 54.2"
Дэлгэрхангай	Сумын төвөөс Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 23' 32.5" 104° 24' 22.0"
Сайхан-Овоо	Дэлгэрхангайгаас Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- таана-монголөвст хээр.	Дорнод говь	45° 25' 07.6" 104° 03' 25.6"
Сайхан-Овоо	Онгийн хийд, хадтай уулын энгэр.	Харгана- монголөвст хээр.	Олон нуурын хөндий.	45° 21' 45.8" 104° 02' 11.6"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"
Дэлгэрцогт	Дэлгэрцогтоос Улаанбаатар явах төв замын дэргэд.	Хялгана- таанат хээр.	Дундад Халх	46° 07' 41.8" 106° 29' 22.8"
Өлзийт	Мандалговиос Өлзийт орох замд, аймгийн төвөөс 30 км-т	Үетэн- элдэвавст хуурай хээр	Дундад Халх	45° 27' 49.8" 106° 15' 59.3"
Өлзийт	Мандалговиос Өлзийт орох замд, Өлзийт сумын төвөөс хойш 30 км-т	Үетэн- элдэвавст хуурай хээр	Дундад Халх	45° 12' 42.7" 106° 18' 01.6"
Сайхан-Овоо	Онгийн гол. Сумын төвөөс хойш 18 км-т Шар эрэг хэмээх газар	Голын алагөвст татам	Дорноговь, Олон нуурын хөндийн хил	45° 33' 08.6" 103° 44' 04.7"
Адаацаг	Сүм хөх бүрдээс урагш 30 гаруй км-т, Хөвийн хоолойн урд Хадат улааны уулын “Шувуу зулзгалдаг хад”. Д.т.д. 1371 м.	Хазаар өвс- харганат хээр	Дорноговь	45° 40' 849" 105° 06' 072"
Эрдэнэдалай	Сумын төвөөс урагш 30 км-т Улаанбаатараас Даланзадгад орох төв замд, багийн төвийн хойно (Эрдэнэдалайгаас Мандал-Овоо орох зам).	Харгана- таана- монгол өвст цөлөрхөг хээр.	Дорноговь (жинхэнэ)	45° 46' 11.2" 104° 46' 01.7"
Өндөршил	Сумын төвөөс баруун тийш 37 км-т, Тоодогийн говь.	Үетэн- алагөвст хээр	Дорноговь (жинхэнэ)	45° 05' 038" 107° 54' 587"

Өлзийт	Ухаа худагийн.govийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгой.	Харгана- хотир- алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 49' 518" 107° 37' 186"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"
Адаацаг	Бага газрын чулуу	Бүйлээс- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)	46° 13' 10.1" 105° 59' 31.4"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 9 км-т. Өмнөговийн Манлай явах замын дэргэд.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 37' 22.3" 106° 53' 57.3"
Сайнцагаан	Мандалговиос баруун урагш 10 орчим км-т Даланзадгад явах төв замын дэргэд. Д.т.д. 1430 м.	Үетэн- таана- алаг өвст хээр.	Дорнод говь (жинхэнэ).	45° 43' 39.2" 106° 09' 08.5"

**Тархац, нөөц:** Хөмөл нь Дундговь аймгийн ихэнх сумдын нутагт нийлээд арвитай ургах ба нийт ойролцоогоор 500000-1000000 га-д sol-корын арвитай ургана. Мөн бус нутгийн ургамлын бүлгэмдэлд доминантнын үүрэг гүйцэтгэдэг бэлчээр, тэжээлийн чухал ач холбогдолтой ургамал билээ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Фитонцид, төрөл бүрийн аминдэмээр баялаг учир.govийн хүмүүсийн дуртай хэрэглэдэг хүнсний ногоо юм. Шинээр нь түүж хоол хүнсэнд хольц болгон хэрэглэх ба даршилж юм уу хатааж зоодой /корын/ болгон удаан хугацаагаар хадгалж хэрэглэнэ.

Хөмлийг түүсний дараа 1-3 хоногийн дотор угааж цэвэрлээд 0.5-1 см хэмжээтэй жижиглэн хэрчээд 1 кг хөмөлд 150-200 г давс байхаар бодож даршлан. Хадгалах хугацаа 5 сар.

**ТААНА,** Үндсээрхэг сонгино, баглагар сонгино, тан, койжуа (казак).

Латин нэр: *Allium polyrrhizum Turcz. Ex Rgl.*

Орос нэр: Лук многокорешковый, Л. многокорневой


Англи нэр: Manyroot Onion

**Ангилалзүйн шинж:** Сонгинолог булцуу үл мэдэгдээ бөгөөд үндэслэг ишэн дээр хэд хэдээрээ чигжүү сууж, нягт бор сааралдуу дэгнүүл үүсгэдэг. Булцууны гадар бүрхүүл ширхэглэг, бараг эсгийлэг, үл мэдэгдээ торлог. 7-9-р сард үрлэнэ.

**Ургах орчин:** Чулуурхаг, хайргархаг цөл, цөлөрхөг хээр, уулын чулуутай хажуу, бэл, хад чулууны ёроол, цав толгодоор ургана.



Таана



Таанын тархцын зураг

**Тархалт:** Хангай (өмнөд бэл), Монгол Алтай (зүүн сэжүүр), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойротгот ургана.

*Хүснэгт 23. Таанын (Үндсээрхэг сонгино, багалгар сонгино, тан, койжсуа - казак)  
тархалт, ургах эвшил*

Сүм	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян уул.	Шарилж-үтэтэн, алаг өвс-үтэтэн-шарилжит эвшилд.	Дорнод говь.	46° 33' 38.2" 107° 50' 13.6"
Говь-Угтаал	Сумын төвөөс зүүн урагш 20 орчим км-т.	Хялгана – харганат хээр.	Дундад Халх	45° 59' 48.1" 107° 35' 19.2"
Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – хазаар өвс-харганат хээр.	Дундад Халх	45° 52' 26.3" 107° 41' 08.0"
Баянжаргалан	Хавирга уулын урд толгодын дунд.	Таанат хээр.	Дундад Халх	45° 47' 17.3" 107° 44' 22.9"
Баянжаргалан	Баянжаргалан сумаас Өндөршил явах замд, толгодын дунд.	Хялгана-харгана-таанат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"
Өндөршил	Сумын төвийн урд нуурын баруун хойно	Монгол өвс-таана-бударганат хээр.	Дорнод говь	45° 13' 33.9" 108° 16' 51.6"
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Монгол өвс-таана-бударганат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Хармаг-бударганат элсэргэг хотгор.	Дорнод говь	44° 56' 14.2" 107° 44' 57.7"
Өлзийт	Сумын төвөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана –харганат хээр.	Дорнод говь	44° 59' 22.5" 106° 23' 32.4"
Гурван сайхан	Өлзийтөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана – таана-харганат хээр.	Дорнод говь	45° 16' 39.1" 106° 40' 04.6"
Гурван сайхан	Сумын төвөөс баруун урагш толгодын дунд.	Монгол өвс- таанат хээр.	Дорнод говь	45° 26' 12.4" 106° 52' 34.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Хулд	Хулд уулын урд хэсэг, энгэр.	Монгол өвс- харганат хээр.	Дорнод говь	45° 13' 28.8" 105° 34' 09.3"
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"

Адаацаг	Сумын төвөөс баруун урагш.	Монголөвс- хялгана-харганат хээр	Дундад Халх	46° 17' 05.1" 105° 27' 11.6"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"
Дэрэн	Дэрэнгээс баруун тийш 3 км-т Дэлгэрцогт явах замд.	Хайлаас- дэрстэй ам.	Дундад Халх	46° 10' 47.9" 106° 41' 30.1"
Дэлгэрцогт	Дэлгэрцогтоос Улаанбаатар явах төв замын дэргэд.	Хялгана- таанат хээр.	Дундад Халх	46° 07' 41.8" 106° 29' 22.8"
Дэлгэрцогт	Цахиурт бр. Цахирин уул.	Харганат хээр	Дундад Халх	46° 28' 00.8" 106° 30' 56.9"
Хулд	Дундговь, Өмнөговь аймгийн заагт төв замын дагуу.	Үетэн- элдэвавс-харганат хээр	Дорноговь	44° 44' 30.0" 105° 32' 11.0"
Өлзийт	Мандалговиос Өлзийт орох замд, Өлзийт сумын төвөөс хойш 30 км-т	Үетэн- элдэвавст хуурай хээр	Дундад Халх	45° 12' 42.7" 106° 18' 01.6"
Сайхан-Овоо	Онгийн гол. Сумын төвөөс хойш 18 км-т Шар эрэг хэмээх газар	Голын алагөвст татам	Дорноговь, Олон нуурын хөндийн хил	45° 33' 08.6" 103° 44' 04.7
Өлзийт	Ухаа худагийн.govийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгойгоос баруун урагш 12 км-т. Өөш манхан явах замд	Баглуурт цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 49' 518" 107° 37' 186"
Баянжаргалан	Сумын төвөөс урагш 52 км-т, Өмнөговийн Манлай сум явах замд.	Үетэн- шарилж- алагөвст цөлөрхөг хээр.	Дорноговь (жинхэнэ)	45° 28' 06.8" 107° 33' 05.1"
Сайнцагаан	Мандалговиос баруун урагш 10 орчим км-т Даланзадгад явах төв замын дэргэд. Д.т.д. 1430 м.	Үетэн- таана- алаг өвст хээр.	Дорнод говь (жинхэнэ).	45° 43' 39.2" 106° 09' 08.5"
Сайхан-Овоо	Сумын төвөөс Эрдэнэдалай орох замд. Төгрөг баг.	Харгана- хазаарөвст хээр.	Дорнод говь	45° 45' 35.6" 104° 26' 05.2"

**Тархац, нөөц:** Таана нь Дундговь аймгийн ихэнх сүмдүүн нутагт нийлээд арвийтайгаар 50000-100000 га-д ургах ба бүс нутгийн ургамлын бүлгэмдэлд доминантнын үүрэг гүйцэтгэдэг бэлчээр тэжээлийн чухал ач холбогдолтой ургамал.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Фитонцид, төрөл бүрийн аминдэмээр баялаг учир.govийн хүмүүсийн дуртай хэрэглэдэг хүнсний ногоо юм. Шинээр нь түүж хоол хүнсэнд хольц болгон хэрэглэх ба даршилж юмуу хатааж зоодой /сорс/ болгон удаан хугацаагаар хадгалж хэрэглэнэ.

### СИБИРЬ ХАРМАГ, товцог, хармаг, сондуул

Латин нэр: *Nitraria sibirica Pall.*


Орос нэр: Селитрянка сибирская

Англи нэр: Siberian Nitraria

**Ангилалзүйн шинж:** Нэг метр хүртэл өндөр хужирлаг элсэн довцог үүсгэдэг, 50-80 см өндөртэй, хэвтээ байрлалтай сөөг. Мөчир салаа ихтэй, цайвар хальсаар хучигдсан хучигдсан өргөслөг байна. Навчис юлдэрхүү. Жижгэвтэр цагаан цэцэгтэй. Яст жимсгэнэ хүрэн улаан, өндгөрхүү, жижигхэн яс нь 4-5 мм урт, голчоороо 2-3 мм. VI-VII сарын эх хүртэл цэцэглэж, VII-VIII сард жимслэнэ (үрлэнэ) (48-р зураг).



Сибирь хармаг



Сибирь хармагийн тархай

**Ургах орчин:** Хужирлаг элсэн дов, сондуул, марз, тойром хийгээд дэрсний зах, сайрын элс бүхий хөвөөнд ургана.

**Тархалт:** Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойргуудын цөл, цөлөрхөг хээрт марц хужиртай, элсэнцэр хөрстэй хотгоруудаар сондуул үүсгэж ургана.

Хүснэгт 24. Сибирь хармагийн (товцог, хармаг, сондуул) тархалт, ургах эвшил

Сум	Газрын иэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өндөршил	Сумын төвөөс баруун урагш Өөш манхан явах замд	Хармаг-бударганат элсэрэг хотгор.	Дорнод говь	44° 56' 14.2" 107° 44' 57.7"
Өлзийт	Өөш манханаас сумын төв явах замд, Хавтгай уулын ар хөндий.	Харгана- бударгана-таанат элсэрэг судаг.	Дорнод говь	44° 48' 57.1" 106° 48' 11.2"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун хойш 12 км-т. Өлзийт с/т явах замын дэргэд.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 45' 18.3" 106° 55' 18.0"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун хойш 33 км-т. Өлзийт с/төөр оролгүй шууд Мандалговь явах замын дэргэд.	Шарилж- хармаг- алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 50' 43.4" 106° 39' 10.9"
Өлзийт	Өөш Манхан, Өлзийт	Заг бүхий үетэн	Дорноговь	44° 41' 12.3"

	сумын төвөөс зүүн урагш 110 км-т	алагөвст манхантай хотгор	(жинхэнэ)	107° 04' 15.9"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уулын урд хоолой.	Заг хармагт элсэн дов.	Дорноговь (жинхэнэ)	44° 56' 49.0" 104° 48' 48.5"
Хулд	Сумын төвөөс баруун урагш.	Дээр- хармагт элсэн хотгор.	Дорноговь (жинхэнэ)	45° 08' 30.4" 105° 06' 28.0"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн Өндөршил, Өлзийт сумдын Ухаа худгийн говь, Заг-Усны говь, Талын хөндийд sol арвтайгаар ургана. Энд хотир- хармагтай элсэргэх хөндийд 2000 га-д 60 орчим тн биологийн, 6 тн бэлтгэлийн нөөцтэй гэсэн урьдчилсан тооцоо гарч байна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Амтлаг, эсгэлэн амттай бөгөөд бүлээн чанартай, биеийг шимжүүлэх, хоол шингээх, сарын тэмдгийн хэм хэмжээг тэгшигтгэх чадалтай. Навчнаас бэлтгэсэн эм нь тайвшуулах ўйлдэлтэй, жимсний чанамал, хандмал, ханд нь зурхний ажиллагааг эрчимжүүлж цусны даралт бууруулна. Гөлгөр булчингийн ажиллагааг сулруулна. Зүрхний ажиллагаа суларч цусны даралт ихсэх, гэдэс базлан суулгах зэрэгт тунг тохируулан хэрэглэнэ. Тун хэтэрвэл амьсгалын төв саатах аюултай ажээ. Намар боловсорсон жимсийг түүж цэвэрлээд сайтар хатааж хэрэглэнэ.

### ШИНЭСЭРХҮҮ БУДАРГАНА, загсагал, харгайрхуу бударгана.

Латин нэр: *Salsola laricifolia Turcz. ex Litv.*

Орос нэр: Солянка лиственницеплистная

Англи нэр: Larschleaf Russianthistle

**Ангилалзүйн шинж:** Хатуу, дэрэвгэр мөчирлөг, тахиралдсан салаатай 30-50 (60) см хүртэл өндөр ургадаг заримдаг сөөг. Иш улаавтар саарал холтостой. Хөгшин мөчир нь бараан саарал юмуу бараг хар бараан, залуу мөчир нь цайвар-саарал юмуу цайвардуу холтостой. Навчис ногоон, багц багцаар байрлах ба богинохон, булархуу түүний орой огцом шөвгөр. Цэцгийн шадар эрхтний навчинцар жимслэх үест далавчнаасаа дээш цул багана болон босч ирнэ.

**Ургах орчин:** Шинэсэрхүү бударгана-*Salsola laricifolia Turcz. ex Litv.* цэлөрхөг хээр, цэлийн бүсийн уул толгодын чулуурхаг, хайргархаг хажуу сайд садаргын ирмэгээр ургах бөгөөд элсэргэх буюу шаранцар хөрсөнд ургадаггүй байна. Бидний судалгаагаар энэ ургамал д.т.д. 1100-1650 метрийн хооронд ургах ба хадархаг, чулуурхаг хөрстэй уулын энгэр хэсгийг дагаж ургана. Уур амьсгалын хувьд жилд 200 мл-ээс бага хур тунадас унадаг, 7-р сард +20<sup>0</sup>-аас дээш температурай, 1-р сард -20<sup>0</sup>C-дээш температуртай хэсэгт ургадаг нь хуурайсаг-чулуусаг ургамал болохыг харуулж байна.



Шинэсэрхүү бударгана



Шинэсэрхүү бударганаын тархалт

**Тархалт:** Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн, Дорнод говийн цөлөрхөг хээрийн, Алашаа говийн цөлийн тойргуудад буюу Дорноговь, Өмнөговь аймгуудын зарим сумдын нутагт тархан ургана.

*Хүснэгт 25. Шинэсэрхүү бударганаын (загсагал, харгайрхуу бударгана)  
тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Өлзийт	Өөш манхан, Хөтөл уулын баруун хажуу.	Харгана- бударгана-таанат элсэрэг хажуу.	Дорнод говь	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Өлзийт	Ухаа худагийн говийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгой.	Харгана- хотир-алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 49' 518" 107° 37' 186"
Өлзийт	Ухаа худагийн говийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгойгоос баруун урагш 4 км-т.	Харгана- хотир-алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг-бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 14 км-т. Цогтцэций явах замд.	Баглуур- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 36' 54.2" 106° 52' 12.4"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 19 км-т. Цогтцэций явах замд.	Баглуур- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 37' 03.5" 106° 50' 45.1"
Өлзийт	Сумын төвөөс хойш 7км-т. Ушигийн уул	Харгана-үетэнт хээр	Дундад Халх (дорнод)	44° 58' 17.1" 106° 17' 14.6"
Өлзийт	Өөш манханы элснээс баруун урагш 9 км-т. Өмнөговийн Манлай явах замын дэргэд.	Баглуур- тэсэг-бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 37' 31.2" 106° 56' 32.4"

Жич: Тэмдэглэхэд Дундговь аймгийн Өлзийт сумын төвөөс хойш 7 км-т Ушигийн уулын хад чулуу бүхий энгэрт ( $44^{\circ} 58' 17.1"$ ,  $106^{\circ} 17' 14.6"$ ) харгана үетэнт хадархаг толгодын дээд хэсэгт ургаж байгаа нь Шинэсэрхүү бударгана-*Salsola laricifolia* Turcz. ex Litv.-ын тархцын хойт хил

боловыг тогтоов. Мөн Гурвансайхан сумын Гурвансайхан ууланд ургадаг тухай нутгийн иргэд мэдээлэл өгч байлаа.

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн Өлзийт сумын Тоодгийн говь болон Өөш манхны орчимд толгодын хооронд нийт 800 га талбайд үетэн- харгана- бударгана- элдэв өвст (*Stipa glareosa*, *S. gobica*, *Allium polorrhizum*, *Salsola passerina*, *S. laricifolia*, *Anabasis brevifolia*, *Kochia prostrata*, *Caragana leucophloea*, *C. pygmaea*) эвшилд sol арвитай ургана.

- 10x10 м<sup>2</sup>-д 3 ш ургамал, 1 ургамал 155 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 46.5 кг; нийт талбайд биологийн нөөц 37.2 т.-оос үйлдвэрлэлийн нөөц нь 3 т. болно.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Газрын хөрсөн дээрх хэсэгт нийлбэр кумарин бий. Монголын эрдэмтэд энэ ургамлаас эм гарган авч түүнийгээ “Салорид” гэж нэрлэсэн билээ. Салорид нь энэ ургамлын газрын хөрсөн дээрх хэсгийн гол үйлчлэгч бодис болох нийлбэр кумарин зонхилсон найрлага бүхий 0.3 г жинтэй шахмал эм. Антиоксидант, мемброн бэхжүүлэх чадлаараа энэ эм дархлалын эсийг задралаас хамгаалах ба дархлалын урвалын хэвийн зохицуулалтыг эрчимжүүлж, дархлал хомсдох үед дархлалын эсийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг. Мөн энэ ургамлаас гарган авсан “Салимон” хэмээх эм нь биений дархлааг сайжруулдаг байна.

Газрын хөрсөн дээрх хэсгийг зун ургалтын үед түүж бэлтгэнэ. Энэ ургамал нь эртний ба дунд төрмөлийн (палеозей, мезозойн) үеийн үүсэлтэй ургамал байж болох тул биологийн жамаар тархцын хүрээ нь хумигдах шатандаа явж буй магадлалтай бөгөөд үүнийг лабораторийн нөхцөлд судлах шаардлагатай юм.

## БАРИУЛТ БҮЙЛС

Латин нэр: *Amygdalus pedunculata* (Pall.) Maxim. = *Prunus pedunculata* (Pall.) Maxim.


Орос нэр: Миндаль черешковый

Англи нэр: Longstalk Peach

**Ангилалзүйн шинж:** Хатгуургүй, сарвагар мөчир, цөөн тооны богиноссон мөчирөнцөрийй 1,5 метр хүртэл өндөр сөөг. Навчис нь гонзгойвтор-зууван, захаараа хурц хөрөөн шүдлэгтэй, богино бариултай. Цэцгэлсний дараа навчаа дэлгэдэг сөөг. Цэцэг тод ягаан, хонхорхуу аяга хэлбэртэй. Жимс нь 10-12 мм урт, зууван орой нь шовгор, ноолорлаг тул хилэнлэг харагдана.



Барiuулт бүйлс



Барiuулт бүйлэсийн тархалт

**Ургах орчин:** Хээрийн ба цөлөрхөг хээрийн бүсэд чулуутай энгэр, сайрын ёроол, хөвөө, элсний зах хадархаг газар ургана.

**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн цаад говь, Алашаа говийн тойрот ургана.

*Хүснэгт 26. Барiuулт бүйлсийн (загсагал, харгайрхуу бударгана)  
тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын хад, чулууны дунд. Яргайтын хажуу.	Монгол өвс- харгана- алагөвст хээр.	Дорнод говь	45° 45' 36.6" 107° 15' 33.6"
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ. Ерлөг уул. Хархадны тохой	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 52' 08.6" 107° 12' 18.2"
Дэлгэрхангай.	Дэлгэрхангай уул, Булангийн даваа.	Үетэн -алагөвст уулын орой	Дорноговь	44° 11' 48.9" 104° 46' 16.7"
Хулд	Хулд уулын урд хэсэг, энгэр.	Монгол өвс- харгана- алагөвст хээр.	Дорнод говь	45° 13' 28.8" 105° 34' 09.3"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"
Өлзийт.	Ухаа худагийн.govийн баруун талд, Чингийн нуураас баруун тийш, Өлзийт толгой.	Харгана- хотирт цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 49' 518" 107° 37' 186"
Өлзийт.	Өөш манханы элснээс баруун урагш 10 км-т.	Баглуур- тэсэг- бударганат цөлөрхөг хээр	Дорноговь (жинхэнэ)	44° 39' 511" 106° 56' 172"
Өлзийт.	Сумын төвөөс хойш 7км-т. Ушигийн уул	Харгана-үетэнт хээр	Дундад Халх (дорнод)	44° 58' 171" 106° 17' 146"

**Тархац, нөөц:** Бариулт бүйлс нь Монгол орны болон Дундговь аймагт өргөн тархацтай боловч маш сийрэг ургадаг, чимэглэлийн ач холбогдолтой ургамал.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд бүйлсний үрийг хэрэглэнэ.

## ДАГУУР ХҮЖ ӨВС

Латин нэр: *Haplophyllum dauricum* (L.) G.Don.

Орос нэр: Цельнолистник даурский

Англи нэр: Daurian Haplophyllum


**Ангилалзүйн шинж:** Голлосон үндэстэй, 10-20 см өндөр заримдаг сөөгөнцөр. Доод хэсэгтээ модожсон саваархуу олон нарийн иштэй. Суумал бүтэн, шовгор оройтой, шаантгархуу угтай бяцхан навчис ишиндээ цуварч байрласан байдаг. Зөв бүтэцтэй, одлог цэцгүүд ишний оройд жижиг бамбай баг цэцэг үүсгэдэг. Үр жимс нь жижиг, жимсний тасалгаа бүрд хосоор байрласан бөөр хэлбэртэй тод хүрэн үртэй.

**Ургах орчин:** Уулын болон цөлийн хуурай хээр, хайрга чулуутай хээр бүхий энгэр, бэл хад, хадархаг орчинд ургана.

**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойргуудад уулын болоод цөлийн хээрийн хайргархаг болон элсэрхэг хэсэгт, хуурай хээр бүхий энгэр, бэлээр ургадаг.



Дагуур хүж өвс



Дагуур хүжөвсний тархац

Хүснэгт 27. Дагуур хүж өвсний (загсагал, харгайрхуу бударгана) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Сумын төвөөс баруун урагш 12 км-, Хулд уул.	Сөөг-үетэн-алагөвст цөлөрхөг хээр	Дорноговь	45° 10' 54.3" 105° 25' 23.7"
Сайнцагаан	Мандалговиос баруун урагш 10 орчим км-т Даланзадгад явах төв замын дэргэд.	Үетэн- таана- алаг өвст хээр.	Дорнод говь (жинхэнэ).	45° 43' 39.2" 106° 09' 08.5"

**Тархац, нөөц:** Дагуур хүж өвс нь Монгол орны дорнод хэсэгт арвин ургах бөгөөд энэ бүс нутаг харьцангуй сийрэг sol арвитай ургана. Хөрш зэргэлдээ Төв, Говьсүмбэр аймагт арвитай ургах боловч ашиглалтын нөөцгүй юм.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Үндэс нь өмөн хавдрын өсөлтийн эсрэг үйлчилдэг бодис агуулдаг болох нь батлагдсан. Сүүлийн үед манай эрдэмтэн судлаачид гадаадын эрдэмтэдгэй хамтарч газрын дээд хэсэг болон үндсэнд зүрхэнд болон өмөн хавдрын эсрэг үйлчилдэг бодис бүхий алкалойдыг илрүүлсэн нь цаашид тармилжуулж, нутагшуулах ажлыг хийх шаардлагатай харуулж байна. Учир нь энэ ургамал өргөн тархац нутагтай боловч маш сийрэг ургадаг ургац багатай ургамал юм.


**АГЬ, Агь шарилж, үйтсэг шарилж, хүйтний шарилж, агь, цагаан агь**

Латин нэр: *Artemisia frigida* Willd.

Орос нэр: Полынь холодная

Англи нэр: Fringed Sagebrush

**Ангилалзүйн шинж** Олон наст найлзуур 10-40 см өндөр, нарийн, богиноsson, нилээд нягт дэгнүүл үүсгэдэг, сааралдуу торгомсог юмуу цагаавтар торгомсог үсэрхэгтэй, цайвар ногоон өнгөтэй олон наст өвслиг, сөөгөнцөр ургамал. Сагс 2-4(5) мм урт бөгөөд 1-5 мм урт унждаг шилбэн дээр байрладаг. Ороолтын дотоод навчинцар гонзгойвтор, тэр нь цайвар хальсан захтай. Бүх навчис-цуулбар, бариулын угт гурав, дөрвөн хос сайн хөгжсөн чихэнцэртэй, дээд хэсгийн навчис гурвалсан юмуу өдлөг цуулбар. Үндэсний систем арай дутмаг хөгжсөн. 7-р сард цэцэглэж, 8-9-р сард үрлэнэ.



Агь шарилж

Агь шарилжийн тархац

**Ургах орчин:** Уулын бэл тал нутгийн ботууль-хялганат алаг өвст хээр, толгодын бэл, тал хөндийн агь-жижиг дэгнүүлт үетэн-хялганат хээр, хялгана алаг өвст, шарилж-үетэнт, навтуул-агь-ботуулт бүлгэмдэлд зонхилогчоор юмуу дэд зонхилогчоор ургана.

**Тархалт:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойргуудад тархацтай.

*Xүснэгт 28. Агийн (Агъ шарилж) тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян уул.	Шарилж-үетэнт, алаг өвс-үетэн- шарилжит эвшилд.	Дорнод говь.	46° 33' 38.2" 107° 50' 13.6"
Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – хазаар өвс-харганат хээр.	Дундад Халх	45° 52' 26.3" 107° 41' 08.0"
Баянжаргалан	Баянжаргалан сумаас Өндөршил явах замд, толгодын дунд.	Хялгана-харгана- таанат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"
Гурвансайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Сайхан-Овоо	Дэлгэрхангайгаас Сайхан- Овоо сум явах замд.	Харгана- таана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 25' 07.6" 104° 03' 25.6"
Сайхан-Овоо	Сумын төвөөс Эрдэнэдалай орох замд. Төгрөг баг.	Харгана- хазаарөвст хээр.	Дорнод говь	45° 45' 35.6" 104° 26' 05.2"
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу. Амралтын урд ам.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"
Дэрэн	Дэрэнгээс баруун тийш 3 км-т Дэлгэрцогт явах замд.	Хайлаас- дэрстэй ам.	Дундад Халх	46° 10' 47.9" 106° 41' 30.1"
Сайхан-Овоо	Онгийн гол. Сумын төвөөс хойш 18 км-т Шар эрэг хэмээх газар	Голын алагөвст татам	Дорноговь, Олон нуурын хөндийн хил	45° 33' 47.7" 103° 43' 25.8"
Сайнцагаан	Мандалговиос баруун урагш 10 орчим км-т Даланзадгад явах төв замын дэргэд.	Үетэн- таана- алаг өвст хээр.	Дорнод говь (жинхэнэ).	45° 43' 39.2" 106° 09' 08.5"
Адаацаг	Бага газрын чулуу, аймаг явах замд хөтлийн ар.	Бүйлээс- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)	46° 11' 33.0" 106° 01' 01.0"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн нутагт 10000-20000 орчим га талбайд үетэн-алагөвст эвшилд sol арвигтай ургана.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Энэ эм гашуун амттай, хуурай нөмцөггүй, ширүүн мохдог, сэруүн чанартай, цус тогтоох, цусан халууныг арилгах, хавдар хариулах, чиххааг номхотгох, уушигны болон элэгний халууныг арилгах чадалтай. Цусаар бөөлжих, шарх хийгээд хамраас цус гарах, сарын тэмдэг элбэгших, дотор цус алдах зэрэгт сибирь тошлог, баавгайн цөстэй хавсарч хэрэглэнэ.

Намар цэцэглэж байх үед нь газрын хөрсөн дээрхи хэсгийг хадаж аваад хатаж өгөршсөн хэсэг болон холимогоос цэвэрлэн сүүдэр газар хатаана.

**ЭЭРЭМ ШАРИЛЖ**, царван

Латин нэр: *Artemisia macrocephala* Jacqum.

Орос нэр: Полынь крупнокорзиночная

Англи нэр: Largehead Wormwood


**Ангилалзүйн шинж:** Нэг ба хоёр наст ургамал. Иш 6-20(34) см өндөр, Навчис өргөн зуувгар юмуу сунгуу-зуувгар, 1.5-4 см урт, 1-2 см өргөн, бариулын утгыг дэлбэн чихэвчгүй, анхдагч сегмент гурвалсан, үзүүрийн салбанцар далархуу юмуу гонзгойвтор, 1-4 мм урт, 0.5 мм өргөн, мөлгөр. Сагс 5-10 мм өргөн, сийрэг сагс үүсгэдэг (58-р зураг). 7-р сард цэцэглэж, 9-р сард үрлэнэ. Үрээр үржинэ.

**Ургах орчин:** Уулын хээржүү хайргархаг хажуу, бэл, марц, хужиртай хотгор, хужирлаг ба эргийн нуга, хайрга, элс, сайр, элсэрхэг хээр, дэрстэй хотгор, тарианы талбай, зам харгуй, буурь, бууц, суурин газар ургана. Апофит, тариалан ба бэлчээрийн хөл газрын үндсэн ургамал.

**Тархалт:** Хөвсгөл (Хөвсгөл нуур), Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дундад Халх, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Ховд, Монгол Алтай, Алтайн өвөр говь (дорнод хэсэгт), Алашаагийн говийн тойргуудад тархацтай.



Ээрэм шарилж



Ээрэм шарилжийн тархач

Хүснэгт 29. Ээрэм шарилжсний (царван) тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян уул.	Шарилж-үтэкт, алаг өвс-үтээн-шарилжит эвшилд.	Дорнод говь.	46° 33' 38.2" 107° 50' 13.6"
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"
Дэрэн	Дэрэнгээс баруун тийш 3 км-т Дэлгэрцогт явах замд.	Хайлаас- дэрстэй ам.	Дундад Халх	46° 10' 47.9" 106° 41' 30.1"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн хойт сумдын зарим нутагт sol арвтайт ургаж байна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цэцэг, навчийг ардын эмнэлэгт хордлого тайлах, ангина болон тонзиллит зэрэг хоолойн болон амны хөндийн өвчин намдаах, түүнчлэн шарх, ханиад, үе мөчний өвчин анагаах зорилгоор хэрэглэхээс гадна мал эмнэлэгт бод (тэмээ, адuu) малын таталдах өвчин эмчлэхэд хэрэглэнэ.

Хамазулен, эфирийн тос нь нян үхүүлэх, өрөвсөл намдаах өндөр үйлдэлтэй тул анагаах ухааны эмнэлэгт өргөн ашиглахаас гадна түүний эфирийн тосыг үнэртний үйлдвэрт ашиглах боломжтой. Адуу, тэмээний татвалзуур өвчинд цэцгийг нь буцалгаж өгч болно. Намар цэцэглэж байх үед нь газар дээрхи хэсгийг хадаж аваад хатаж өгөршсөн хэсэг болон хог хольцыг цэвэрлэн сүүдэр газар хатаана.

## ҮСХИЙ НОХОЙН ХЭЛ

Латин нэр: *Panzeria lanata* (L.) Bge.

Орос нэр: Панцерия шерстистая

Англи нэр: Woolly Panzeria

**Ангилалзүйн шинж:** Голлосон үндэстэй, салаалсан богино үндэслэг иштэй, өтгөн ноосорхог эсгийлэг үсэрхэг, 30 см хүртэл өндөр иштэй олон наст өвслөг ургамал. Өдлөж хэрчигдсэн 3-4 салбангаас тогtosон цуурхай, дугуй давхар навчтай. Баг цэцгийн дэлбээ том цагаан(60-р зураг).

**Ургах орчин:** Уулын хад хайргатай хуурай хажуу, хээр ба цөлийн бүсэд хайрга чулуутай хээржүү хажуу, хадны ёроол, нуранги асга, хуурай ам хавцал, сайрын адаг ба элсэрхэг хээрт ургана.


**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорнод говь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алашаагийн говийн тойргуудад тархацтай.

Хүснэгт 30. Үсхий нохойнхэлийн тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Баянжаргалан	Хавирга уулын урд толгодын дунд.	Таанат хээр.	Дундад Халх	45° 47' 17.3" 107° 44' 22.9"
Өлзийт	Өөш манхан, Хөтөл уулын баруун хажуу.	Харгана- бударгана-таанат элсэрэг хажуу.	Дорнод говь	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Гурвансайхан	Сумын төвөөс баруун урагш толгодын дунд.	Монгол өвс- таанат хээр.	Дорнод говь	45° 26' 12.4" 106° 52' 34.6"
Сайхан-Овоо	Дэлгэрхангайгаас Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- таана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 25' 07.6" 104° 03' 25.6"
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"



Үсхий ногойхэл



Үсхий ногойхэлний тархац

**Тархац, нөөц:** Гарц-нөөцийн материал бүрдээгүй.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Монгол уламжлалт эмнэлэгт иш, үндсийг шээс хаагдах, сарын тэмдэг хэт их ирэх, умайн элдэв үрэвсэлт өвчин, шархлаа анагаахаар, төвөд эмнэлэгт ходоод гэдэсний өвчин, орос ардын эмнэлэгт хэвлэлий устахад чанамал, идээшмэл, хандмал хэлбэрээ тайвшруулах, шээлгэх, өвчин намдаах, цусны даралт бууруулахад хэрэглэнэ.

## ТӨЛӨГЧДҮҮ БОРОЛЗ

Латин нэр: *Ajania achilleoides* (Turcz.) Poljak.


Орос нэр: Аяния тысячелистничковая

Англи нэр: Yarrowlike Ajania

**Ангилалзүйн шинж:** 15-25 см өндөр, саарал ногоог өнгийн заримдаг сөөгөнцөр. Модожсон уг бүхий салаалсан иштэй. Шар өнгийн цэцэг бүхий бағавтар сагснууд иш, салааны оройд бамбай хэлбэрийн баг цэцэг үүсгэнэ байрлана.

**Ургах орчин:** Хээрийн болон цөлөрхөг хээрийн уул, толгодын чулуу, хайргатай энгэр, бэл, хад, сайр болон мөлгөр хайрга чулуутай ёроолд ургана.

**Тархалт:** Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорнод Говь, Говь-Алтай, Алашаа Говийн тойргуудад тохиолдоно.



Төлөгчдүү боролзын тархац

## Хүснэгт 31. Төлөгчдүү боролзын тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Говь-Угтаал	Сумын төвөөс зүүн урагш 20 орчим км-т.	Хялгана – харганат хээр.	Дундад Халх	45° 59' 48.1" 107° 35' 19.2"
Говь-Угтаал	Сумын төвөөс Баянжаргалан сум явах замд.	Хялгана – хазаар өвс-харганат хээр.	Дундад Халх	45° 52' 26.3" 107° 41' 08.0"
Баянжаргалан	Хавирга уулын урд толгодын дунд.	Таанат хээр.	Дундад Халх	45° 47' 17.3" 107° 44' 22.9"
Баянжаргалан	Баянжаргалан sumaас Өндөршил явах замд, толгодын дунд.	Хялгана-харгана-таанат хээр.	Дорнод говь	45° 37' 08.3" 108° 03' 43.4"
Өлзийт	Өөш манхан, Хөтөл уулын баруун хажуу.	Харгана- бударгана-таанат элсээрэг хажуу.	Дорнод говь	44° 40' 31.5" 106° 59' 17.3"
Гурвансайхан	Өлзийтөөс Гурван сайхан сум явах замд.	Хялгана – таана-харганат хээр.	Дорнод говь	45° 16' 39.1" 106° 40' 04.6"
Гурвансайхан	Сумын төвөөс баруун урагш толгодын дунд.	Монгол өвс- таанат хээр.	Дорнод говь	45° 26' 12.4" 106° 52' 34.6"
Гурвансайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын баруун урд хад, чулууны дунд.	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 44' 24.2" 107° 13' 05.6"
Хулд	Хулд уулын урд хэсэг, энгэр.	Монгол өвс- харгана-алагөвст хээр.	Дорнод говь	45° 13' 28.8" 105° 34' 09.3"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уул. Давааны оройд.	Боролз – бүйлс - алагөвст хээр.	Дорнод говь	45° 11' 48.9" 104° 46' 16.7"
Сайхан-Овоо	Онгийн хийд, хадтай уулын энгэр.	Харгана- монголөвст хээр.	Олон нуурын хөндий.	45° 21' 45.8" 104° 02' 11.6"
Эрдэнэдалай	Рашаант баг. Сумын төвөөс Улаанбаатар явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	46° 09' 32.1" 105° 06' 04.4"

**Тархац, нөөц:** Төлөгчдүү Боролз нь тус аймгийн нутагт харьцангуй өргөн тархацтай бөгөөд sol аривтайгаар тархан ургана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Монгол ардын эмнэлэгт энэ ургамлын навч, цэцгийг чанаж гүйлсэн булчирхайн үрэвсэл, ам, хоолойн өвчний үед зайллага хийх ба даавуу, хөвөнд шингээж гадна талаас нь жин тавьдаг.

Газрын дээд хэсгийг зуны ургалтын үед нь түүж ашиглана.

### ҮМХИЙ ШИМЭЛДЭГ

Латин нэр: *Dracocephalum foetidum* Bunge.


Орос нэр: Змееголовник вонючий

Англи нэр: Fetid Dragonhead

**Ангилалзүйн шинж:** 5-15 см өндөр иштэй, нэг наст ургамал. Навч доод гадаргуудаа суумал армаг тармаг булчирхайтай, гонзгойвтор юмуу гонзгойвтор өндгөрхүү, мохoo үзүүртэй, захаараа дугуй шүдлиг, уртавтар бариултай. Цэцэгс ишний оройн хэсгийг тойрч үелэн байрласан байдаг, цэцгийн дагавар навчис гонзгойвтор, урт нимгэн үзүүр нь сор болсон 3-5 шүдхэнтэй. Цоморлиг хос уруултай, дээд уруул нь гуравны нэгдээ цуурсан оньтой, доод уруулын шүд юлдэрхүү, цоморлигийн бүх салбан сор маягтай хурц. Цэцгийн дэлбэ цайвар нил-ягаан 15-18 мм урт(64-р зураг). 7-р сард цэцэглэж, 8-р сард үрлэнэ.

**Ургах орчин:** Ойт хээр, хээр, говийн бүсэд голын эрэг, хайрга, ам хавцал, сайр садрага, байц хадны ёроол, нуранга, элсэрхэг хээр, чулуурхаг ба хайргат хажууд ургана.

**Тархалт:** Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алашаа говийн тойргуудад тархацтай.



Үмхий шимэлдэгийн тархац

Хүснэгт 32. Үмхий шимэлдэгийн тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Цагаандэлгэр	Сумын төвөөс зүүн хойш Баян уул.	Шарилж-үетэнт, алаг өвс-үетэн-шарилжит эвшилд.	Дорнод говь.	46° 33' 38.2" 107° 50' 13.6"
Гурвансайхан	Их газрын чулуу БНГ-ын	Монгол өвс-	Дорнод говь	45° 44' 24.2"

	уулсын баруун урд хад, чулууны дунд.	алагөвст хээр.		107° 13' 05.6"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уул. Булангийн давааны оройд.	Боролз – бүйлс - алагөвст хээр.	Дорнод говь	45° 11' 48.9" 104° 46' 16.7"
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"

**Тархац, нөөц:** Дундговь аймгийн зарим сумдын нутагт уулсаар sol аривтай ургах бөгөөд гарц-нөөцийн материал бүрдүүлэх боломжгүй байлаа..

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Эфирийн тос нь нян, мөөгөнцөр хөнөөх өндөр үйлдэлтэй нь эмзүйн судалгаагаар илэрчээ. Монгол эмнэлэгт газрын хөрсөн дээрхи хэсгийг амны хөндий, шүд, буйлны өрөвсөл өвчинд; навч, цэцгийг суулга, бөөлжихүй зэрэгт хэрэглэх ба цэцгийг чийг бам, үе мөчний өвчнийг эмчлэх эмийн найрлагад оруулдаг. Газар дээрх хэсэг, цэцгийг зун (7-8-р сард) цэцэглэлтийн үед бэлтгэж, сүүдэр газар нимгэн дэлгэн хатааж хэрэглэнэ.

## МОНГОЛ ЧАРГАЙ


Латин нэр: *Cotoneaster mongolicus* Pojark.

Орос нэр: Кизильник монгольский

Англи нэр: Mongolian Cotoneaster

**Ангилалзүйн шинж:** Ихэд салаалсан 0.8-2 м хүрэхүйц өндөр, тахиралдсан сөөг. Навч нь уртавтар зууван, түүний орой мохой юмуу ухамтай, бас үзүүртээ богино шовонтой, дээд гадаргуу нүцгэн, доод гадаргуу нь үслэг юмуу нимгэн саарал эсгийлэг, гадагшаа эргэсэн цагаан дэлбээ бүхий өргөн дэлгэмэл цэцэгтэй. Жимс нь 8-9 мм урт, гадаргуйдаа ялимгүй саарал түрхэцтэй, улаан өнгөтэй.

**Ургах орчин:** Хээрийн үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, хад, уулын хажуу ба толгодын сөөгөн шугуйнд ургадаг.



Монгол чаргайн тархац

**Тархалт:** Хангай, Монгол Дагуур, Дундад Халх, Олон нуурын хөндий, Говь-Алтайн (Гурван богд, Гурван сайхан) тойргуудад тархацтай.

## Хүснэгт 33. Монгол чаргайн тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Гурван сайхан	Их газрын чулуу БНГ-ын уулсын хад, чулууны дунд. Яргайтын хажуу.	Монгол өвс- алагөвст хээр.	Дорнод говь	45° 45' 36.6" 107° 15' 33.6"
Адаацаг	Их Адаацаг хайрханы уулын овооны дэргэд.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 37' 43.9" 105° 46' 06.1"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Тархац, нөөц:** Бидний судалгааны дүнд Дундговь аймагт гурван газар ургадаг, бөгөөд 15 кг/га ургацтай, нийт 10 га талбайгаас 150 кг биологийн нөөцтэй бөгөөд бэлтгэлийн нөөцгүй, нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Монгол төвд эмнэлэгт жимсийг ходоодны элч буурах, идээ ундаа эс шингэхэд хэрэглэдэг.

### КОЗЛОВЫН СҮҮТ ӨВС

Латин нэр: *Euphorbia kozlovi Prokh.*

Орос нэр: Молочай козлова

Англи нэр: Kozlova Euphorbia

**Ангилалзүйн шинж:** Мөлхөө нарийн үндэслэг иштэй, жижиг навчис бүхий үл цэцэглэгч найлзуурт сайн хөгжсөн цэх иштэй, олон наст өвслөг ургамал. Навчис дугуйдуу өндөг хэлбэртэй.

**Ургах орчин:** Жижиг товгор болон сул элс, гол нуурын элсэн эрэг, сайрын ёроол, чулуутай элсжсэн энгэрт болон марзтай элсэнд ургасан дэрстэй хотгорт ургана.



Козловын сүүт өвс



Козловын сүүт өвсний тархац

**Тархалт:** Дундад Халх, Олон нуурын хөндий, Дорнод Говь, Говь-Алтайн тойргуудад тархацтай.

## Хүснэгт 34. Козловын сүүт өвсний тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Хулд	Хулд уулын баруун хоолой.	Монгол өвс- дэрс оролцсон харганат хээр.	Дорнод говь	45° 10' 38.1" 105° 23' 09.0"
Дэлгэрхангай	Дэлгэрхангай уулын зүүн хажуу.	Дэрс – харганат сайр.	Дорнод говь	45° 12' 19.4" 104° 56' 54.2"
Дэлгэрхангай	Сумын төвөөс Сайхан-Овоо сум явах замд.	Харгана- монголөвст хээр.	Дорнод говь	45° 23' 32.5" 104° 24' 22.0"

**Тархац, нөөц:** Тодорхой нутаг цөөн тооны хэдэн цэгт ургадаг тул гарц-нөөцийн материал бүрдээгүй болно.

**Зохицой ашиглах, хамгаалах арга:** Монгол төвд эмнэлэгт хорын болон савын халуун, турай, хэрэх, усан хаван өвчин анагаахад хэрэглэдэг.

## БҮНГИЙН ЯРГУЙ


Латин нэр: *Pulsatilla bungeana* C.A.Mey.

Орос нэр: Прострел Бунге

Англи нэр: Bunge Pulsatilla

**Ангилалзүйн шинж:** Олон толгой бүхий эгц доошоо орсон бүдүүн үндэслэг иштэй, 5-8 (25) см өндөр, өтгөн биш тархай үсэрхэг, олон наст өвслөг ургамал. Навчис хошоод өдлөг цуулбар, шугаман зураас юлдэрхүү юмуу гонзгой салбанцартай. Цэцэг хөхөвтөр ягаан.

**Ургах орчин:** Хад асга, хээрийн чулуурхаг, үйрмэг чулуут хажуу, уулын хээр, хуурай хээрт ургана.



Бүнгийн яргуйн тархац

**Тархалт:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Олон нуурын хөндийн тойргуудад тархацтай.

## Хүснэгт 35. Бүнгийн яргуйн тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Тархац, нөөц:** Ургамлын ургалтын хугацаа өнгөрсөн байснаас гарц-нөөцийн судалгаа хийх боломжгүй байлаа.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Монгол эмнэлэгт ногоог бие ядарч хөрөх үед дулаацуулан тамир тэнхээ оруулахаар дотуур, хоолойн бах, гүйлсэн булчирхайн үрэвслийн үед шинэ түүсэн цэцэг, ногоог няцлан хүйтэн усанд хийж ам хоолойг зайлдаг байна. Ногоо, цэцэг нь шинэ түүсэн нойтон үедээ арьс, салст бүрхүүлийг хэт цочроож үрэвсэл, цэврүү үүсгэдэг тул үүнийг хэрэглэхдээ тун ба шингэрлийг зохицуулах талаар эмчийн хяналтад байж байнгын зөвлөгөө авч байх нь чухал юм. Шинэ түүсэн ногоог усны уураар нэрж битүү ариутган адууны хулгана яр, сөдрөгө, өгөр хонь ямааны сөдрөгийн үед зохих тунгаар судсанд тарихад түргэн эдгэрүүлдэг байна.

**СӨӨГӨН БОРОЛЗГОНО**, Шүүр, даланхальс, буриагуул, боролзгонон шүүр, угаагуур

Латин нэр: *Dasiphora fruticosa* (L.) Rydb. = *Potentilla fruticosa* (L.) Rydb.

Орос нэр: Лапчатка кустарниковая, Пятилистник кустарниковый, Курильский чай  
Англи нэр: Bush Cinquefoil

**Ангилалзүйн шинж:** 0.8-1.5 м өндөр сөөг. Навчис өдлөг, бүтэн ирмэг бүхий салбантай, 5(7) навчинцартай. Навчинцар гонзгойвтор, гонзгой өндгөрхүү юмуу юлдэрхүү, үсэрхэг юмуу нүцгэн, 10-25 мм урт, 1.5-8 мм өргөн. Навчны дагавар шовх үзүүртэй. Цэцэг том, 15-30 мм голчтой. Цэцэг ганц нэгээрээ юмуу 3-7-оороо дихази үүсгэнэ. 6-8-р сард цэцэглэнэ.



Сөөгөн боролзгоно



Сөөгөн Боролзгонын тархац

**Ургах орчин:** Таг цармын намгархаг нуга, ойн бүслүүрийн торлог, шинэсэн ой, хусан төгөл, ойт хээрийн уулын хажуу, энгэр, бэл, голын хөндийгөөр, эргийн шугуй, ойн захаар ургана.

**Тархалт:** Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Хянган, Ховд (Хархираа нуруу, Түргэн уул), Монгол Алтай, Говь-Алтай (Гурван Богд), Дорнод Монгол, Дундад Халх, Олон нуурын хөндийн тойрогт тархацтай.

#### Хүснэгт 36. Сөөгөн боролзгонын тархалт, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"

**Тархац, нөөц:** Монгол орны умарт хэсэгт нэлээд арвин нөөцтэй, тархалт ихтэй ургамал боловч Дундговь аймагт Их Адаацаг ууланд тэмдэглэгдсэн, гарц-нөөцгүй ургамал болно.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Навч, цэцгийг цус тогтоох, идээ ундаанд дуртай болгох, мэдрэл-сэтгэцийн өвчин засахад болон суулга татрахаар олгох ба цэцгийн чанамлыг бөөрний өвчинд хэрэглэнэ.

Эмийг хэтрүүлэн хэрэглэснээс үүссэн эмийн хордлого (дисбактериоз)-д, уг ургамлын хатаасан навч, цэцэгнээс цайны 1-2 халбагыг авч, аяга буцалсан усанд хийж, 30 мин хандална. Хүүхдэд удаа бүр хоолны 1-2 халбагаар өдөрт 3-4 удаа өгнө.

Энэ сөөг нь тархац-нөөцийн хувьд харьцангуй элбэг боловч цэцгийг ихээр бэлтгэх шаардлагагүй бөгөөд нөхөн сэргэлтийг дэмжих үүднээс нэг бутны тавны нэгийг, тухайн нэгж талбайн гуравны хоёрыг үлдээж бэлтгэх хэрэгтэй. Бэлтгэлийг зуны ургалтын үе буюу 6-7-р сард хайчилж бэлтгээд салхи чөлөөтэй нэвтрэх хуурай, сүүдэр газарт нимгэн үелэж, тараан хатаах ба эсвэл хатаагч шүүгээнд 60-70°C хэмд хатаана. Бор цаасан, даавуун болон таар уутанд хийж хуурай, сэргүүн, харанхуй нөхцөлд 1 жил хадгална.

### ХУРЦ САЛБАНТ ХОНИН ЗАЖЛУУР

Латин нэр: *Linaria acutiloba* Fiscz. ex Reichb.

Орос нэр: Льнянка остролопастная

Англи нэр: Acutilobate Toadflax

**Ангилалзүйн шинж:** Эгц, бөх 30-50 см өндөр иштэй, юлдэрхүү навчтай, нүүцгэн саарал ургамал. Дэлбэ 12-16 мм урт, шовгор годойтой, шар доод уруулдаа шаргал юмуу хурц шар толботой(74-р зураг).

**Ургах орчин:** Хээрийн ба нугархаг хажуу, сийрэг ойн зах, хадны ёроол, нураг юмуу эргийн хэвгий, хонхор ам, хөндийн оёоороор ургана.



*Хүрүү салбант хонин зажлуурын тархац*

**Тархалт:** Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Говь-Алтай, Дорнод Монгол, Дундад Халхын тойрогт тархацтай.

*Хүснэгт 37. Хүрүү салбант хонин зажлуурын тархалт, ургах эвшил*

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог	Координат
Адаацаг	Их Адаацаг хайрханы урд хадтай ам.	Хялгана- бүйлэст хээр	Дундад Халх	46° 36' 43.2" 105° 45' 25.9"
Адаацаг	Бага газрын чулуу.	Хялгана- бүйлэст хээр.	Дундад Халх	46° 12' 42.1" 105° 59' 50.6"

**Тархац, нөөц:** Гарц-нөөцийн материал бүрдээгүй.

**Зохицтой ашиглах, хамгаалах арга:** Газар дээрх хэсгийн усан ханд нь хоруу чанар багатай, үений үрэвслийн улмаас үүссэн хаванг хариулан, хodoодны салстын гэмтлийг илэрхий багасгаж, эдийн үхжил, гэмтлийг эрс багасгаж үрэвслийн эсрэг үйлчилдэгийг монголын эрдэмтэд эм зүйн судалгаагаар илрүүлжээ. Мөн Монгол уламжлалт эмнэлэгт цэцгийн үе мөчний өвчин, нохой болон зэрлэг араатанд хазуулсан үед хорын ерөндөг болгон гадуур хэрэглэдэг байна.

## ДҮГНЭЛТ

Монголчууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлал, малын тоо толгойн өсөлт, улмаар газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа зэрэгээс улбаалан байгалийн ургамлын ашиглалт үлээмж ихсэв. Өнөө үед уламжлалт анагаах ухаанд эмийн ургамлын ашиглалт ихээр нэмэгдэхийн зэрэгцээ гадаад улс орнууд монголын экологийн цэвэр орчинд ургасан эмийн ургамлын түүхий эдийг ихээр авах сонирхолтой болсноос шалтгаалан ургамлыг үндсээр нь ухаж устгах, иш навч мөчрийг их хэмжээгээр түүж бэлтгэх, худалдаалах, цэцэг үр жимсийг хэт их ашигласнаар тухайн зүйл ургамлын тархалт, нөөц хомсдож, зарим зүйлийн хувьд бүрмөсөн устгах аюул нүүрлээд байна.

Дундговь аймагт 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйлийн ургамал хээрийн судалгаагаар бүртгэгдсэн ба энэ нь ургамлын судалгааг ургамал ургалтын үеэс хожуу хийсэнтэй холбоотой байж болох юм. Мөн 20 овгийн 28 төрлийн 37 зүйл ургамлын тархац, 9 зүйл ургамлын нөөцийн судалгаа явууллаа.

Одоо ашиглалтад өртөмтгий ургамлуудын тархалт, нөөцийн судалгааг Дундговь аймагт хийж байгаа явдал бол байгалийн баялаг, ялангуяа ургамлын аймгийн тогтвортой ашиглалт, бодлого боловсруулах түвшинд мэдээллийн сан бүрдүүлэхэд үр дүнгээ өгөх сайн үйлсийн эхлэл болж байна. Энэ судалгааг цаашид аймгийн сум бүрээр гаргах боломжийг бүрдүүлэх нь чухал юм. Ингэж ажиллах боломж бүрэн бий. Сум бүрт Байгаль орчны улсын байцаагч, Байгаль хамгаалагч гэсэн ажлын байранд ажиллаж байгаа хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэжсэн ажилтан болгоход анхаарах шаардлагатай

Цаашид БОАЖЯ-ны бодлогын түвшинд дараах санал болгож байна. Үүнд:

- Дундговь аймагт ургаж буй нэн ховор, ховор ургамал нь байгаль экологийн хүчин зүйлээс хамаарч ховордож буй ургамал (Алтан бэрмэг, Сөөгөн шимэрс, Шивлээхэй зээргэнэ, Монгол догар г.м.), хүн амьтан нөлөөллөөс ховордож буй ургамал (Нангиад зээргэнэ, Толбот бэрээмэг, Ацан ажигана, Сибирь ерөндгөнө, г.м.) буй бөгөөд энэ бус нутагт **нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, Эндемик 3 зүйл, Субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал тохиолдоно.**
- Ашигт (дотоодод хэрэглэгдэж байгаа эмийн болон экспортоор гаргаж байгаа) ургамлын нөөц ашигласны төлбөр, зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд экологи-эдийн засгийн үнэлгээний төлбөрийг яаралтай мөрдөж хэрэгжүүлэх.
- Дундговь аймгийн өвөрмөц ургамалжилт бүхий Их Адаацаг болон Их газрын чулуу, Бага газрын чулуунд “байгалийн цэцэгт ургамлын хүрээлэн” байгуулж тэнд байгалийн аясаар болон зориудаар зарим ургамлыг шилжүүлэн байршуулах, нутагшуулах улмаар нөхөн сэргээх.

Дулааны улиралд унах тунадасны хэмжээ, температур болон бусад хүчин зүйл, хүний үйл ажиллагааны хам нөлөөгөөр вегетацийн үе ургамлын зүйл тус бүр дээр харилцан адилгүй байлаа. Бидний хээрийн судалгааны хугацаа ургамлын вегетацийн

нэлээд хожуу үед хийгдсэн тул хээрийн нөхцөлд хийсэн бичиглэлийг эхний байдлаар товч боловсруулж, ашигт ургамалтай холбоотой мэдээллийг орууллаа.

Тархац нөөц багатай ашиглалтад өртөмхий ашигт ургамлыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах, нэн ховор болон ховор ургамлыг үр болон тарималжуулах байдлаар үржүүлэн, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

Энэ ажил төгс хийгдсэн гэж үзэж болохгүй бөгөөд цаашид нарийвчилсан хайгуул судалгааг урт хугацаатай аймгийн бүх нутгийг хамарч явуулах шаардлагатай хэмээн үзэж байна.

## ДҮНДГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХОТ СУУРИН ГАЗРЫГ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭХ, ЭВДЭРСЭН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Аливаа нөхөн сэргээх ажилд тухайн орон нутгийн ургамлыг ашиглавал илүү үр дүнтэй байдаг. Тийм ч учраас энд эх орны ургамлын балгыг хот суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд ашиглах тухай зөвлөмж боловсруулав.

Ургамал тарих ажил одоо 3 чиглэлээр өрнөж байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуй газар тариалан эрхэлж, гурил будааны ургамал, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, эмийн ургамал, малын тэжээлийн өвс, үйлдвэрлэлийн түүхий эд болдог ургамлыг (хөвөн, олс, маалинга, цай, чихрийн нишингэ, чихрийн манжин, наранцэцгэг гэх мэт) тарьж ашигладаг.

2. Ой модыг байгалийн нөхцөлд сэргээн тарих, тариалангийн талбай, бэлчээр хамгаалах, ойн зурvas байгуулах, хотын ногоон бүс гол мөрөн, нуурын эргийг ойжуулах ажил

3. Хот суурин газрыг чимэглэн тохижуулах, амралт сувиллын газрыг цэцэрлэгжүүлэх

### **2. Хот сууринг тохижуулахад хэрэглэх ургамал**

Хот сууринг цэцэрлэгжүүлэхэд анх түрүүнд анхаарах зүйлүүд:

а. Хот суурины байрлал байгалийн бүс, уур амьсгалын онцлог, ялангуяа дулааны горим, жил улирал, сард унах хур тунадасны хэмжээ, нарны гийгүүлэх эрч, салхины чиглэл, хүч гэх мэт.

б. Газрын гадаад байдал, хотгор, гүдгэр, ургамал нөмрөг, хөрсний бүтэц, усан хангамж, гол, нуур байршил.

в. Хот суурингийн үйлчилгээний чиглэл, хүн ам суурьшлын, үйлдвэрийн, зам тээврийн гэх мэт.

г. Хот тохижуулах цэцэрлэгжүүлэх нь хот байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг байдаг учир, тарих ургамлыг уран барилгын зарчимд нийцүүлэн үзэх.

Хот тохижуулалтад хэрэглэх ургамал нь гадаад хэлбэр байдал, цэцэг, навч, жимсний өнгө сайн байх ёстой. *Хэрэглэх ургамал нь:*

- МОД СӨӨГ
- ОЛОН НАСТ ӨВС

- хоёр ба нэг наст ургамал
- үет ургамал
- сонгинолог булцуут ургамал гэсэн 5 бүлэгт хуваагддаг.

Хот тохижуулахад гол төлөв гадаад орноос хэлбэр, өнгө үзэмж сайтай ургамлыг авч ирж хэрэглэдэг. Ийм ургамал нь тарьж ургуулахад зохицсон, тарилт арчилгааны тогтсон журамтай байдаг. Эдгээр нь байнгын анхаарал, арчилгаа шаарддаг онцлогтой.

Хот цэцэрлэгжүүлэхэд орон нутгийн ургамлыг ашиглах нь үнэ өртгийн хувьд хямд, арчилгаа нь харьцангуй хялбар байдаг. Мод сөөг нь мөнх ногоон ба зуны ногоон навчтай эсвэл шилмүүст ургамал байж болно.

#### **Мод:**

- Нарс (*Pinus sylvestris*)
- Шинэс (*Larix sibirica*)
- Гацуур (*Picea obovata*)
- Жодоо (*Abies sibirica*)
- Улиас (*Populus laurifolia; P.suaveolens*)
- Улиангар (*Populus tremula*)
- Хайллас (*Ulmus pumila*)
- Хус (*Betula platyphylla*)
- Өрөл (*Malus baccata*)
- Монос (*Padus asiatica*)
- Долоогоно (*Crataegus sanguinea, C. dahurica*)
- Чацаргана (*Hippophae rhamnoides*)
- Жигд (*Elaeagnus, Moorcroftii*)
- Заг (*Haloxylon ammodendron*)
- Харгана (*Garagana arborescens*)

#### **Сөөг:**

- Нохойн хушуу (*Rosa acicularis, R. davurica*)
- Улаалзгана (*Ribes rubrum, R. nigrum, R. diacantha*)
- Боролзгоно (*Dasiphora fruticosa*)
- Гүйлс (*Armeniaca sibirica*)
- Бүйлс (*Amygdalus pedunculata*)
- Даль (тэрэлж) (*Rhododendron dahuricum*)
- Ямаан арц (*Juniperus sibirica*)
- Тошлог (*Berberis sibirica*)

#### **Олон наст өвслөг ургамал:**

- Цахилдаг (*Iris lactea*)
- Мийн хумс (*Nepeta sibirica*)
- Сэдэргэнэ (*Convolvulus arvensis*)
- Флокс (*Rhlox paniculata*)

#### **Үет ургамал:**

- Ерхөг (*Agropyron cristatum*)
- Согоовор (*Bromus inermis*)
- Биелэг өвс (*Poa attenuata, P. pratensis*)

Ботуул (*Festuca rubra*)

Дурваа (*Phleum phleoides*)

Үнэгэн сүүл (*Alopecurus pratensis*, *A. brachystachyus*)

Зэрлэг арвай /Зурман сүүл/ (*Hordeum brevisubulatum*)

Дааган сүүл (*Koeleria macrantha*)

Дэрс (*Achnatherum splendens*, *A. inebrians*)

#### Нэг наст ургамал:

Петуния (*Petunia hybrida*)

Астра (*Aster amellus*, *A. alpinus*), Китайская астра (*Callistephus chinensis*)

Ноготки (*Calendula officinalis*)

Космeya (*Cosmos bipinnatus*, *C. sulphureus*)

Бархатцы (*Tagetes patula*, *T. signata*, *T. erecta*)

Львиный зев (*Antirrhinum majus*)

#### Сонгинолог булцуут ургамал:

Сараана /лилия/ (*Lilium*)

Алтан зул /тюльпан/ (*Tulipa gesneriana*)

Гиацинт (*Hyacinthus orientalis*)

Флокс (*Phlox drummondii*)

Георгин (*Dahlia*)

Гладиолус (*Gladiolus hybridus*)

#### ҮР ЦУГЛУУЛАХ АРГАЧЛАЛ

Ургамлын үрийг цуглуулахдаа эхлээд ямар ургамлын үр түүхээсээ шалтгаалан уут сав, эдгээрийн бүрэн бүтэн байдлыг шалгах хэрэгтэй. Үр бүхэн харилцан адилгүй хэлбэр дүрстэй, хонхорцог, буурцган үр жимс нь гар хүрмэгц өөрөө нээгдэж цацагддаг. Үрийг гар хуруугаар удаан барьж биеийн илч дулааныг шингээвэл ургах чадвараа алдах тохиолдолд ч бий.

Хуурай үрийг цаасан, давуун уут, таглаатай хуванцар сав эсвэл нягт тортой зориулалтын саванд цуглуулна. Дараа нь үрийг жимсний хальс бусад хольцоос нь цэвэрлэнэ.



Хуванцар саванд үр цуглуулах



Бусад хольцоос шүүрээр салгах

Хармаг, зээргэнэ мэтийн шүүслэг жимсний үрийг түүхдээ няцлаж гэмтээхгүйгээр жимсний хамт цуглувулж, маараль, сиймхий давуунд боож мушгиад шүүсийг шахаж гаргана. Дараа нь сэргүүн газар хатааж бусад хольцоос цэвэрлэн цаасан уутанд хийж хадгална.



Буурцааг, хонхорцогоос үрийг салгах



Үрийг цаасан уутанд хадгалах

Үрийг тарихын өмнө заавал ариутгал цэвэрлэгээ хийж, амьдрах чадварыг нь шалгах учиртай. Шил саванд буцалгаж хөргөсөн усанд марганцийн хэдэн талст хийж сулавтар ягаан өнгөтэй болсоны дараа үрийг хийж сайтар хутгаад 2-4 цаг тавихад хэсэг үр савны ёроолд, зарим хэсэг үр уусмалын гадаргууд ялгарсан байна. Уусмалын гадаргууд байгаа үр бол амьдрах чадвараа алдсан байдаг болохоор үүнийг ялгаж хаяна. Ёроолд тунаж хоцорсон үр нь тариалж болох амьдрах чадвартай үр учраас уусмалаас шүүж хатаана. Энэ үед уусмалын ягаан өнгө бараг арилсан байх тул асгана. Ингэж үрийн амьдрах чадвар, ариутгалыг хамт хийнэ.

## УРГАМЛЫГ ҮРЭЭР ҮРЖҮҮЛЭХ

(аргачилсан зөвлөмж)

Цэцэглэдэг ургамал бүхэн үр жимс үүсгэнэ. Үр жимс бол тухайн ургамлын дараагийн үед амьдрах үр удам билээ. Ургамлыг үрээр үржүүлэх нь түүнийг нөхөн сэргээх үндсэн арга зам юм.


Манай дэлхий дээрх бүх ургамлыг **нэг талт үрт ургамал, хос талт үрт ургамал** гэсэн хоёр бүлэгт хувааж үздэг. Энэ бол тун энгийн хялбархан ангилал юм. Ямар ч ургамлын үрийг аваад үрийн хальсан бүрхүүлийг задалж үзэхэд дотоод хэсэг нь нэг цул байвал нэг талт үрт ургамал, харин дотоод цул хэсэг нь хоёр хэсэг болон салж байвал хос талт үрт ургамал болно.

Үрийн бүтцийн энэ онцлог нь үрийг тарьж ургуулах үед тодорхой харагдаж ойлгогдоно.

### Нэг талт үрт ургамлын үрийн ургах онцлог

Нэг талт үрт ургамлын үрийг хөрсөнд тарьж үзэхэд үрийн бүрхүүлээс гарч ирж байгаа анхны цайвар ургац бол хөврөлийн үндэс (1) бөгөөд тэр ямагт газар луу хандаж ургана. Өөрөөр хэлбэл энэ хэсгийг доош харуулан үрээ тарих хэрэгтэй.

Дараа нь хөрснөөс нэг нахиа (2) гарч дээш чиглэн ургах бөгөөд үргэлжлэн хэд хэдэн ногоон навч (3) гарсаар бүхэл бүтэн ургамал болж ургана.



*Нэг талт үрт ургамлын үрийн ургах байдал*

### НЭГ ТАЛТ ҮРТ УРГАМАЛ

#### БҮНГИЙН ЦАХИЛДАГ Iris Bungei Maxim.

**Үндсэн шинж:** Бунгийн цахилдаг утсархуу нарийн, 30-40 см өндөр, навч шугамархуу, хатуу, 2-4 мм өргөн, цэцэг нил, цагаан, бүрхэвч тууш судлуудтай. Жимс хонхорцог. Бунгийн цахилдаг 4 сараас сэргэн ургана.

**Ургах орчин:** Элсэргүү, элс хайрган цөлийн хээр, толгодын бутармаг чулуурхаг хажуу, сайрын зах, ёроолоор ургана.

**Цэцэглэх ба үрлэх хугацаа:** 6 сард цэцэглээд, 8 сард үр боловсорч 9 сард хагдарна. Үр боловсорч дуусмагц хонгорцог задарч үр нь асгардаг. Хагд босоогоор нэлээд удаан хадгалагдана. Олон наст үндэслэг ишээрээ дэгнүүл үүсгэж ургана. Үрээр сайн ургана.

**Үр цуглуулах, хадгалах:** Хонхорцогт олон тооны үр боловсordog. Хонгорцгийг дөнгөж нээгдэх үеэр угаар нь хайчлан цуглуулна. Үрийг хонхорцгоос салгаж сайтар цэвэрлэнэ. Хатаасан үрийг цаасан уутанд хийж ус чийг багатай газар хадгална.

**Үрийг тариалах, арчлах:** Хавар үрийн амьдрах чадварыг шалгаж ургах чадвартай үрийг чийгтэй элсэрхэг хөрсөнд 3-5 см гүнд суулгаж тарина. Хэнз ургацыг 1-2 хоногт тогтмол усалж арчлан.

**Ашиглах боломж:** Цахилдаг нь олон настай, үндэслэг ишээрээ дэгнүүл үүсгэж ургах чадвартай учраас хөрсийг тогтворжуулах зорилгоор хамгаалалтын зурваст, хавар эрт цэцэглэдэг тул чимэглэлийн зориулалтаар ашиглана.

### САЙРЫН ХЯЛГАНА *Stipa glareosa* P.Smirn.

**Үндсэн шинж:** Хатсан үед нь цагаан өвс гэж нэрлэдэг. 5-7 см ургт нилдээ өдөрхөг нугарсан шивээтэй, хялгас мэт мушгирсан нарийхан ширүүн навчтай. Сайрын хялгана 15-18 см өндөртэй, жижиг дэгнүүлт, намхан үет ургамал юм. Хатсан иш навч өвлийн улиралд хагд хэлбэрээр үлддэг.

**Ургах орчин:** Цөлийн бүсийн дов толгод, хөтөл, гүвээ, тэгш талаар тохиолдох боловч ус чийг хангамж сайтай судаг, жижиг хотгоруудаар голдуу ургана.

**Цэцэглэх, үрлэх хугацаа:** Хялгана 7, 8 сард цэцэглэж үрлэнэ. Хялганы шивээ нь түүний үр юм. Дэгнүүл үүсгэдэг сахлаг үндэс болон үрээр ургах чадвартай.

**Үр цуглуулах, хадгалах:** 8 сарын сүүлчээр бүрэн боловсорсон шивээг өдлөг нисгүүрийн хамт цуглуулж, хатуу цаасан уутанд цуглуулж хадгална.

**Үрийг тариалах, арчлах:** Хавар шивээг өдлөг хэсгээс нь салгаж 1-3 мм гүнд мөрөөр юмуу цацаж тариад элсээр зөөлөн хучиж үрээ хийсгэхгүйгээр шүршиж услана. 3-5 хоногийн дараа амьдрах чадвартай үр соёолно. Хэнз ургацыг байнга услаж 1-2 нас хүртэл арчилна.

**Ашиглах боломж:** Хялгана дэгнүүл үүсгэж хөрс бэхжүүлдэг олон наст ургамал учраас нөхөн сэргээлт, таримал бэлчээрт ашиглана.

### МОРИН ЗЭЭРГЭНЭ *Ephedra equisetina* Bge.

**Үндсэн шинж:** Жижигхэн дэлгээ, 3-20 см өндөр сөөгөнцөр, газар доорх урт найлзууртай бөгөөд түүний үзүүрээс эгц шулуун нарийвтар ногоон, шар ногоон мөчир олноор багцлан ил гардаг. Улгарга шаравтар юмуу цагаавтар хальслаг, угларгынхаа дунд хүрсэн хурц шүдлэгтэй.

**Ургах орчин:** Уул толгодын хад, чулуутай хажуу, сайрын чулуурхаг ирмэгээр ургана.

**Цэцэглэх ба үрлэх хугацаа:** Зээргэнэ 6 сард цэцэглэж, 8 сард шүүслэг, чихэрлэг амттай улаан жимс үүснэ. Жимсний дотор олон тооны үр бүрэлдэнэ


**Үр цуглуулах, хадгалах:** 8 сараас шүүслэг жимсийг түүж сиймхий даавуу эсвэл марльд боож зөөлөн базаж шүүсийг авна. Харин гялалзсан хар бараан үрийг сэргүүн газар дэлгэж хатаагаад цаасан эсвэл даавуун уутанд хадгална.

**Үрийг тариалах, арчлах:** Тарих үрийг 24 цаг буцалсан усанд байлгаж дараа нь 1 хувийн зэсийн байвангийн уусмалд 30 минут байлгаад шүүж авна. Үрээ цэвэр усаар зайлж тусгайлан бэлтгэсэн элсэнд хийж гараараа имэрч үзэхэд наалдахгүй байвал үрээ тарьж болно. 5-6 сард элсэрхэг хөрс бэлтгэж 2-3 см гүнд мөрөөр тариална. 2-3 хоногийн зйтай услаад 5-7 хоноход үр ургаж эхэлнэ. Эхний жилдээ 7-10 см өндөр ургана. Хэрвээ нягт тарьсан бол дараа хавар сийрэгжүүлэн их талбайд суулгацаа тарина.

**Ашиглах боломж:** Зээргэнэ сахлаг, мөлхөө үндэстэй, дэгнүүл үүсгэж ургадаг тул хөрс хамгаалах зорилгоор хамгаалах зурваст тарьж болно. Арвин ургацтай бол газрын дээд найлзуур, шүүслэг жимсийг авч ашиглана.

### Хос талт үрт ургамлын үрийн ургах онцлог

Хос талт үрт ургамлын үрийг хөрсөнд суулган тарихад эхлээд хөврөлийн үндэс (1) үрийн хальсыг нэвтлэн гарч доош чиглэн ургана. Удалгүй тохойрсон хэсэг үрийн талыг (2) хальсны хамт газрын хөрсөн дээр өргөж гаргаж ирдэг. Зарим ургамлын үрийн тал ногоон өнгөтэй болж дараагийн хос навчыг (3) гарч ирэх хүртэл байна. Үргэлжлэн хос навчнууд гарч ирэх үед үрийн тал хагдарч унадаг.



Хос талт үрт ургамлын үрийн ургах байдал

## ХОС ТАЛТ ҮРТ УРГАМАЛ

### **МОНГОЛ БҮЙЛЭЭС *Amygdalus mongolica* Maxim.**

**Үндсэн шинж:** Маш их өргөслөг дээрэвгэр мөчиртэй, 25-80 см өндөр сөөг. Навчис зууван, өргөн-тонгорхуу-өндгөрхүү юмуу дугариг, 0,5-1,5 см урт, жижигхэн, үл мэдэг гүдэн-шүдэрхэг, нүцгэн илэглэг. Цэцэг цайвар ягаан, суумал навч гарахаас өмнө дэлгэрдэг.

**Ургах орчин:** Уул толгодын чулуурхаг бэл, хажуу хормой, байц ам хавцал, сайрын ирмэг дагаж ургана.

**Цэцэглэх ба үрлэх хугацаа:** 4, 5 сард цэцэглэнэ. 7, 8 сард гадуураа үслэгтэй, амтлаг самран жимс боловсордог. Говийн жижиг мэрэгчид, үр идэшт шувууд самрыг цөмж иднэ.

**Үр цуглуулах, хадгалах:** Сайтар боловсорсон самрыг 8-р сарын дунд үеэс түүж, даавуун эсвэл цаасан уутанд харанхуй, сэрүүн, чийггүй газар хадгална.

**Үрийг тариалах, арчлах:** Үрийг марганцын сувалтар уусмалаар ариутгаж, буцалгаж хөргөсөн ус, эсвэл цэвэр чийгтэй элсэнд 12-24 цаг байлгаж үр хөөж, самрын ясанд ан цав гарах үед тариалах талбайд 3-5 см гүнд суулгана. 3-5 хоногийн дараа хэнз ургацын анхны навч гарна. Бусад ургамлын адил хортон шавж, мал, амьтанд идэгдэхээс хамгаалах шаардлагатай. Хамгаалалттай талбайд 1-3 нас хүртэл ургуулж түүний ургаж болох орчинд, байгальд задгай талбайд шилжүүлнэ. Түүнээс хойш 1-2 жил усалж тордоно. Цаашдаа байгаль дээр бие даан ургана.

**Ашиглах боломж:** Хөрсний нүүдэл, нөхөн сэргээлт, цэцэрлэгжүүлэлт, хамгаалах зурваст тариална. Ихээр үржүүлсэн тохиолдолд самрыг хүнсэнд боловсруулж хэрэглэнэ.

### **МОНГОЛ ТАРВАГАН ШИЙР *Thermopsis mongolica* Czebr.**

**Үндсэн шинж:** Тарваган шийр 20-30 см өндөр олон наст, үндэсний цухуйцаар үрждэг өвслөг ургамал бөгөөд доод талдаа үстэй сааралдуу, ногоон өнгийн гурвалсан навчнууд нь том дагавар навчнуудтай байна. Залаа маягийн оройн шингэн баг цэцэгтэй, цэцгүүд нь шар өнгөтэй, дээшээ чиглэсэн, хавтгай уртавтар шугаман буурцагнуудтай байна.

**Ургах орчин:** Элсэргэг ба зөвлөн ба шаварлаг хөнгөн хөрсөнд харьцангуй элбэг, хааяа сайрархаг энгэрээр тохиолддог.

**Цэцэглэх ба үрлэх хугацаа:** 6, 7 сард цэцэглэж үрлэнэ. Үрээрээ ургах чадвар сайтай.

**Үр цуглуулах, хадгалах:** Үр бүрэн боловсорч хар бараан өнгөтэй болох үед урт буурцагийн угаар хайчилж түүнэ. Буурцагийг даавуун уутанд хийж зөвлөн үрэх эсвэл

гараар үрийг салгаж авна. Үрийг цаасан юм уу даавуу уутанд хийж сэргүүн, хуурай орчинд хадгална.

**Үрийг тариалах, арчлах:** Үрийг марганцийн сувалтар уусмалаар ариутгаж дэвтээгээд элсэрхэг хөрсөнд 2-3 см гүнд мөрөөр тарина. 5-7 хоногт үр ургаж эхлэнэ. Хэнз ургацыг 1-2 нас хүртэл арчилж ургуулна.

**Ашиглах боломж:** Тарваган шийр үндэслэг ишээр үржиж бөөн бөөнөөр ургаж хөрс бэхжүүлдэг. Эмийн ач тустай ургамал.

### ХАРЛАГ ӨМХИЙ ӨВС *Peganum nigellastrum* Bunge

**Үндсэн шинж:** Голлосон үндэстэй, хялгасан үсэнцэртэй олон наст өвс. Иш 10-20 см өндөр, маш ширүүн, олон, бараг салаагүй. Навчис 1,5-2 см урт, шугамархуу, эсвэл юлдэрхүү 3-5 салбантай, тэдгээр тус бүр цаашдаа цуулбар өдлөг, шугман хэлбэртэй. Цэцэг цагаан голчоороо 1,5-2 см, дээд хэсгийн навчны өврөөс ганц нэгээрээ гарна. Хонгорцог 3 үүртэй, суумал, тонгоруу-өндгөрхүү, оройдоо урт баганатай.

**Ургах орчин:** Говь, цөл, хуурай хээрийн бүсэд элсэрхэг тал, эргийн элсэрхэг хайр, хужир, мараа сайрын ёроол дэрсэн шигэнгэ, булаг шандны эргэн тойронд хөглөрч ургана.

**Цэцэглэх ба үрлэх хугацаа:** 5, 6 сард цэцэглэж, 7,8 сард үрлэнэ.

**Үр цуглуулах, хадгалах:** 8, 9 сард үрийг цуглуулж, сэргүүн, харанхуй газар хадгалан.

**Үрийг тариалах, арчлах:** Хавар цэвэрлэж ариутгаад чийгтэй хөрсөнд тарьж, 1-3 хоног тутамд усалж ургуулна.

**Ашиглах боломж:** Ногоон үед нь мал идэхгүй, харин хатсан үедээ малын тэжээлийн ургамал.

### ОДОЙ ХАЙЛАС *Ulmus pumila* L.

**Үндсэн шинж:** Хайлас 12-15 м хүртэл өндөр мод, ишний голч 40-50 см. Залуу хайлас сөөгөрхүү. Навчис гозгой, 2-5 см урт, 1-2 см өргөн, нүцгэн, шовгор үзүүртэй, ирмэгээрээ дан юмуу давхар шүдлэг. Навчлахаас өмнө цэцэглэдэг, цэцэг жижигхэн 5-6 шүдлэгтэй, хонхорхуу ногоовор хүрэн шадар эрхтэнтэй. Дохиур 5-6, шадар эрхтнээс цухуйдаг, үрэвч 1 хоёр салаа амсартай. Жимс нь төвдөө үртэй дүгэриг 1-2 см нимгэн далбанцартай.

**Ургах орчин:** Уул толгодын ам хавцал, сайранд ургана.

**Цэцэглэлт ба үрлэлт:** 4, 5 сард навчлахаасаа өмнө цэцэглэж үрлэнэ. Үр нь унасан даруйдаа ургах чадвартай. Үрээр маш сайн нөхөн төлжинө.

**Үр цуглуулах, хадгалах:** Үр бүрэн боловсорч унах үед нь цуглуулна. Үрийн амьдрах чадвар цөөн хэдэн хоног байdag учраас цуглуулсан даруйдаа үрслүүлж тарина. Хадгалж болохгүй.

**Үрийг тариалах, арчлах:** Бүрэн боловсорсон амьд үрийг буцалгаж хөргөсөн устай саванд 1-2 хонуулахад үрнээс 2 шагаан утаслаг гарна. Ийм үрийг тусгайллан бэлдсэн хөрсөнд 1-2 см гүн ховил татаж мөрөөр тарина. Мөрөнд хийсэн үрийг хөнгөн элсэрхэг хэсгээр хучиж шүршүүрээр зөвлөн усална. 2-3 хоногийн дараа үр ургана. 1-3 нас хүртэл арчлан ургуулж дараа нь ургах тохиromжтой орчин шилжүүлэн суулгана.

**Ашиглах боломж:** Говийн нөхцөлд ургах чадвартай модлог ургамал учраас хамгаалах зурvas, цэцэрлэгжүүлэлтэд өргөн ашиглана.

## ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

### Зөвлөмж 1. Нутгийн модлог, сөөглөг ургамлын үрийг сонгох

Манай орны говийн бүс нутаг уур амьсгалын хувьд хатуу ширүүн боловч хайлаас, тоорой, заг, жигд, бүйлээс, харгана, зээргэнэ зэрэг ургамал сайн ургаж цэцэглэж үрлэдэг. Нутгийн хүмүүс эдгээр ургамлыг үрээр тарьж ургуулсан баагүй туршлага бий.

#### Одой хайлаас (*Ulmus pumila L.*)

Навчлахаасаа өмнө цэцэглэж үрлэдэг 12-15 м өндөр мод. Үр нь боловсорч унасан даруйдаа ургах чадвартай. Газар унасан болон боловсорсон үрийг модноос түүж тэр даруйдаа үрслүүлж тариан. Нэг модноос хэдэн арван кг үр түүж болно. Үрийг дараа жил тарихаар хадгалж болохгүй.

Монгол бүйлээс (*Amygdalus mongolica Maxim.*) 8-р сарын дунд үеэс сайн боловсорсон самаран үрийг түүж хуурай сэргүүн газар хадгалан. Хавар самрын ясыг бага зэрэг ан цав гаргаж тарьвал хурдан ургана.

#### Харгана (*Caragana sp.*)

Манай оронд олон зүйл ургана. Хавар эрт бас намар дахин цэцэглэнэ. Харганы үрийг зуны дундуур буурцагтай нь хамт түүнэ. Үр боловсорч эхлэх үеэр буурцаг өөрөө ханзарч үр чөлөөлөгднө. Ямар ч харганы үр хавар үрлүүрээр сайн ургана.

#### Морин зээргэнэ (*Ephedra equisetina Bge.*)

Бөөн бөөн бут үүсгэж ургадаг сөөгөнцөр. 6-р сард цэцэглэж 7-8 сард шүүслэг улаан жимс үүсгэнэ. Шүүслэг жимсний дотор хэд хэдэн хар хүрэн өнгийн үр үүснэ. Үр хавар үрлүүлэн тарихад хялбархан ургана. Говийн нөхцөлд зохицсон олон наст ургамал учраас цаашдаа усалгаа шаардахгүй ургана.

## Зөвлөмж 2. Нөхөн сэргээлтэнд олон үр өгдөг ургамлыг сонгох

Ургамал бүр цэцэглэж үрлэхдээ тодорхой тооны үр, жимс бүрдүүлдэг. Нөхөн сэргээлтэнд их талбайг хамарч ургамалжуулах ажил явагдах учраас аль болох олон үр өгдөг ургамлыг сонгох ач холбогдолтой. Говь нутагт ургадаг цахилдаг, хоног будаа, таана зэрэг ургамал арвин үр өгдөг. Ийм ургамлыг сонгох нь үр цуглуулах ажлыг хөнгөвчилнө.

Бунгийн цахилдаг (*Iris bungei Maxim.*)

Олон наст дэгнүүл үүсгэдэг ургамал. Хавар эрт цэцэглэж, 8-р сард үр боловсорч хонхорцог ханзрах үеэр үрийг түүнэ. Нэг хонхорцогт олон тооны үр боловсorno.

Ногоон хоногбуудаа (*Setaria viridis (L.) Beauv.*)

Нэг наст өвслөг ургамал, малчид үнэгэн сүүл, хоног гэх зэргээр нэрлэнэ. Түрүү баг цэцэгт маш олон тооны үр үснэ. Дээр үеэс түүнийг түүж хуурч тээрэмдэж хэрэглэдэг байжээ. Үр нь ургах чадвар сайтай, өтгөн дэгнүүл үүсгэнэ.

Таана (*Allium polyrrhizum Turcz.et Rgl.*)

Үндэс өтгөн сахлаг дэгнүүл үүсгэдэг 10-25 см өндөр олон наст өвслөг ургамал. Таанын толгой баг цэцэг дээр олон тооны гялалзсан хар бараан үр үүсдэг. Үр нь тохиромжтой орчинд хурдан ургах чадвартай. Таана болон сонгины төрлийн бусад ургамлууд нь үрээрээ сайн нөхөн төлждөг онцлогтой.

## Зөвлөмж 3. Говийн зарим ургамлын ногоон мөчрийн үржүүлэг хийх

Манай орны говь цөлийн нөхцөлд сайн дасан зохицож ургадаг хайлаас, сухай зэрэг ургамал нь мөчрөөрөө үржих чадвартайг харгалzan байгаль дахь бүлгэмдлийнх нь орчинд үржүүлэг хийж нөхөн сэргээлтэд хувь нэмэр оруулах боломж бий.

Сухай (*Tamarix ramosissima Ldb.*)

Олон салаа мөчиртэй 2-3 м өндөр олон наст сөөг ургамал. Хавар эрт, намар орой залуу найлзуурыг 30-50 см урттай тайрч тусгайлан бэлдсэн элсэрхэг хөрсөнд ногоон мөчрөөр үржүүлж болно.


Бургас (*Salix sp.*)

Бургас нь мөчрөөрөө үржих чадвар сайтай. Иймд баян бүрдийг түшиглэн бургасыг мөчрөөр үржүүлэн ургамалжуулах, төгөл байгуулах бий болгох боломж байгаа нь харагдаж байна.


#### Зөвлөмж 4. Нөхөн сэргээлтийн эхний жилийн үр дүнг харгалzan үзэх

Нөхөн сэргээлтэд хэд хэдэн ургамлыг тарьж туршсан бол энэ намрын байдлаар чухам ямар ургамлын ургацын амьдрах чадвар, өсөлт хөгжилт нь сайн байгаад үнэлгээ өгөх учиртай. Усалгаа ямар байсан, агаарын ерөнхий температур ямар байсан зэрэгт мэргэжлийн үүднээс дүгнэлт хийж зөвлөгөө сургамж авах хэрэгтэй. Дараа жилийн нөхөн сэргээлтэд дээрх ургамлуудыг үргэлжлүүлэн үрээр тарьж турших, эсвэл ногоон мөчрөөр үржүүлэхийн аль нь илүү үр дүнтэйг дүгнэн хэлэлцэх учиртай. Гэхдээ тухайн ургамал нь байгалийн ямар нөхцөлд ургаж байгааг анхаарч үзэх шаардлагатай. Усалж арчлахгүйгээр орхивол байгальдаа амьдарч чадаж байвал нөхөн сэргээлт амжилттай болж байна гэж үзэх хэрэгтэй.


#### АДААЦАГ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## БАЯНЖАРГАЛАН СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ГОВЬ УГТААЛ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




### ГУРВАН САЙХАН СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




### ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ДЭЛГЭРЦӨГТ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ДЭРЭН СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ЛУУС СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ӨЛЗИЙТ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ӨНДӨРШИЛ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




### САЙНЦАГААН СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




### САЙХАН ОВОО СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ




## ХУЛД СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ



## ЦАГААН ДЭЛГЭР СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ



**ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН УРГАМЛЫН БҮЛГЭМДЭЛ**

## АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. Байгалийн ургамлын тухай хууль. УБ. 1995.
2. Грубов В.И. Определитель сосудистых растений Монголии. “Наука” Л. 1982. 441.
3. Губанов И.А. Конспект флоры Внешней Монголии (Сосудистые растений). М. 1996. 136 стр.
4. Губанов И.А. Критика растительный ресурсы. Т. XXIII. Вып. 2. М. 1987. с. 312.
5. Дикорастущие полезные растения флоры Монгольской Народной Республики.// Биологические ресурсы и природные условия Монгольской Народной Республики. Том XXIII. Изд. “Наука”. Л. 1985. 235.
6. Кормботаническая карта МНР, (1: 1000000 ) 1981 он
7. Лигаа У. Монголын орны эмийн ургамлыг өрнө, дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. 2006. 652.
8. Лигаа У., Очирбат Г. Угсаатны ургамал судлалын толь. УБ. 2005.108.
9. Мөнхжаргал Б., Цэцэгмаа Ч. Хэнтийн эмийн ургамал. УБ. 2005. 76.
10. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах, Улаанбаатар, 2003,
11. Монгол орны ашигт ургамлын зурагт лавлах, Улаанбаатар, 2005,
12. Монголын Улаан Ном. УБ. 2-р хэвлэл. 1997.
13. Монголын Улаан Ном. УБ. 3-р хэвлэл. 2014.
14. Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. УБ. 2012.
15. Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсран, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж.Е.М. Баиллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). *Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл*. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль (Монгол, Англи хэлээр).
16. Очирбат Г., Мөнхжаргал Б., Суран Д. Зарим ашигт ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ. УБ. 2009. 31.
17. Өлзийхутаг Н. БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг. УБ. 1985. 555.
18. Өлзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ. 1989.
19. Өлзийхутаг Н. Бобовые Монголии. УБ. 2004.
20. Түвшинтогтох И., Монгол орны хээрийн ургамалжил. УБ. 2014.